



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2014

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Эдийн засгийг тогтворжуулах, улмаар зөөлөн газардуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг Монголбанк хоёр дахь жилдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал 2013-2014 онд хадгалагдан, инфляцийн бүтэц ба хандлага, өрхийн зардлын бүтцэд эерэг өөрчлөлтүүд гарч, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, нийт эдийн засагт шаардлагатай тохиргоонууд хийгдлээ.

Дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өсөх мөчлөг үндсэндээ дуусгавар болж, Монгол Улсын экспортын 78 орчим хувийг бүрдүүлдэг нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, цайр зэрэг ашигт малтмалын үнэ гадаад зах зээлд сүүлийн хоёр жилийн дотор 13-70 хүртэл хувиар буураад байна. Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2011-2012 онд нийлбэр дүнгээр 9.0 тэрбум ам.долларт хүрч, нэг жилд ногдох ГШХО-ын дундаж хэмжээ нь мөн хугацаанд ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлж байсан бол 2014 онд ГШХО ердөө 276 сая ам.доллар болж ДНБ-ий 2 хувьтай тэнцэх түвшин рүү огцом буурчээ. Хятадын эдийн засгийн өсөлт үргэлжлэн удааширч, уул уурхайн түүхий эдийн гадаад эрэлт эрс бууран, хөрөнгийн урсгал хөгжингүй орнуудыг чиглэж, Хятад улс болон хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад хийх хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурах сөрөг хандлага 2014 онд ч үргэлжиллээ. АНУ-ын Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын нөлөөгөөр ам.долларын ханш дэлхийн бусад валютын эсрэг чангарсан нь төлбөрийн тэнцлийн хүндрэл бүхий орнуудын үндэсний валютын ханш болон гадаад валютын нөөцөд нэмэлт ачаалал, сөрөг нөлөөллүүд бий болгосоор байна.

Ийнхүү гадаад орчны нөхцөл байдал туйлын таагүй, тодорхой бус байдал удаан үргэлжилсэн, Монгол Улсыг чиглэх хөрөнгийн урсгал үлэмж хэмжээгээр татарсан хэдий ч, гадаад секторын дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх, эдийн засагт шаардлагатай тохиргоог алгуур хийлгэх, үүссэн нөхцөл байдалд өрх гэр, хувийн хэвшил, улсын сектор, эдийн засгийн бусад оролцогчдод дасан зохицоход шаардлагатай цаг хугацааны боломжийг нь олгох, эдийн засгийг зөөлөн газардуулах макро бодлогын сонголтыг 2012 оны 4 дүгээр улиралд хийсний үр дүнд эдийн засагт дараах эерэг нөлөөллүүд бий болоод байна. Үүнд:

- Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн үр дүнд инфляцийн бүтцэд зарчмын эерэг өөрчлөлт гарч, 2010-2012 онд нийлүүлэлтийн гаралтай инфляци нийт инфляцийн 1/3-ийг бүрдүүлдэг байсан бол 2014 онд 1/20 болж буурснаар хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх жилийн инфляци 2 жилийн дотор 14.0 хувиас 11.0 хувь болж буурч, улмаар 2015 оноос эхлэн инфляцийн зорилтот 7 хувийн түвшинг хангах суурь нөхцөл бүрдэв.
- Инфляцийн бүтцэд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт ийнхүү арилж, мах, 1 дүгээр гурил, шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байснаар бага, дундаж орлоготой өрхийн бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлсэн. Үүний зэрэгцээ Монголбанк анх хөтөлбөрийг эхлүүлэхдээ төлөвлөж байсны дагуу хөтөлбөрүүдээс үе шаттай гарч, арга хэрэгслийг зах зээлийн зарчимд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлсэн. Цаашид Монголбанкны оролцоогүйгээр,

Засгийн газраас хувийн хэвшилтэй хамтран мах, гурил, шатахуун зэрэг иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа бүтээгдэхүүний агуулах дахь нөөцийг банкны зээлээр санхүүжүүлэх, ингэснээр эдгээр бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах тогтолцоог бий болголоо.

- Монгол Улсын гадаад худалдаа 2014 онд 2006 оноос хойшхи хугацаанд анх удаа тэнцвэржиж, 538 сая ам.долларын ашигтай гарч, гадаад худалдааны тэнцэл 2011-2013 оны дундаж түвшинтэй харьцуулахад 2.6 тэрбум ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй болов. Үүнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг Монголбанк тууштай баримталж, төлбөрийн тэнцэл 2013 онд 1.9 тэрбум ам.долларын алдагдалтай байх үед нь эдийн засагт үүссэн нөхцөл байдалтай нийцтэйгээр ханш сулрах хандлагыг хүлээн зөвшөөрч, ханшийн тохиргоог алгуур хийсэн нь чухлаар нөлөөлсөн. Гадаад худалдаа тэнцвэржсэнээр төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2011-2013 оны дундаж 3.1 тэрбум ам.доллар (ДНБ-ий -26 хувь)-аас 2014 онд 1.4 тэрбум ам.доллар (ДНБ-ий 11 хувь) болж буурснаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, гадаад валютын улсын нөөц дэх суурь дарамт 2013 онтой харьцуулахад мэдэгдэхүйц буураад байна.
- Эдийн засаг богино хугацаанд огцом агших, хөдөлмөрийн зах зээл дэх нийт ажлын байрны 20 хувийг алдах, санхүү-эдийн засаг-нийгмийн гурвалсан хямрал бий болох эрсдэлээс 2013-2014 онд урьдчилан сэргийлж, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангалаа. Төлбөрийн тэнцлийн огцом цочрол, хүндрэлийн үед хөдөө аж ахуй, барилга угсралт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа зэрэг уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжсэнээр ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.6 хувь, 2014 онд 7.8 хувьтай гарахад эергээр нөлөөлөв.
- Ажилгүй иргэдийн тоо 2013 онд 180 гаруй мянган хүнээр нэмэгдэх байсан эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажилгүйдлийн түвшинг огцом нэмэгдүүлэхгүй байлгах, 2013-2014 онд барилгын салбарт ажиллагсдын тоо 15.3 мянгаар өсч 77 мянгад, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо 10.1 мянгаар өсч 70 мянгад тус тус хүрэх, нийт ажиллагсдын тоо 2013 онд 20,024 хүнээр, 2014 онд 2479 хүнээр тус тус нэмэгдэхэд эергээр нөлөөлөв.
- Санхүүгийн салбарт зээл тасалдах, активын чанар огцом муудах, банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдах, дотоод активууд үнэгүйдэх, системийн шинжтэй тогтворгүй байдал үүсэх эрсдэлээс 2013-2014 оны туршид урьдчилан сэргийлж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалаа. 2014 оны эцэст банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүд зохистой харьцааны шаардлагаас харгалзан 5.7 нэгж хувь, 16.2 нэгж хувиар өндөр байв. Мөн банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь системийн хэмжээнд 5.0 хувь, татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкныг хассанаар 3.1 хувьтай тэнцүү буюу тогтвортой түвшинд байлаа.
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийн нөлөөгөөр өрхийн зардлын бүтцэд зарчмын эерэг өөрчлөлт гарч, дундаж давхаргын хуримтлал өсөн нэмэгдэж байна. 2011-2012 онд сар бүр дунджаар 80 тэрбум төгрөг иргэдийн хэрэглээ байдлаар зарцуулагдаж байсан бол 2013-2014 онд сард дунджаар 23 тэрбум төгрөг орон сууцны ипотекийн зээлийн төлбөр хэлбэрээр банкинд төвлөрч, энэ хэмжээгээр иргэдийн хуримтлал нэмэгдэж байна. 2014 оны эцэст орон сууцны ипотекийн зээлтэй өрхийн тоо 66.3 мянгад, нийт зээлийн хэмжээ 2.84 их наяд төгрөгт хүрч, 2012 оны эцэстэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 2.2 дахин, зээлийн хэмжээ 3.4 дахин өсчээ.
- 2013-2014 оны төлбөрийн тэнцлийн хүндрэлийн сөрөг нөлөөллийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханш, гадаад валютын улсын нөөцийн аль алинаар дамжуулж зөөлрүүлснээр гадаад валютын улсын нөөц 2014 оны 5 дугаар сараас


хойши хугацаанд 1.3-1.6 тэрбум ам.долларын хооронд тогтворжиж, 2014 оны эцэст 1650 сая ам.доллар байсан нь 4.9 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд буюу олон улсын жишиг доод түвшнээс өндөр хэвээр байлаа. Мөн Хятадын ардын банхтай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн хугацааг сунгаж, хэмжээг нь 15 тэрбум юань болгож нэмэгдүүлсэн нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, хоёр орны хоорондох гадаад худалдааг санхүүжүүлэх, санхүүгийн салбарт гадаад валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг муутгахгүй байхад тус тус чухал дэм боллоо.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2014 оны 2 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 10.5 хувьд өөрчлөлгүй хэвээр үлдээх, олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан нь эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, ингэснээр макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихэд эергээр нөлөөлсөн. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурч байгаа хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй, гадаад валютын орох урсгал болон төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээний үр дүн хангалттай бус байсан учраас Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 7 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12 хувь болгох шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэр нь инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогод ирэх ачааллыг бууруулах зорилго бүхий, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээ байлаа.

Ийнхүү Монголбанк мөнгөний уламжлалт бус бодлогоор эдийн засгийг зөөлөн газардуулж, 2012 оны сүүл үеэс эхлэн хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн арга механизмыг зах зээлийн зарчимд шилжүүлэн, хөтөлбөрөөс үе шаттай гарахын зэрэгцээ мөнгөний бодлогын төлөвийг макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд 2014 оны 2 дугаар хагасаас эхлэн өөрчилж, микро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг хослуулан ашигласнаар санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, болзошгүй байсан эрсдэлээс сэргийлэв.

2014 онд банкны салбарын нийт актив 8.1 хувиар өсч 22.6 их наяд төгрөгт, зээлийн өрийн үлдэгдэл 16.1 хувиар өсч 12.5 их наяд төгрөгт, нийт харилцах ба хадгаламжийн хэмжээ 14.2 хувиар өсч 10.1 их наяд төгрөгт, банкуудын өөрийн хөрөнгө 54.5 хувиар өсч 2.1 их наяд төгрөгт тус тус хүрлээ. Өмнөх 2013 онтой харьцуулахад Монгол Улсын төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо 11.5 хувиар, гүйлгээний дүн 16.3 хувиар тус тус өссөн байна.


Монголбанкны мөнгөний бодлого нь 2015-2016 онд макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангаж, инфляцийг зорилтот 7 хувийн түвшинд нь байлган, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж бэхжүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэх болно.



Н.ЗОЛЖАРГАЛ

Монголбанкны Ерөнхийлөгч

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	9
1.1 Бодит сектор	9
1.2 Гадаад сектор	12
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	19
1.4 Улсын төсөв	35
2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ	37
2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн	37
2.2 Санхүүгийн тогтвортой байдал	49
2.3 Валютын бодлого	55
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	60
2.5 Төлбөр тооцооны систем	61
2.6 Банкны хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт	64
3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ	
ҮЙЛ АЖИЛЛАГАА	67
3.1 Төв банкны үнэт цаас	67
3.2 Төв банкны санхүүжилт	67
3.3 Засгийн газрын үнэт цаас	68
3.4 Гадаад валютын дуудлага худалдаа	69
3.5 Дотоодын зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа	71
4. ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ	
ТОГТВОРЖУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР	73
4.1 Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах	
дэд хөтөлбөр (SIES)-ийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж	74
4.2 Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг	
бууруулах дэд хөтөлбөр (TLF)-ийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж	78
4.3 Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах	
дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж	81
4.4 Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг	
тогтворжуулах дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж	83
4.5 Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний	
салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ,	
тарифыг тогтворжуулах дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж	84
5. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	85
5.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт	85

5.2 Олон нийттэй харилцах харилцаа	85
5.3 Гадаад харилцаа	87
5.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагаа	88
5.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	90
5.6 Бэлэн мөнгөний хангалт	91
5.7 Мэдээллийн технологи	92
5.8 Монголбанкнаас 2014 онд хэрэгжүүлсэн бодлого, техникийн арга хэмжээний хураангуй	92
6. АУДИТЫН ТАЙЛАН	97
7. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	197

1.1 Бодит сектор


ДНБ-ий бодит өсөлт

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2014 онд 7.8% болж, өсөлтийн хурдац нь 2013 оны гүйцэтгэлээс 3.8 нэгж хувиар саарсан үзүүлэлттэй гарлаа. Эдийн засгийн бодит өсөлтөд хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын үзүүлэх хувь нэмэр харьцангуй тогтвортой хадгалагдаж, эерэг нөлөө үзүүлж байгаа бол улсын төсвийн нөлөөлөл буюу бүтээгдэхүүний цэвэр татварын бодит өөрчлөлт 2014 оны 2 дугаар улирлаас эхлэн сөрөг утгатай болсон нь ДНБ-ий бодит өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөтэй байв.


2014 оны эцсийн байдлаар ДНБ-ий 7.8%-ийн бодит өсөлтийг задаргаагаар нь, 2010 оны зэрэгцүүлсэн үнээр авч үзвэл уул уурхайн салбар 3.9 нэгж хувийг, хөдөө аж ахуйн салбар 1.6 нэгж хувийг, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 0.3 нэгж хувийг, үйлчилгээ 2.0 нэгж хувийг, тээвэр ба агуулахын салбар 0.8 нэгж хувийг, худалдаа 0.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн бол бүтээгдэхүүний цэвэр татвар -1.1 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ. Эдийн засгийн өсөлтөд уул уурхай, үйлчилгээний салбарын эзлэх хувь 2013 онтой харьцуулахад өсч, харин барилга, худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хөдөө аж ахуй, уул уурхайгаас бусад аж үйлдвэрлэл, үйлчилгээний салбар голлох нөлөөтэй байв.

Салбар бүрийн үйлдвэрлэлийн жилийн бодит өсөлтөөр нь авч үзвэл 2014 онд уул уурхайн салбар 19.1%, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 14.1%, хөдөө аж ахуйн салбар 13.7%, үйлчилгээний салбар 10.3%, мэдээлэл, холбооны салбар 7.3%, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 4.6%-ийн бодит өсөлттэй гарсан байна. Харин бүтээгдэхүүний цэвэр татвар 2013 оноос -8.1%-иар буурчээ.

Зураг 1. ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлэх хувь нэмэр




Зураг 2. ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа



Эх сурвалжууд: Үндэсний статистикийн хороо


Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий задаргаанаас харахад нийт хөрөнгө оруулалт 2014 онд эрс багассан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Харин эцсийн хэрэглээ харьцангуй тогтвортой түвшинд байж, 2009 оны эдийн засгийн хямралын үеийнх шиг агшаагүй байна. Гадаад худалдааны тэнцэл 2014 онд 538 сая ам.долларын ашигтай гарснаар цэвэр экспорт ДНБ-ий бодит өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.

Зураг 3. ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа (эцсийн ашиглалтаар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 4. ДНБ-ий бодит өсөлт (санхүүжилтийн төрлөөр)



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

ДНБ-ий бодит өсөлтийг банкны салбарын зээл, улсын төсвийн зардал, Хөгжлийн банкны зарцуулалт гэсэн санхүүжилтийн төрлөөр нь болон бусад хүчин зүйлийн нөлөөлөл гэсэн хувьсагчдаас хамааруулж үнэлэхэд 2013 оны 11.6%-ийн өсөлтийн 9.9 нэгж хувийг банкны салбарын зээл (5.0 нэгж хувь) болон бусад хүчин зүйлийн нөлөөлөл (4.9 нэгж хувь), 1.8 нэгж хувийг Хөгжлийн банкны зарцуулалт болон улсын төсвийн зардал тус тус бүрдүүлжээ. Харин 2014 оны дунд үеэс эхлэн макро бодлогын өөрчлөлтийг эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах чиглэлд өөрчилсөнтэй уялдан ДНБ-ий 7.8%-ийн бодит өсөлтийн 7.1 нэгж хувийг банкны салбарын зээл (1.7 нэгж хувь) болон бусад хүчин зүйлийн нөлөөлөл (5.4 нэгж хувь), 0.7 нэгж хувийг улсын төсөв болон Хөгжлийн банкны зарцуулалт тус тус бүрдүүлсэн гэсэн тооцоо гарч байна.

Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн насны хүн амын тоо өмнөх оноос 1.3%-иар өсч, 2014 оны эцсийн байдлаар 1870.2 мянгад хүрсэн байна. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу нийт ажиллах хүч 60.3%-ийг эзэлж байгаа бөгөөд ажиллах хүчний оролцооны түвшин 2013 оноос 0.6 нэгж хувиар буурчээ. Харин нийт ажилчдын тоо 2013 оноос 2.5 мянгаар өсч 1040.7 мянгад хүрсэн бол нийт ажилгүйчүүдийн тоо 87.0 мянгаар буурч, ажилгүйдлийн түвшин 7.7% болжээ.

Зураг 5. Ажиллах хүчний оролцооны түвшин¹

Зураг 6. Ажилгүйдлийн түвшин




¹ Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт хөдөлмөрийн насны (15-аас дээш) хүний тоонд эзлэх хувь хэмжээ.

Зураг 7. Ажилчдын тоо
(эдийн засгийн голлох салбараар)



Зураг 8. Ажилчдын тоо
(хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр)



Зураг 9. Аж үйлдвэрийн салбарын ажиллагсад



Эх сурвалжууд: Үндэсний статистикийн хороо

Нийт ажилчдын тоог эдийн засгийн гол салбаруудын ангиллаар авч үзвэл 2014 онд 297.5 мянга буюу 28.7% нь ХАА-н салбарт, 218.7 мянга буюу 21.1% нь аж үйлдвэрлэлд, 524.5 мянга буюу 50.5% нь үйлчилгээний салбарт тус тус ажиллаж байна. Нийт ажилчдыг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр авч үзвэл 513.8 мянга буюу 49.4% нь цалин хөлстэй ажилчид, 16.4 мянга буюу 1.6% нь ажил олгогч байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид 212.5 мянга буюу 20.4%, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд тогтсон цалин

хөлсгүй оролцогч 29.7 мянга буюу 2.9%-ийг эзэлж байна. МАА эрхлэгчид 266.8 мянга буюу нийт ажилчдын 25.6%-ийг бүрдүүлж байна.


Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 2014 онд 2.0%-иар буурч 71.6 мянгад хүрсэн байна. Үүнээс 30.9 мянга буюу 43.2%-ийг боловсруулах аж үйлдвэр, 25.3 мянга буюу 35.3%-ийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 15.4 мянга буюу 21.5%-ийг усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлд хөдөлмөр эрхэлж буй ажилчид тус тус бүрдүүлж байна.

1.2 Гадаад сектор


Төлбөрийн тэнцэл

2014 онд төлбөрийн тэнцлийн урсгал данс -1405 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 1062 сая ам.долларын ашигтай, статистикийн алдаа ба орхигдуулга -128 сая ам.долларын дүнтэй гарснаар төлбөрийн нийт тэнцэл -471 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ 2013 оноос 1396 сая ам.доллараар буюу 4 дахин буурсан үзүүлэлттэй гарав.

Зураг 10. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл




Зураг 11. Төлбөрийн урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалжууд: Монголбанк

Урсгал тэнцлийн алдагдал 2014 онд өмнөх оноос 1787 сая ам.доллараар буюу 56%-иар буурчээ. Үүнд барааны гадаад худалдаа 2014 оноос тэнцвэржиж, тэнцэл нь F.O.B. нөхцөлөөр 2013 оны -1321 сая ам.долларын алдагдлаас 2014 онд 994 сая ам.долларын ашигтай гарч, 2314 сая ам.доллараар сайжирсан нь гол нөлөөг үзүүлсэн. Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2011-2012 онд дунджаар -27% байсан бол 2013 онд -25%, 2014 онд -11.6% болж буураад байна.

Зураг 12. Хөрөнгө ба санхүүгийн дансны бүтэц



Зураг 13. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц



Эх сурвалжууд: Монголбанк

2014 онд хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны мөн үеэс 26%-иар буюу 376 сая ам.доллараар буурч 1062 сая ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 7.6 дахин буюу 1822 сая ам.доллараар буурч 276 сая ам.доллар болж, ДНБ-ий 2%-тай тэнцэх түвшинд хүрснээр голлон тайлбарлагдана.

Барааны гадаад худалдаа

Хүснэгт 1. Барааны гадаад худалдаа

	Эхний 12 сар			Өөрчлөлт 2014/2013	
	2014	2013	2012	Мөнгөн дүн	Хувь
Эргэлт	11 010	10 626	11 122	384	3.6%
Экспорт	5 774	4 269	4 384	1 505	35.3%
Импорт	5 236	6 357	6 738	-1 121	-17.6%
Тэнцэл	538	-2 088	-2 354	2 626	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдаа тэнцвэржихэд экспорт 35%-иар өсч, импорт 18%-иар буурсан нь голлох нөлөөг үзүүлээ. Гадаад худалдааны эргэлт 2014 онд 11,010 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 3.6%-иар нэмэгдсэн байна.


Экспорт: 2014 онд экспорт 35%-иар буюу 1.5 тэрбум ам.доллараар өссөн. Үүнд зэсийн баяжмалын экспорт 1.7 тэрбум ам.доллараар, түүхий нефтийн экспорт 119 сая ам.доллараар, алтны экспорт 95 сая ам.доллараар, угаасан ноолуурын экспорт 36 сая.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн. Хэдийгээр зэсийн баяжмал болон түүхий нефтийн экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан нийт экспорт өссөн ч, дэлхийн зах зээлд түүхий эдийн эрэлт багасч, үнэ буурсаар байсан нь экспортыг бууруулах нөлөө үзүүлж байв.

Алтны үнэ: EIU судалгааны байгууллагын дүгнэлтээр 2014 онд үнэт эдлэл, үйлдвэрлэлийн орц болон хөрөнгө оруулалтын хэрэгсэл байдлаар ашиглагдах алтны эрэлт буурсан. АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний тэлэх бодлогыг хумьж, бодлогын төлвийг чангаруулах чиглэлд өөрчлөх төлөвтэй болсон нь ам.долларын ханш чангарахад нөлөөлж, алтанд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бууруулах нөлөө үзүүлсэн. Ингэснээр алтны үнийн индекс 2014 онд 1.4%-иар буурсан бөгөөд цаашид ч үргэлжлэн буурах хандлагатай болов.

Зэсийн үнэ: 2014 онд АНУ-аас бусад хөгжингүй орнууд болон БНХАУ-ын эдийн засаг төдийлөн сэргээгүй тул аж үйлдвэрлэл суларч, суурь металлын эрэлт буурсан. Блүмберг агентлагийн мэдээллээр дэлхийн зэсийн нийлүүлэлт 2013 онд 6.7%, 2014 онд 7.5%-иар өссөнөөс зэсийн зах зээлд илүүдэл үүссэн. Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан Лондонгийн металлын бирж дэх цэвэршүүлсэн зэсийн үнэ өмнөх оноос 14.0%-иар буурчээ.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 1990 оноос хойшхи хугацаанд 1994, 1995, 2006, 2014 онуудад л ашигтай, бусад үед алдагдалтай гарч байв. Тайлант 2014 онд гадаад худалдааны тэнцэл 538 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 2627 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй болов.

Зураг 14. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2012 оны 12 дугаар сар = 100)



Эх сурвалж: Блүмберг

Хүснэгт 2. Экспорт (голлох бүтээгдэхүүнээр)

	2014		2013		Өөрчлөлт	
	Тоо хэмжээ	Сая \$US	Тоо хэмжээ	Сая \$US	Сая \$US	%
1. Ашигт малтмал		5,129		3,777	1,352	36%
Чулуун нүүрс (мян.тн)	19 481	849	18 194	1 116	(268)	-24%
Зэсийн баяжмал (мян.тн)	1 378	2 574	650	949	1 625	171%
Төмрийн хүдэр/баяж. (мян.тн)	6 324	446	6 724	654	(208)	-32%
Боловсруулаагүй нефть (мян.тн)	6 885	635	5 244	515	119	23%
Цайрын хүдэр ба баяж. (мян.тн)	99	113	131	119	(6)	-5%
Алт (кг)	10 041	405	7 559	310	95	31%
Жонш, лейцит, нефелинт (мян.тн)	314	72	338	83	(12)	-14%
Молибдений хүдэр/баяж. (мян.тн)	4	36	4	29	6	21%
2. Ноос, ноолуур (тн)		286		2459	41	17%
Ямааны угаа. ноолуур (тн)	4 035	224	4 070	189	35	19%
Ямааны сам. ноолуур (тн)	637	62	564	56	6	10%
3. Бусад		360		248	112	45%
Нийт дүн		5 775		4 269	1 506	35%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Коксжих нүүрсний үнэ: БНХАУ-ын гадаад, дотоод нийлүүлэлт өндөр, гангийн үйлдвэрлэлээр тодорхойлогдох коксжих нүүрсний эрэлт буурснаас Mcloskey агентлагаас гаргадаг коксжих нүүрсний үнийн индекс 2014 оны эцэст өмнөх оноос 41.1%-иар буурлаа.

Төмрийн хүдрийн үнэ: Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, аж үйлдвэрлэлийн өсөлт суларсан хандлага үргэлжилж буй сөрөг орчинд төмрийн хүдрийн үнэ 2014 онд 49.3%-иар буураад байна.

Түүхий нефтийн үнэ: Боловсруулаагүй нефтийн үнэ 2014 онд 41.9%-иар буурсан нь дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн удаашрал, тодорхой бус байдлаас гадна геополитикийн буюу ОХУ-ын эсрэг барууны орнуудын тавьсан хориг, түүний нөлөөлөлтэй шууд холбоотой байв.

2014 онд чулуун нүүрс, зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, алт, ямааны самнасан ноолуурын экспорт тоо хэмжээгээрээ өссөн бол төмрийн хүдэр, цайрын хүдэр ба баяжмал, жоншны экспорт тоо хэмжээгээрээ буурсан үзүүлэлттэй гарав. Экспорт мөнгөн дүгээр 1.5 тэрбум ам.доллараар өсөхөд зэсийн баяжмалын экспорт 1.6 тэрбум ам.доллараар, боловсруулаагүй нефтийн экспорт 119 сая ам.доллараар, алтны экспорт 95 сая ам.доллараар, ноолуурын экспорт 41 сая ам.доллараар тус тус өссөн нь эергээр нөлөөлжээ. Харин чулуун нүүрс, төмрийн хүдэр, цайрын хүдэр ба баяжмал, жоншны экспорт мөнгөн дүнгээр нийтдээ 493 сая ам.доллараар буурсан байна.

Хүснэгт 3. Импорт (голлох ангиллаар)

	2014		2013		Өөрчлөлт	
	Сая \$US	%	Сая \$US	%	Сая \$US	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	1 379	26%	1 526	24%	(147)	-10%
Түргэн эдэлгээтэй	764	15%	780	12%	(17)	-2%
Хүнс	531	10%	559	9%	(27)	-5%
Эм, тариа	82	2%	77	1%	5	6%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	151	3%	145	2%	6	4%
Удаан эдэлгээтэй	615	12%	745	12%	(130)	-17%
Гутал, хувцас, цүнх	58	1%	55	1%	3	5%
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба тавилга	137	3%	156	2%	(19)	-12%
Автомашин, түүний сэлбэг хэрэгсэл	348	7%	462	7%	(114)	-25%
Бусад удаан эдэлгээтэй бараа	73	1%	72	1%	1	1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2 098	40%	2 824	44%	(726)	-26%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,114	21%	1,810	28%	(697)	-38%
Барилгын материал	756	14%	748	12%	8	1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	228	4%	266	4%	(38)	-14%
Аж үйлдвэрлэлийн орц	592	11%	595	9%	(4)	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	1 155	22%	1 409	22%	(255)	-18%
Дизель түлш	656	13%	881	14%	(224)	-25%
АИ-92, АИ-95	320	6%	325	5%	(5)	-2%
А-80 болон бусад	178	3%	203	3%	(25)	-12%
Бусад	14	0%	3	0%	10	315%
Нийт дүн	5 237		6 358		(1 121)	-18%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт: 2014 онд импорт 18%-иар буюу 1.1 тэрбум ам.доллараар буурлаа. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв:

- Түргэн эдэлгээтэй хэрэглээний барааны импорт 2%-иар, удаан эдэлгээтэй хэрэглээний барааны импорт 17%-иар буурснаар нийт хэрэглээний барааны импорт 147 сая ам.доллараар буюу 10%-иар буурсан.
- Машин механизм, тоног төхөөрөмж, түүний эд ангийн импорт 38%-иар буурснаар хөрөнгө оруулалтаар голдуу санхүүжигддэг бүтээгдэхүүний импорт 726 сая ам.доллараар буюу 26%-иар буурсан.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 255 сая ам.доллараар буюу 18%-иар буурсан.

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2014 онд өмнөх оноос 18%-иар өсч, 1553 сая ам.доллар болсон.

Барааны импорт буурсантай уялдан тээврийн үйлчилгээний алдагдал 2013 онтой харьцуулахад 33%-иар буурч -458 сая ам.доллар болсон хэдий ч, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал 56%-иар өсч -328 сая ам.доллар, бусад үйлчилгээний алдагдал 82%-иар өсч -767 сая ам.доллар болсон нь үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2014 онд өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлс байв.

Хүснэгт 4. Үйлчилгээний гадаад худалдаа

Дансны нэр	2012	2013	2014	Өөрчлөлт 2014/2013	
				Дүн	%
1. Тээвэр	-894	-683	-458	-225	-33%
2. Аялал жуулчлал	85	-210	-328	118	56%
3. Харилцаа холбоо	-26	-69	-75	6	8%
4. Барилга	-85	-169	-69	-100	-59%
5. Даатгал	-57	-55	-31	-24	-43%
6. Санхүүгийн үйлчилгээ	-30	-31	-99	-69	225%
7. Компьютер, мэдээлэл	-20	-28	-26	-2	-7%
8. Патент, тэмдэг, лицензийн хураамж	-6	-13	-11	-3	-21%
9. Бизнесийн зөвлөх үйлчилгээ	-18	-31	-284	254	826%
10. Бусад үйлчилгээ	-49	-26	-172	147	571%
Нийт үйлчилгээ	-1100.3	-1314	-1553.2	239	18%

Эх сурвалж: Монголбанк

Барилга, угсралтын үйлчилгээний алдагдал 59%-иар буурсан хэдий ч, бизнесийн зөвлөх үйлчилгээ болон санхүүгийн үйлчилгээний гадаад худалдааны алдагдал огцом нэмэгджээ.

Гадаад хөрөнгө оруулалтын позиц (ИР)

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр дүнгээр) 2014 оны эцэст -23,689 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 3437 сая ам.доллар, үүний 48%-ийг гадаад валютын улсын нөөц, 34%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 10%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 8%-ийг багцын хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн 27,127 сая ам.долларт байгаагийн 61%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 28%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36%-ийг буюу 6078 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 64% буюу 10,615 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 5. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2014 оны эцэст (сая ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		3 437	Б. ГАДААД ПАССИВ		27 127
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	355		1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)		16 693
2. Багцын хөрөнгө оруулалт	280		2. Багцын хөрөнгө оруулалт		2 913
3. Санхүүгийн дериватив	9		3. Санхүүгийн дериватив		12
4. Бусад хөрөнгө оруулалт	1 144		4. Бусад хөрөнгө оруулалт		7 508
5. Нөөц актив	1 650				
			В.ПОЗИЦ		-23689

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц (ИР) 2014 онд өмнөх онтой харьцуулахад 16%-иар буюу 3249 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлжээ:

- Гадаад актив 14%-иар буюу 568 сая ам.доллараар буурч, гадаад пассив 11%-иар буюу 2682 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 867 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалт 1231 сая ам.доллар, багцын хөрөнгө оруулалтын позиц 225 сая ам.доллараар өссөн;

Хүснэгт 6. Гадаад хөрөнгө оруулалтын позицийн өөрчлөлт (сая ам.доллар)

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	Өөрчлөлт	
				Дүн	%
ГШХО-ын позиц	-12 267	-15 471	-16 338	867	6%
Багцын ХО-ын позиц	-2 584	-2 083	-2 633	550	26%
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	0	0	-3	-3	
Бусад ХО-ын позиц	-3 495	-5 134	-6 365	1 231	24%
ГВАН-ын үлдэгдэл	4 126	2 248	1 650	-598	-27%
Нийт позиц	-14 219	-20 440	-23 689	-3 249	16%

Эх сурвалж: Монголбанк

- Гадаад валютын улсын нөөц 46%-иар буюу 598 сая ам.доллараар буурсан.

Нийт гадаад өр (улсын болон хувийн хэвшил)

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2014 оны эцэст 20,942 сая ам.доллар болж, өмнөх оноос 10%-иар буюу 1920 сая ам.доллараар өсчээ. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн:

- Хөгжлийн банкны гадаадаас авсан авсан зээл, хувийн хэвшлийн гадаадын банкнаас авсан зээл зэргээс шалтгаалан бусад секторын гадаад өр 2014 онд өмнөх оноос 34%-иар буюу 889 сая ам.доллараар өссөн.

Хүснэгт 7. Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2012	2013	2014	Өөрчлөлт (14'/13')	
				Дүн	Хувь
Нийт гадаад өр	15 386	19 022	20 942	1 920	10%
I. Засгийн газар	3 684	3 684	3 610	-74	-2%
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	30%	29.4%	29.9%	0.5%	
II. Төв банк	415	1 065	1 568	503	47%
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1 074	1 298	1 629	331	26%
Богино хугацаат	58	200	315	115	58%
Урт хугацаат	1 016	1 098	1 314	216	20%
IV. Бусад сектор	1 856	2 633	3 522	889	34%
Богино хугацаат	508	406	562	156	38%
Урт хугацаат	1 348	2 228	2 960	732	33%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	8 357	10 341	10 615	274	3%

Эх сурвалж: Засгийн газрын гадаад өрийн мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк

- Арилжааны банкуудын олон улсын зах зээлд шинээр гаргасан бонд, авсан зээлүүдээс шалтгаалан хадгаламжийн байгууллагын гадаад өр 26% буюу 331 сая ам.доллараар өссөн.
- Компани хоорондын зээллэгээ буюу охин компанийн зүгээс толгой компаниасаа авсан хөрөнгө оруулалт (төлбөрийн тэнцэлд гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж бүртгэгддэг бол гадаад өрийн статистикт хөрөнгө оруулагчаас авсан зээл гэж бүртгэгддэг) 274 сая ам.доллараар буюу 3%-иар өссөн.
- Үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэл болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр Төв банкны гадаад өглөг 503 сая ам.доллараар нэмэгдсэн.

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2012-2014 онуудад 29.4%-30.0% хооронд тогтвортой түвшинд байна (Олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг Бусад сектор хэсэгт ангилсан).

Шигтгээ 1.**Монгол Улсад ажиллаж буй гадаад ажилтнуудын цалингийн судалгаа**

Зорилго: Төлбөрийн тэнцлийн статистик мэдээгээр Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагуудаас эдийн засгийн харьяат бус этгээдэд (гадаад ажилтнууд) 2013 онд 236 сая, 2014 онд 168 сая ам.долларыг цалин хөлс хэлбэрээр олгосноос 68% нь уул уурхай, 12% нь барилга угсралт, үлдсэн 20% нь бусад салбарт ногдож байна. Зам, барилга угсралтын салбарт ажиллаж буй гадаад ажилтнуудад дотоодын компаниудаас төлж буй нийт цалингийн зардал нь төлбөрийн тэнцэлд тусгагдаж буй эсэхийг тодруулах зорилгоор Монголбанк 2014 онд тус судалгааг гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүн: Нийгмийн даатгалд хамрагдсан гадаад ажилтнууд тоо 2013 онд 18,852 байсан бөгөөд уул уурхай, зам, барилгын салбарын ажилтнууд хамгийн их буюу тус бүр 14%-ийг эзэлж байна. Эдгээр ажилтнуудын 35% нь сард 200 мянгаас бага, 52% нь 200 мянгаас 2 сая төгрөгийн цалин авчээ. 200 мянгаас бага цалинтай ажилтнуудын дийлэнх нь зам, барилгын салбарт ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв 2013 онд 1428 компанид нийт 26,109 гадаад ажилтныг Монгол Улсад ажиллуулах зөвшөөрөл олгосон нь нийгмийн даатгалд бүртгүүлж цалин авсан гадаад ажилтны тооноос 38%-иар илүү байна. Энэ нь манай улсад ажиллах зөвшөөрөл урьдчилан авсан ч ирж ажиллаагүй, нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдээллээгүй, дотоодын компаниас цалин авдаггүй гадаадын иргэд Монгол Улсад ажиллах зөвшөөрөл авч байгаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж байна.

Дээр дурдсан нийт зөвшөөрлийн 20%-ийг хамарч буй хамгийн их зөвшөөрөлтэй компаниудаас Монголбанк түүврийн аргаар судалгаа авсан.

Манай улсаас гадаад ажилтнуудад төлж буй дундаж цалингийн хэмжээ нь уул уурхайн салбарт хамгийн өндөр буюу сард 2646 ам.доллар байгаа бол барилгын салбарт харьцангуй бага буюу сард 590 ам.доллар байна.

БНХАУ-ын ажилчид олноор ажилладаг барилга, замын салбарын дундаж цалингийн зардал нь бусад салбаруудтай харьцуулахад бага байгаа нь тухайн салбарын дараах онцлог шинж чанаруудаас хамаарч байна:

- Манай улсын компаниуд БНХАУ-ын компаниудаар барилга угсралтын ажил гүйцэтгүүлэхдээ ажил гүйцэтгүүлсний буюу үйлчилгээ авсны төлбөрийг гадаад гүйлгээгээр, гадаад ажилчдыг илгээсэн гадаад орон дахь компанийн дансанд шилжүүлдэг учраас ажилтан тус бүрт дотоодын компаниас цалин олгодоггүй байна. Харин Хятад ажилтнуудын Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг өөрийн компанийн нэр дээр авч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон нийгмийн даатгалын шимтгэл төлж байдаг ажээ.
- БНХАУ-ын хөрөнгө оруулалттай барилгын компаниудад толгой компаниас нь томилолтоор ирсэн гадаад ажилчид үндсэн цалингаа Монгол улсад авдаггүй, харин толгой компаниасаа өөрсдийн орондоо хүлээн авдаг байна.
- Ихэнх барилгын компаниуд БНХАУ-ын ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхдөө Монголд байх үеийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан сард 200 мянга орчим төгрөгийн цалин олгодог байна.

Хэдийгээр гадаадаас олон тооны барилгын ажилчид Монгол Улсад ирж ажиллах зөвшөөрөл авдаг ч, үндсэн цалингаа өөрсдийн эх орондоо хүлээн авч байна. Өөрөөр хэлбэл манай улсын дотоодын компаниуд тухайн ажилчдын хөдөлмөрийн зардлыг барилгын үйлчилгээний төлбөр хэлбэрээр банкны гадаад гүйлгээгээр шилжүүлж байдаг бөгөөд төлбөрийн тэнцлийн статистикт барилгын үйлчилгээний зардал хэлбэрээр 2013 онд 195 сая ам.доллар, 2014 онд 87 сая ам.долларын төлбөр гадагш төлөгджээ.

Энэхүү судалгааны үр дүнд төлбөрийн тэнцлийн статистик бүртгэлийн үндсэн аргачлал, эх сурвалж болох банкуудын гадаадын гүйлгээний тайлан, томоохон аж ахуйн нэгжүүдийн тайлан, мэдээнд Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудаас эдийн засгийн харьяат бус иргэдэд төлж буй нийт цалингийн мэдээлэл бүрэн хамрагддаг гэсэн дүгнэлтийг хийж байна.

1.3 Мөнгө, санхүүгийн сектор

Инфляци

Монголбанкны үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдлыг хангах буюу инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах явдал юм. Энэ нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх, бодит секторын худалдан авах чадварыг бууруулахгүй байлгах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх зэрэгт зайлшгүй шаардлагатай суурь нөхцөл нь болж байдаг.

2014 онд хэрэглээний үнэ улсын хэмжээнд 11.0%-иар, Улаанбаатар хотод 10.7%-иар өсч, 2013 онтой харьцуулахад жилийн инфляци улсын хэмжээнд 0.9 нэгж хувиар, Улаанбаатар хотод 0.5 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарав. Ийнхүү жилийн инфляци 2014 оны эцэст 11% буюу зорилтот түвшин (8%)-ээс 3 нэгж хувиар өндөр гарахад төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсны инфляци дахь сөрөг нөлөөлөл 2013 оны 2 дугаар хагасаас 2014 оны эхний хагасыг дуусталх хугацаанд хүчтэй байсан нь голлон нөлөөлсөн. Тухайлбал, нийлүүлэлтийн гаралтай инфляци 2013-2014 оны туршид буурч, нам бөгөөд тогтвортой түвшинд байсан хэдий ч, импортын барааны инфляци болон импортын орц өндөртэй дотоодын бусад барааны инфляци 2014 оны эхний хагас жилийг дуусталх хугацаанд өсч байв. Харин 2014 оны сүүлийн хагаст уг өндөр өсөлтийн инерц саарч, нөлөөлөл нь буурсаар инфляцийн түвшин оны сүүлийн саруудад буурах хандлагатай болсон байна. Хэрэглээний сагсны хамгийн их хэлбэлзэлтэй бүтээгдэхүүний нэг болох махны үнийн өсөлт огцом буурсан нь жилийн инфляци буурахад эерэг нөлөө үзүүлсэн. Харин хүнс, шатахуун, төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт нь инфляцийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй байлаа.

18

14

10

6

2

-2

3 6 9 12 3 6 9 12 3 6 9 12

2012 2013 2014

Бусад
Шатахуун
Махнаас бусад хүнс
Төрийн зохицуулалттай үнэ
Мах
Инфляци

107.7


2014 оны 12 дугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (10.7%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн -0.06, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 2.20, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.58, шатахуун 0.07, бусад бараа, үйлчилгээ 6.90 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн жилийн инфляцид эзлэх хувь өмнөх сараас 0.43 нэгж хувиар нэмэгдсэн байна. Тухайлбал, төрийн өмчийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр 7.6%-иар өссөн нь 0.3 нэгж хувийн, орон сууцны усан хангамжийн үнэ 23.0%-иар өссөн нь 0.4 нэгж хувийн, цахилгааны үнэ дунджаар 5.8%-иар өссөн нь 0.1 нэгж хувийн, авто замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ дунджаар 17.7%-иар өссөн нь 0.5 нэгж хувийн буюу нийтдээ 1.4 нэгж хувийн инфляцийг бий болгожээ. Мах, махнаас бусад хүнс, бусад барааны үнийн жилийн инфляцид эзлэх хувь хэмжээ өмнөх сараас харгалзан 0.24, 0.12 болон 1.29 нэгж хувиар тус тус буурчээ. Харин шатахууны үнэ тогтвортой байж, түүний жилийн инфляцид эзлэх хувь хэмжээ өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна.

Гэвч мөнгөний бодлогын төлвийг макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах чиглэлд өөрчилсөнтэй уялдан 2014 оны 2 дугаар хагасаас эхлэн инфляцийн инерц саарч, импортын барааны болон дотоодын бусад барааны инфляци буурах хандлага гарсан. Нөгөө талаар *“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”*-ийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт эрс буурсан тул цаашид 2015 онд инфляци буурч, зорилтот түвшинд хүрэх төсөөлөлтэй байна.

Мөнгөний үзүүлэлтүүд

Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаад валютын урсгал, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт 2014 онд үргэлжлэн буурч, ДНБ-ий 2%-тай тэнцэх хэмжээнд байснаар Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА) 3 дахин буурсан. Гэхдээ МУХБ, Засгийн газрын санхүүжилт, эдийн засгийг зөөлөн газардуулах зорилгоор Монголбанкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөр буюу дотоод эх үүсвэрийн нөлөөгөөр дотоод цэвэр актив (ДЦА)-ын огцом уналтаас сэргийлэн, зээл өсч, ДЦА 44.7%-иар өссөн байна.

Зураг 17. М2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн: актив, пассив



Эх сурвалжууд: Монголбанк


2014 онд мөнгөний нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрийн бүрэлдэхүүн хэсэг буурсан ч, дотоод эх үүсвэр өссөнөөр М2 мөнгөний нийлүүлэлт 12.5%-иар өссөн байна. Банкны салбарын зээлийн жилийн өсөлт 2014 онд 16.1% болж хурдац нь удааширсан бөгөөд үүнд гадаад эх үүсвэрийн бууралт болон дотоод эх үүсвэрийн өсөлт саарсан нь нөлөөлөв.

Пассив талаас нь авч үзвэл М2 мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд бараг мөнгө², үүний дотор валютын харилцахын нөлөө нэмэгдсэн. Харин зээлийн өсөлтөөс шалтгаалан М1 мөнгөний нийлүүлэлт 2013 онд 14.1%-иар өсч, тогтворжих хандлагатай байсан хэдий ч, 2014 онд өсөлтийн хурд нь үргэлжлэн саарсаар М1 мөнгөний нийлүүлэлт 2014 онд -13.2%-иар буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл сүүлийн жилүүдэд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин буурч төгрөгийн харилцах, хадгаламжийн эзлэх хувийн жин нэмэгджээ. 2014 онд өмнөх онтой харьцуулахад төгрөгийн харилцахын эзлэх жин буурч харин валютын харилцах, хадгаламжийн жин өссөн байна. Актив талаас нь авч үзвэл 2010-2012 оны дунджаар М2 мөнгөний нийлүүлэлтэд дотоод цэвэр актив (ДЦА) дунджаар 45%-ийг эзэлдэг байсан бол гадаад цэвэр актив (ГЦА) огцом буурч төлбөрийн тэнцлийн хямрал үүссэн 2013 онд 90%, төлбөрийн тэнцлийн хямралын нөлөөлөл үргэлжилсэн 2014 онд 116%-ийг эзлэх болсон. Өөрөөр хэлбэл 2013 онд Монгол Улсын ГЦА-ын 79%-ийн огцом уналтыг ДЦА-ын 165%-ийн өсөлтөөр, 2014 онд ГЦА 282%-ийн бууралтыг ГЦА-ын 45%-ийн өсөлтөөр тус тус нөхөж, ГЦА-ын огцом бууралтын санхүүгийн салбар, эдийн засаг засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлжээ.

² Төгрөгийн хадгаламж, валютын харилцах, хадгаламжийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Зураг 18. М2 мөнгөний нийлүүлэлтийн бүтэц: актив, пассив



Эх сурвалжууд: Монголбанк


Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Банкны салбарт тайлант оны эцсийн байдлаар нийт 14 банк 1,486 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.7 саяд хүрч, 219.8 мянгаар нэмэгдсэн бол нийт зээлдэгчдийн тоо 803.1 мянгад хүрч, 109.1 мянгаар нэмэгдлээ.

Активын бүтэц, өөрчлөлт


Банкны салбарын нийт активын хэмжээ 2014 оны эцэст 21.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.7%-иар буюу 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Нийт активын 55.8% нь зээл, 20.9% нь мөнгөн хөрөнгө, 9.2% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 7.9% нь урт хугацаат хөрөнгө оруулалт, үлдэх 6.2% нь бусад хөрөнгө байна. Банкны салбарын голлох актив болох нийт зээлийн хэмжээ тайлант оны эцэст татан буугдсан банкууд (Анод, Зоос, Хадгаламж)-ыг хассанаар 12.3 их наяд төгрөгт хүрч, 2013 оноос 18%-иар буюу 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Харин татан буугдсан банкуудыг оруулж тооцсоноор нийт зээлийн өрийн үлдэгдэл 12.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.1%-ийн өсөлттэй байв.

Зураг 19. Нийт активын бүтэц (тэрбум төгрөг)



Эх сурвалжууд: Монголбанк


Зураг 20. Нийт активын жилийн өөрчлөлт (%)



2014 оны эцэст татан буугдсан банкуудыг хассанаар нийт зээлийн 12,262 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийн 94.7% буюу 11,607 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 2.2% буюу 269 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 3.1% буюу 386 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагджээ. Зээлийн чанарыг өмнөх оны эцэстэй харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ

өмнөх оны эцсээс 126 тэрбум төгрөгөөр буюу 49%-иар нэмэгдсэн бол хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 152 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин нэмэгдсэн байна. Харин татан буугдсан банкуудыг оруулж тооцсоноор хугацаа хэтэрсэн зээл 270 тэрбум төгрөг болж 2013 оноос 151 тэрбум төгрөгөөр буюу 2.28 дахин өссөн бол чанаргүй зээл 626 тэрбум төгрөг болж 2013 оноос 60 тэрбум төгрөгөөр буюу 11%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 21. Чанаргүй зээл (тэрбум төгрөг)



Зураг 22. Хугацаа хэтэрсэн зээл (тэрбум төгрөг)



Эх сурвалжууд: Монголбанк

Төгрөгийн зээлийн чанар гадаад валютын зээлийнхтэй харьцуулахад харьцангуй сайн байна. Тухайлбал, 2014 оны эцсийн байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн хувь 2.4%, гадаад валютын чанаргүй зээлийн хувь 6.7% байна. Гадаад валютын чанаргүй зээлийн хэмжээ 2013 оны 6 дугаар сард 3.2% байсан бол 2013 оны эцэст 5.7% болж өссөн бөгөөд 2014 онд 1.0 нэгж хувиар нэмэгдсэн нь төлбөрийн тэнцлийн 2013-2014 оны хүндрэлтэй нөхцөл байдлаас шууд хамааралтай байна.


Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл иргэдэд олгосон хэрэглээний зээл нийт зээлийн 24.4% буюу 2.9 их наяд төгрөг, үл хөдлөх хөрөнгийн салбарт 18.2% буюу 2.2 их наяд төгрөг, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 14.0% буюу 1.7 их наяд төгрөг, барилгын салбарт 13.5% буюу 1.6 их наяд төгрөг, боловсруулах салбарт 10.8% буюу 1.3 их наяд төгрөг, уул уурхайн салбарт 8.2% буюу 1.0 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн чанарын үзүүлэлтээс дүгнэхэд уул уурхай болон бөөний болон жижиглэн худалдааны салбарын чанаргүй зээлийн хувь бусад салбаруудтай харьцуулахад өндөр буюу харгалзан 8.1%, 5.0% байна. Харин үл хөдлөх хөрөнгийн салбар, иргэдэд олгосон хэрэглээний зээлийн чанар харьцангуй сайн буюу эдгээр салбарын чанаргүй зээлийн хувь хэмжээ харгалзан 0.9%, 1.5% байна. Тайлант оны эцэст орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ ердөө 0.4% байгаа нь үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн чанар сайн байхад голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 23. Нийт зээлд эзлэх хувь (салбараар)




Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 24. Зээлийн чанар (салбараар)

**Пассивын бүтэц, өөрчлөлт**

Төлбөрийн тэнцлийн хямралтай 2013 онд Монголбанкнаас эдийн засгийг зөөлөн газардуулах зорилготой мөнгөний уламжлалт бус арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүгийн салбарт эх үүсвэрийн хомсдол үүсэх, зээлийн тасалдал бий болох, системийн шинжтэй тогтворгүй байдал учрах эрсдэлээс сэргийлсэн билээ. Ийнхүү нэг талаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөгөөр, нөгөө талаас харилцах, хадгаламжийн тогтвортой өсөлттэй уялдан банкны салбарын эх үүсвэр 2013 онд 72.4%-иар өсч байсан. Харин 2014 онд банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 19.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 9.4%-иар буюу 1.64 их наяд төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сүүлийн саруудад өсөлтийн хурдац нь саарах хандлагатай болсон. Тайлант оны эцсийн байдлаар нийт харилцах, хадгаламжийн жилийн өсөлт 5.2% болж, өсөлтийн хурдац нь 2013 оноос 37.8%-иар саарчээ.

Зураг 25. Банкны салбарын пассивын бүтэц (тэрбум төг.)



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 26. Эх үүсвэрийн жилийн өсөлт (%)



Банкны салбарын өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүд

Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ оны эцсийн байдлаар 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 30.9%-иар буюу 575.6 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 13.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 22.4%-иар буюу 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Банкууд 2014 онд нийт 287.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Банкны салбарын цэвэр ашгийн хэмжээ 2013 оноос 3.8 тэрбум төгрөгөөр буурч, ашигт ажиллагааны гол үзүүлэлтүүд буурсан байна. Активын болон өөрийн хөрөнгийн өгөөж 1.6%, 12.4%-д хүрч, 2013 оноос харгалзан 1.1, 8.0 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.3%, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.5% байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс харгалзан 3.3 ба 5.5 нэгж хувиар өндөр байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд 2013 оноос харгалзан 0.2, 1.1 нэгж хувиар сайжирсан байна.

Зураг 27. Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд



Зураг 28. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалжууд: Монголбанк

Тайлант оны эцэст банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 41.2%-д хүрч 2013 оноос 3.2 нэгж хувиар буурсан хэдий ч, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны доод шалгуур болох 25%-иас даруй 16.2 нэгж хувиар өндөр байна. Банкууд Засгийн газрын үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтаа тогтвортой нэмэгдүүлэх замаар Төв банкин дахь нөөцөө нэмэгдүүлсэн нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа тогтвортой байхад нөлөөлжээ. Төв банкны болон Засгийн газрын үнэт цаасанд банкуудын оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 2014 онд 3.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь нийт түргэн борлогдох активын 44.6%-ийг бүрдүүлж байв.

Банкууд гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15% дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40% дотор барьж байх шаардлагатай. 2014 оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд -8.9%, нийт валютын хувьд -9.6% байсан нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байв. Нийт гадаад валютын активын хэмжээ 6.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээнд хүрч, 2013 оноос 1.0 их наяд төгрөгөөр буюу 18.6%-иар өссөн бол гадаад валютын пассивын хэмжээ 7.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээнд хүрч, 2013 оноос 1.9 их наяд төгрөгөөр буюу 34.8%-иар өссөн байна.

Банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах чиглэлд Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монголбанкны зүгээс банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах, төлбөрийн чадварыг хадгалах зорилтыг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд сүүлийн жилүүдэд тогтмол тусгаж, энэ чиглэлд дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

Санхүүгийн тогтвортой байдлыг дунд болон урт хугацаанд хангах, системийн шинжтэй болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Монголбанк *“Хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”*-ийн баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах макро зохистой бодлогын хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг өсгөх замаар банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээг чангатгаж, зээлийн эрсдэлийг бууруулах талаар судлан, *“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”*-д нэмэлт, өөрчлөлт оруулж, гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг нэмэгдүүлсэн. Энэ нь зээлийн долларжилтыг саармагжуулах, гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хангах чиглэлд чухал алхам боллоо.

Макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийн нэг болох динамик эрсдэлийн санг манай орны нөхцөл байдалд хэрэгжүүлж болох талаар судалгаа хийж, уг судалгааны үр дүнд үндэслэн *“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”*-д нэмэлт өөрчлөлт оруулж, шинээр олгосон хэвийн зээлд 1%-ийн эрсдэлийн сан байгуулах зохицуулалтыг бий болголоо. Ингэснээр чанаргүй активт байгуулах эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, улмаар банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, болзошгүй эрсдэлийн эсрэг хамгаалалтуудыг нэмэгдүүлэх давуу талыг бий болгож байна.

Санхүүгийн салбарын зохицуулалтын орчныг сайжруулах, санхүүгийн зуучлалыг бодитойгоор нэмэгдүүлэх чиглэлд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран кастодиан үйлчилгээг манай орны санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх зорилгоор *“Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”*-ыг баталсан. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр хөрөнгийн зах зээлийн арилжааны үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчийн үнэт цаасыг түүний зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах боломжийг хязгаарлах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Банкны зохистой засаглал болон үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах хүрээнд *“Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”*-ыг олон улсын стандартын үндсэн зарчмуудтай нийцүүлэн батлуулж, банкуудын үйл ажиллагаанд мөрдүүлж эхлээд байна. Энэхүү журамд өөрчлөлт оруулсантай уялдан *“Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”*-д хараат бус гишүүнийг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж, Монголбанкны зөвшөөрлөөр үүрэгт ажлаас нь чөлөөлөх, системд нөлөө бүхий банкуудын хувьд компанийн хэлбэрээс үл хамааран ТУЗ-ийн Хараат бус гишүүн 3 буюу түүнээс дээш байхаар тус тус тусгасан болно.

Зээлийн мэдээллийн санг өргөтгөх, хүртээмжийг сайжруулах, мэдээллийн чанар болон агууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр нийтдээ 13 банк, 226 бичил санхүүгийн байгууллага буюу 177 банк бус санхүүгийн байгууллага, 49 хадгаламж зээлийн хоршоодтой мэдээлэл солилцож байна. Зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгах, илүү боловсронгуй болгох зорилгоор програмд нэмэлт цэс оруулан хамтран зээлдэгчийн мэдээлэл болон мал тооллогын мэдээллийг орууллаа.

Банкуудад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн багц материалыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж баталлаа. Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчилж буйтай уялдан банкуудаас тайлан хүлээн авах, нэгтгэх програмыг

шинэчилж, банкуудын дансны төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн маягтуудыг шинэчилсэн програмд нэвтрүүлж дууссан бөгөөд банкуудаас тайлан мэдээ хүлээн авах туршилтыг амжилттай хэрэгжүүлээд байна.

Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкуудын холбоотой хамтарсан ажлын хэсгийг байгуулан хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Энэхүү ажлын хүрээнд одоогийн байдлаар Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр “Санхүү, банкны нэр томъёоны гарын авлага”-ыг эрхлэн хэвлүүлж олон нийтэд түгээгээд байна.

Монголбанкнаас цаашид банкны системд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтворгүй байдал үүссэн тохиолдолд түүний далайцыг бууруулах чадамж бүхий бодлогын шинэ хэрэгслүүдийг дэлхийн бусад орнуудын шилдэг туршлагад үндэслэн, өөрийн орны санхүүгийн системийн онцлог байдлыг харгалзан үзэж үр ашигтайгаар хэрэгжүүлэх чиглэлээр судалгааны ажлуудыг тогтмол хийж байна.

Банкны хяналт шалгалт

Газар дээрх хяналт шалгалт

Монголбанкнаас 2014 онд бүх банкуудад газар дээрх иж бүрэн шалгалт, зарим банкинд хэсэгчилсэн шалгалт хийж гүйцэтгэлээ.

Газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх чиглэлд түлхүү анхаарч, банкны эрсдэлийн үнэлгээний аргачлал нь оновчтой, хүлээж болзошгүй эрсдэлийн талаарх бодлого нь үр дүнтэй эсэх, дотоод хяналтын систем нь хангалттай эсэхэд үнэлгээ өгч ажилласан бөгөөд шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж, илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоох, мэдэгдэл бичих, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг банкууд хэрхэн хангаж байгааг газар дээр нь шалган тогтоохоос гадна банкууд өөрийн хөрөнгийн үзүүлэлт, төлбөрийн чадвараа үнэлэх систем, аргачлал нь оновчтой байгаа буюу тухайн банкны эрсдэл, хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээнд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, түүнийгээ банк дотоод үйл ажиллагаандаа оновчтой хэрэгжүүлж, тооцож, үнэлж байгаа эсэх, тооцооллын аргачлал, системийг бие даасан байдлаар боловсруулан бодитой хэрэгжүүлж чадаж байгаа эсэхэд дүгнэлт өгч ажиллалаа.

Хүснэгт 8. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	Зохистой харьцааны доод шаардлага
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	
- I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	9%
- Нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	12% ³
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	
- Түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа	25%

³ Системийн нөлөө бүхий банкуудад 14%

	Зохистой харьцааны дээд хязгаарлалт
Гадаад валютын нээлттэй позиц	
- нэгж валютад	+/-15%
- нийт валютад	+/-40%
Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлтүүд	
- Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт, аккредитивын нийлбэр, өөрийн хөрөнгийн харьцаа	20%
Холбогдох этгээдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад активын нийлбэр, өөрийн хөрөнгийн харьцаа	20%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив, өөрийн хөрөнгийн харьцаа	5%
Үндсэн хөрөнгийн үзүүлэлт	
Үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа	8%

Эх сурвалж: Монголбанк

Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор банкуудад хийгдэж байгаа иж бүрэн хяналт шалгалтын удирдамжинд тусгай заалтуудыг оруулж, 2014 онд шалгалт хийгдсэн банкуудад энэ чиглэлийн хяналт шалгалт хийлээ. Мөн Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлүүдэд хяналт шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллав.

Зайнаас хийх хяналт шалгалт

Тайлант онд банкуудын санхүүгийн тайлан мэдээ, газар дээрх шалгалтын дүнд үндэслэн Монголбанкнаас өгсөн үүргийн биелэлт ба холбогдох бусад хууль, тогтоомжуудын дагуу банкуудад зайнаас хяналт тавих ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ.

Зайнаас хийх хяналтын хүрээнд активыг зохих журмын дагуу ангилаагүй, эрсдэлийн санг дутуу байгуулсан, нягтлан бодох бүртгэлийн журмын заалтуудыг биелүүлээгүй, тайлан мэдээг буруу гаргасан зэрэг зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт, шийтгэвэр тогтоох, холбогдох залруулгын гүйлгээг хийлгэх, зөрчлийг арилгуулах зэрэг арга хэмжээг авсан болно.

Түүнчлэн банкуудын тайлан тэнцэлд үнэлгээ, дүгнэлт өгч ажиллахаас гадна банкинд тавих хяналт шалгалтыг хугацаанд нь, чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс банкны өөрийн хөрөнгийн, гадаадын хөрөнгө оруулалттай банкны судалгаа, Банкны тухай хуулийн 38.2 дахь заалтын биелэлтийг улирал бүр, банкны салбар нэгжийн өөрчлөлтийн судалгааг хагас жил тутам гаргаж ажиллалаа.

Шигтгээ 2. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг (ОНССМ)-ийг дээшлүүлэх хөтөлбөр

Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх нь нэн чухал билээ. Хөгжиж буй эдийн засагтай орнуудын хувьд иргэдийн санхүүгийн суурь мэдлэг сайн байх нь эдийн засгийн бодит өсөлтийг тогтвортой байлгах, ядуурлыг бууруулах, цаашлаад санхүүгийн болзошгүй хямралаас сэргийлэхэд чухал нөлөөтэй байдаг бол өндөр хөгжилтэй орны хувьд тэтгэврийн насны иргэд хангалттай хэмжээний хуримтлал үүсгэсэн байх, өрийн дарамтад орохгүй байх зэрэг нөхцөлийг бүрдүүлдэг ач холбогдолтой байна.

Харин олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг дутмаг, санхүүгийн бүтээгдэхүүний талаар ойлголт бага байх нь иргэд урт хугацаанд санхүүгийн оновчгүй шийдвэрийг гаргахад хүргэж, үүнээс үүдэн иргэдийн санхүүгийн байдал сайжрахгүй, цаашлаад санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг байна.


1990-ээд оны сүүлчээр тохиолдсон Азийн санхүүгийн хямралын дараагаас эхлэн Япон, Сингапур, Голланд, Шинэ Зеланд, Их Британи болон АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнууд санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх явдлыг бодлогын хэмжээнд авч үзэн, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж эхэлсэн байдаг. Энэ нь үндэсний хэмжээнд санал нэгдсэн санхүүгийн боловсролыг сайжруулахын тулд хэрэгжүүлж буй хөтөлбөр болон тогтолцоо бүхий арга хэмжээний цогц юм.

Тус хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж буй орнуудын тоо эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2011 оны байдлаар 26 орон тус хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шатандаа явж байсан бол энэ тоо 2013 оны байдлаар 45 болж өсөөд байна.

Хүснэгт 9. ОНССМ-ийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж буй байдал

Хэрэгжилтийн байдал	Тоо	Орнууд
Үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа	20	Австрали, Бразил, Чех, Эль Сальвадор, Эстони, Гана, Ирланд, Япон, Малайз, Голланд, Шинэ Зеланд, Нигер, Португал, Сингапур, Словен, ӨАБНУ, Испани, Их Британи, АНУ, Замби
Үндэсний хөтөлбөрийг боловсруулах үйл явц ахисан буюу дэвшилтэт түвшинд байгаа	25	Армен, Канад, Чили, Колумб, Энэтхэг, Индонез, Израйл, Кени, БНСУ, Латви, Леван, Мексик, Малави, Морокко, Перу, Польш, Румын, ОХУ, Серб, Швед, Танзани, Тайланд, Турк, Уганда, Уругвай
Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар төлөвлөж байгаа	5	Аргентин, БНХАУ, Франц, Итали, Саудын Араб

Зураг 29. ОНССМ-ийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа байдал (бүс нутгаар)



Эх сурвалжууд: ЭЗХАХБ (OECD)

Улс орнуудын санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин, хүн амын хэрэгцээ шаардлага зэргээс хамааран хөтөлбөрийн зорилго нь санхүүгийн зах зээлийг хүртээмжтэй болгох, иргэдийг санхүүгийн зөв зохистой шийдвэр гаргах чадавхитай болгох, хувьсан өөрчлөгдөж буй нийгэм эдийн засгийн сорилтуудтай тулгарахад нь туслах зорилготой байдаг.

Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр нь ихэвчлэн бүх нийтэд зориулагдсан байдаг боловч тодорхой хэмжээнд ямар нэг зорилтот бүлэгт илүү ач холбогдол өгч, анхаарал хандуулах явдал бий. Ихэнх оронд залуучууд болон хүүхдүүдийг зорилтот бүлэгт зүй ёсоор оруулдаг бөгөөд бусад зорилтот бүлэг нь тухайн орны онцлогоос хамаарч харилцан адилгүй байна.

Хүснэгт 10. Дэлхийн улс орнуудын ОНССМ-ийг дээшлүүлэх хөтөлбөрийн зорилтот бүлгүүд

Зорилтот бүлэг	Уг бүлгийг зорилтот хэмээн сонгосон орнууд
Эмэгтэйчүүд	Бразил, Энэтхэг, Индонез, Саудын Араб, Турк
Шилжин суурьшигчид	Канад, Индонез, Мексик
Бизнес эрхлэгчид	Бразил, Энэтхэг, Индонез, Голланд, Саудын Араб, Испани
Ажилчид, бага дунд орлоготой иргэд, өндөр настнууд	Бразил, Канад, Хятад, Солонгос, Турк болон АНУ
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс	Энэтхэг
АНУ-руу цагаачлагчид	Мексик
Хөдөө орон нутгийн иргэд	БНХАУ
Их сургуульд суралцаж байх үе, гэрлэх, орон сууц худалдан авах, гэр бүл салах, хүүхэдтэй болох, ажилгүй болох зэрэг гэр бүл, хувь хүний хувьд санхүүгийн шийдвэр гаргах шаардлага тулгардаг тодорхой үеүд	БНСУ, Голланд, Их Британи

Эх сурвалж: ЭЗХАХБ (OECD)

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн үр дүнд тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлгээ хийх нь хөтөлбөрийн ач холбогдлыг нэмэгдүүлэх бөгөөд одоогийн байдлаар Австрали, Япон, Голланд, Сингапур, ӨАБНУ, Их Британи болон АНУ гэсэн 7 орон тоон болон чанарын аргаар үнэлгээ хийсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох боломжтой болох, санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх, иргэдийн өрийн хэмжээ буурч, хуримтлал нэмэгдэх, ядуурал, гэмт хэрэг буурах зэрэг ач холбогдолтой юм.

Монголбанк сүүлийн жилүүдэд дотоод, гадаадын холбогдох байгууллагуудтай хамтран олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх суурь судалгааг хийж, хөтөлбөр боловсруулах чиглэлээр ажиллалаа. ОНССМ-ийг дээшлүүлэх дунд хугацаа (3-5 жил)-ны хөтөлбөрийг 2015 онд баталж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Шигтгээ 3. Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо

Орон сууцны санхүүжилтийн систем

Эрс тэс уур амьсгалтай, хүн амын дийлэнх хэсэг нь гэр хороололд амьдардаг манай орны хувьд орон сууцны санхүүжилтийн зах зээлийн зарчимд нийцсэн, тогтвортой тогтолцоог бий болгож, ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг зөв чиглэлээр, урт хугацаанд хөгжүүлэх асуудал эн тэргүүнд тавигдсаар ирсэн билээ. Манай улсад ипотекийн зээл олгох үйл ажиллагаа 2003 оноос эхэлсэн бөгөөд түүнээс хойш дан ганц банкны салбарын хадгаламжид суурилсан орон сууцны санхүүжилтийн систем зонхилж байв. 2003 онд Азийн Хөгжлийн банкны “Орон сууцны санхүүжилт” төсөл хэрэгжсэн нь банкны салбарын богино хугацаат эх үүсвэрээр орон сууц барьцаалсан урт хугацаатай зээлийн үйл ажиллагааг эхлүүлэх, улмаар орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бий болгох урт хугацааны зорилтыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ.

Орон сууцны зээлийн санхүүжилтийг хэрхэн бий болгож байгаа буюу зээлийн эх үүсвэр хаанаас гарч байгаагаас нь хамаарч орон сууцны санхүүжилтийн системийг дараах 5 төрөл болгон ангилж байна:

- Хадгаламжид суурилсан систем
- Бондын захад суурилсан систем
- Үнэт цаасжуулалт буюу хоёрдогч захад суурилсан систем
- Орон сууцны төрийн банк, эсхүл сан
- Бусад санхүүгийн эх үүсвэр

Орон сууцны санхүүжилтийн системийн үр ашгийг хэмжихийн тулд хэд хэдэн үзүүлэлтүүдийг авч үздэг. Үүнд өрхийн дундаж орлого нь дундаж ангиллын орон сууцыг ипотекийн зээлээр худалдан авахад банкнаас тавьж буй өрхийн орлогын шаардлагыг хангах хэмжээнд хүрэлцээтэй байх, зээлийн төрөл нь макро эдийн засгийн нөхцөл байдал, харилцагчдын хэрэгцээнд нийцсэн байх, банкны зээлэх болон зээлдүүлэх хүүгийн зөрүү болон ипотекийн зээлээр баталгаажсан бонд болон бусад үнэт цаасны хүүгийн зөрүү бага байх, үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр аливаа саадгүйгээр, бага зардлаар хангуулдаг байх, зээлдэгчийн мэдээлэл, үл хөдлөх хөрөнгө болон гүйлгээний шинж чанарт үндэслэн зээлийн алдагдлыг урьдчилан, хэсэгчлэн таамаглах боломжтой байх, систем нь гадаад орчны сөрөг нөлөөнд тэсвэртэй, уян хатан байх, дотоод орчны сөрөг өөрчлөлтийг даах чадалтай, хэврэг бус байх, санхүүгийн боловсрол багатай зээлдэгч шударга бус зээл олголтоос хамгаалагдсан байх зэрэг үзүүлэлтүүд ордог байна.

Хадгаламжийн эх үүсвэрт тулгуурласан орон сууцны санхүүжилтийн тогтолцоонд банкууд зээл олгох, эргэн төлөлтийг хариуцах, зээлийн эрсдэлийг хүлээх, эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг бол хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн системд орон сууцны зээл олголт, эргэн төлөлтийг банкууд хариуцаж, харин зээлийн эрсдэл болон санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагаа нь үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдад шилждэг.

Хадгаламжид суурилсан орон сууцны санхүүжилтийн системийн давуу тал нь банк хугацаа хэтрэлт болон зээлийн төлбөрийн чадварын эрсдэлийг хүлээх учир зээлийн эрсдэлийн хяналт сайн байдаг. Мөн зээлдүүлэгч, зээлийн үйлчилгээ үзүүлэгч нь нэг байгууллага (банк) учраас тухайн зээлдэгчид үзүүлэх үйлчилгээ илүү сайн байх талтай. Харин энэхүү системийн сул тал нь банкны актив, пассивын хугацааны зөрүү буюу богино хугацаатай хадгаламжийн эх үүсвэрээр орон сууцны урт хугацаатай зээлийн эрэлтийг хангах болдог тул хүүгийн эрсдэлийг удирдахад хүндрэлтэй, зээлийн төлбөрийн чадварын эрсдэл төвлөрөх магадлалтай, ялангуяа газар зүйн хувьд жижиг хэсгийг хамарсан зээл олгох тохиолдолд нэг байгууллага олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг тул үйл ажиллагааны үр ашиг бага байх, банкны байнгын санхүүжилт хязгаарлагдмал учир өрсөлдөөн сул байх талтай байдаг.

Тиймээс Монголбанк урт хугацаанд тогтвортой ажиллах орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэхийг зорьж, Засгийн газартай хамтран “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөрийг хэрэгжүүлэн хадгаламжид суурилсан орон сууцны санхүүжилтийн системээс хоёрдогч захад суурилсан системд шилжих ажлыг 2013 онд эхлүүлсэн билээ. Энэхүү шинэ систем нь төрөл бүрийн хугацаатай ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргаж хөрөнгө оруулагчдад худалдсанаар хүүгийн эрсдэлийг үр ашигтай удирдах боломж бий болгох, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг эрсдэлээс нь хамааруулан ангилж, зэрэглэл болон үнийг нь тогтоон, хөрөнгө оруулагчдад эрсдэлийг тархаасан үнэт цаас худалдан авах боломжийг бий болгосноор төлбөрийн чадварын эрсдэлийг үр ашигтай тархаан байршуулах, мэргэжлийн төрөлжсөн ур чадвар, зах зээлийн сахилга бат сайн тул үйл ажиллагааны үр ашиг өндөр байх зэрэг давуу талтай байна.

Түүнчлэн ипотекийн зээлийн хоёрдогч зах нь шинээр зээл олгож буй банкинд зах зээлд хялбараар нэвтэрч орох боломж олгосноор анхдагч зах зээл дээр өрсөлдөөн үүсгэн зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх давуу талтай. Харин мэдээллийн тэгш бус байдал нь хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн системийн сул тал юм. Учир нь зээл олголтыг хариуцаж буй банкууд зээлдэгчийн талаар илүү мэдээлэлтэй байдаг боловч зээлийн багцыг худалдан тайлан тэнцлээсээ хасч, зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулагчид шилжүүлдэг бол хөрөнгө оруулагч нь зээлийн эрсдэлийг өөртөө авсан боловч зээлдэгчийн талаар хомс мэдээлэлтэй байдаг. Энэ нь банкны хувьд зээлийн чанарт төдийлөн анхаарахгүйгээр зээлийг их хэмжээгээр олгох сонирхлыг бий болгох эрсдэл дагуулах магадлалтай байдаг.

Тиймээс ипотекийн зээлийн нэгдсэн стандартыг гаргаж мөрдүүлэх, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөрөнгийн эрхийн бүртгэлийг найдвартай, шуурхай хийх зэрэг асуудлыг оновчтой шийдвэрлэх нь хоёрдогч захад суурилсан орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоо үр ашигтай ажиллах чухал хүчин зүйл юм.

Үүнээс гадна манай улсын хувьд хөрөнгийн захын хөгжил сул хэвээр байгаа, урт хугацаат ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-д хөрөнгө оруулах боломжтой мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид үүсч бий болоогүй байгаа нь Төрийн оролцоогүйгээр хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх боломжийг бий болгохгүй байсан юм.

Иймд, Монголбанк хөрөнгийн захын томоохон хөрөнгө оруулагч бий болох хүртэл орон сууцны санхүүжилтийг хариуцаж байгаа бөгөөд цаашид Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, түүнийг улсын төсвөөс тусгаарлан бие даасан институциональ хөрөнгө оруулалтын сан болгон хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг. Ингэснээр тус сангийн хөрөнгөөр ИЗББ-д хөрөнгө оруулах замаар орон сууцны урт хугацааны санхүүжилтийн тасралтгүй урсгалыг бий болгох боломжтой юм.

Зураг 30. Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ерөнхий схем




Эх сурвалж: Монголбанк

Үнэт цаасжуулалт

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу санхүүгийн зах зээл дээр барьцаат болон баталгаат гэсэн хоёр төрлийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах боломжтой. Эдгээр үнэт цаас нь ипотекийн зээлийн багцын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажих боловч барьцаат үнэт цаасны хувьд зээлийн багц банкны тэнцэл дээр үлдэх бол баталгаат үнэт цаасны хувьд банк зээлийн багцыг тэнцлээсээ бүрэн хасдагаараа ялгаатай. Иймд зээлийн багцын чанар муудсан тохиолдолд барьцаат үнэт цаасны хувьд үнэт цаас гаргасан банк зээлийн эрсдэлийг хариуцдаг бол баталгаат үнэт цаасны тухайд үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагч нь зээлийн эрсдэлийг хариуцдаг байна.

Манай улсын хөрөнгийн захын хөгжил сул, банкуудын санхүүгийн чадавхи хязгаарлагдмал зэрэг хүчин зүйлсийг харгалзан хөтөлбөрийн хүрээнд баталгаат үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн. Ингэснээр банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд дарамт учрахгүйгээс гадна МИК (Монголын Ипотекийн Корпораци) ОССК ХХК-ийн үүсгэн байгуулсан Тусгай зориулалтын компани (ТЗК) ипотекийн зээлийг худалдан авч багцлан, үнэт цаасжуулснаар зардал хэмнэх боломжтой болсон. Түүнчлэн ипотекийн зээлийг МИК ОССК ХХК-иас тогтоосон шалгуурын дагуу худалдан авч нэгдсэн стандартад шилжүүлэн, банкуудыг олгосон болон үйлчилгээ үзүүлсэн зээлийн дүнгээс хамаарч урамшуулахаар болсон нь зээлийн эргэлтийг хурдасгаж, банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх давуу талтай болсон.

Зураг 31. Үнэт цаасжуулалтын бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Хэдийгээр баталгаат үнэт цаас нь дээрх давуу талуудтай боловч зээлийн багцыг банкны тайлан тэнцлээс хассанаар зээлийн эрсдэл хөрөнгө оруулагчдад шилждэг тул хөрөнгө оруулагчдыг зээлийн эрсдэлээс хамгаалах, банкуудын үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг алдагдуулахгүй байх зорилгоор холбогдох зохицуулалтыг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д тусгасан. Уг журмын дагуу МИК ОССК ХХК хөтөлбөрт хамрагдсан банкуудын ипотекийн зээлийг худалдан авч багцлан, давуу эрхтэй болон энгийн гэсэн хоёр ангиллын үнэт цаас гаргана. Нийт гаргасан үнэт цаасны 90% нь давуу эрхтэй, 10% нь энгийн ИЗББ байна. Давуу эрхтэй ИЗББ нь зээлийн багцын мөнгөн урсгалаас төлбөр хүлээн авах дарааллын хувьд тэргүүн ээлжийн эрхтэй байх тул үнэт цаас гаргагч давуу эрхтэй ИЗББ-ын үндсэн болон хүүгийн төлбөрийг эхэлж хуваарилан зөвхөн давуу эрхтэй ИЗББ-ын төлбөр бүрэн төлөгдсөний дараа л

энгийн ИЗББ-ын төлбөрийг хуваарилахаар журмаар зохицуулсан.

Түүнчлэн зээлийн эрсдэл үүссэн тохиолдолд аливаа алдагдлыг энгийн ИЗББ эзэмшигчид түрүүлж хүлээх бөгөөд алдагдлын хэмжээ энгийн ИЗББ-ын үлдэгдлээс хэтэрсэн тохиолдолд давуу эрхтэй ИЗББ эзэмшигчид алдагдал хүлээх зохицуулалттай байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр банкуудын үйл ажиллагааны зохистой хэм хэмжээ алдагдахаас сэргийлж энгийн ИЗББ-ыг банкууд 3 жилийн турш эзэмшихээр журамд заасан. Энгийн ИЗББ-ыг банкууд тодорхой хугацаанд эзэмшин, эрсдэл, үр өгөөжийг хуваалцсанаар банкуудын зохистой үйл ажиллагааг хангах, зээлийн багцын чанар муудахаас сэргийлэх, улмаар банк, санхүүгийн салбарт системийн шинжтэй болзошгүй эрсдэл үүсэхээс хамгаалах зорилготой юм.

Хууль эрх зүйн зохицуулалт

2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанк Засгийн газартай “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулсан нь урт хугацаанд тогтвортой ажиллах ипотекийн хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгох анхны нөхцлийг бүрдүүлсэн. 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ыг баталж, орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвортой байлгах, иргэдийн эрүүл аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтот ажлыг эхлүүлсэн билээ.

Дээрх ажлын хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн А167/203 дугаар хамтарсан тушаалаар “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны багцыг тусгай тэмдэглэл хийж, бүртгэх журам”-ыг баталсан бөгөөд ипотекийн хоёрдогч захад суурилсан орон сууцны

санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор уг хөтөлбөрийн эхлэлийн санхүүжилтийг Монголбанкнаас банкинд зээл хэлбэрээр, дараагийн санхүүжилтийг банк эхлэлийн санхүүжилтээр иргэдэд олгосон ипотекийн зээлийн багцыг Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан тусгай зориулалтын компаниар үнэт цаасжуулан Монголбанкинд худалдах замаар олгох тогтолцоог бүрдүүлэх урьдач нөхцөл богино хугацаанд амжилттай бүрдсэн юм.

МИК ОССК ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос анхны тусгай зориулалттай компанийн зөвшөөрлийг 2013 онд авсан бөгөөд анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр санхүүгийн зах зээл дээр амжилттай гаргасан.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийг иргэдэд саад бэрхшээлгүй, түргэн шуурхай олгоход төрийн байгууллага хоорондын харилцан ойлголцол, зохион байгуулалттай хамтын ажиллагаа нь хөтөлбөрийг амжилттай эхлүүлж хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байсан юм.

Ийнхүү орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сүүлийн 18 сарын хугацаанд банкуудын орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл 2845 тэрбум төгрөгт, үүний 2028 тэрбум төгрөг буюу 71.3%-ийг энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл эзэлж байна. Нийт зээлдэгчдийн тоо 2012 оны эцэст 29,887 байсан бол 2014 оны эцэст 66,334 болж 2.2 дахин өсчээ. Улмаар орон сууцны ипотекийн зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2012 оны эцэст 6% байсан бол 2013 оны эцэст 11%, 2014 оны эцэст 13% болж нэмэгдээд байна.

1.4 Улсын төсөв

Засгийн газрын цэвэр зээл

Төв банк болон банкуудын нэгдсэн дүнгээр 2014 оны эцэст Засгийн газрын өр төлбөр 2519.9 тэрбум төгрөг, хөрөнгө 2320.6 тэрбум төгрөг болж, Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)-ийн хэмжээ 199.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь ЗГЦЗ өнгөрсөн оноос 1255.3 тэрбум төгрөгөөр буюу 118.9 хувиар өссөн үзүүлэлт байлаа.

Хүснэгт 11. Банкны систем дэх ЗГЦЗ, Монголбанкныг оруулсан дүн (тэрбум төгрөг)

Хөрөнгө	2013	2014	Өөрчлөлт	Өр төлбөр	2013	2014	Өөрчлөлт
Төсвийн харилцах	1268.2	400.9	(867.3)	ЗГҮЦ	1780.3	2290.5	510.2
Төгрөгийн	807.1	311.9	(495.2)	Богино хугацаат	393.0	723.8	330.8
Валютын	461.1	89.0	(372.1)	Дунд хугацаат	1387.3	1566.7	179.3
Төгрөгийн нөөц	386.4	319.7	(66.7)	ЗГ-т олгосон зээл	-	-	-
Нийгмийн даатгал	565.6	726.1	160.5	Бусад	42.7	229.4	186.7
ЗГ-ын санхүүжилт	540.1	693.0	152.9				
Бусад	118.7	180.9	62.2				
1. Нийт	2879.0	2320.6	(558.4)	2. Нийт	1823.0	2519.9	696.9
				ЗГЦЗ [2-1]	(1056.0)	199.3	1255.3

Эх сурвалж: Монголбанк

Банкны систем дэх Засгийн газар (ЗГ)-ын нийт өр төлбөр 2013 оноос 696.9 тэрбум төгрөгөөр буюу 38.2%-иар өссөн нь Монголбанкны платформуор болон Хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалж буй Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны үлдэгдэл 510.2 тэрбум төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалжээ.

Харин ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 558.4 тэрбум төгрөгөөр буюу 19.4%-иар буурсан байна. Банкуудад байршиж буй нийгмийн даатгалын хөрөнгө, Засгийн газрын санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч, Төв банкин дахь ЗГ-ын төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдэл нийт 867.3 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын хөрөнгийн хэмжээ буурахад голлон нөлөөлжээ. Банкны систем дэх ЗГ-ын нийт өр төлбөрийн 15% нь Монголбанкинд, 85% нь банкуудад байршиж байгаа бол хөрөнгийн 33.7% нь Монголбанкинд, 66.3% нь банкуудад байршиж байна.

Хүснэгт 12. ЗГЦЗ-ийн тайлан (банкуудаар болон системийн хэмжээгээр), сая төгрөгөөр

ДАНС	БАНКУУД	Банкууд	Улирлын өсөлт (хувь)	Монголбанк	Улирлын өсөлт (хувь)	БҮГД ДҮН	Улирлын өсөлт (хувь)
1. Засгийн газрын өр төлбөр		2 140 813.2	17.4	379 085.8	100.0	2 519 899.0	38.2
Урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар		9 121.4	241.0	-	-	9 121.4	241.0
ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас		723 823.2	84.2	-	-	723 823.9	84.2
ЗГ-ын дунд хугацаатай үнэт цаас		1 364 248.4	(1.7)	202 404.4	100.0	1 566 652.8	12.9
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг		43 619.5	9.0	-	-	43 619.5	9.0
Засгийн газрын зээл		-	-	-	-	-	-
ЗГ-ын бусад төрлийн өглөг		-	-	176 681.4	100.0	176 681.4	100.0
2. Засгийн газрын хөрөнгө		1 538 314.2	29.7	782 288.2	(53.8)	2 320 566.1	(19.4)
Улсын төсөв		1 512 314.2	27.9	782 288.2	(53.8)	2 294 602.4	(20.2)
Улсын төсвийн төгрөгийн харилцах		-	-	311 938.0	(61.4)	311 938.0	(61.4)
Улсын төсвийн төгрөгийн хугацаатай хадгаламж		6 037.0	471.4	-	-	6 037.0	471.4
Улсын төсвийн төгрөгийн хугацаагүй хадгаламж		43.4	(17.2)	-	-	43.4	(17.2)
Улсын төсвийн төгрөгийн нөөц		-	-	319 677.8	(17.3)	319 677.8	(17.3)
Улсын төсвийн валютын нөөц		-	-	28 465.4	649.8	28 465.4	649.8
Улсын төсвийн валютын харилцах		-	-	88 969.6	(80.7)	88 969.6	(80.7)
Улсын төсвийн валютын хугацаатай хадгаламж		-	(100.0)	-	-	-	(100.0)
Улсын төсвийн валютын хугацаагүй хадгаламж		-	-	-	-	-	-
Улсын төсвийн валютын данс (төсөл)		-	-	25 799.3	2.6	25 799.3	2.6
Орлогын шилжүүлэг (төгрөг)		9 025.7	(48.7)	-	-	9 025.7	(48.7)
Орлогын шилжүүлэг (валют)		30.8	(99.7)	-	-	30.8	(99.7)
Нийгмийн даатгал (төгрөг)		726 147.7	28.4	-	-	726 147.7	28.4
Нийгмийн даатгал (валют)		-	-	-	-	-	-
Тусгай данс (төгрөг)		47 157.4	13.7	-	-	47 157.4	13.7
Тусгай данс (валют)		30 896.5	430.0	-	-	30 896.5	430.0
Засгийн газрын санхүүжилт		692 975.7	28.3	-	-	692 975.7	28.3
Засгийн газрын авлага (KFW II)		-	-	7 409.9	(2.7)	7 409.9	(2.7)
Хуримтлуулж тооцсон хүүний авлага		-	-	28.2	(98.3)	28.2	(98.3)
Өр барагдуулах албатай хийх тооцоо		-	-	-	-	-	-
Орон нутгийн төсөв		25 963.7	563.2	-	-	25 963.7	563.2
Орон нутгийн тусгай данс (төгрөгийн)		8 900.3	175.9	-	-	8 900.3	175.9
Орон нутгийн тусгай данс (валютын)		17 063.3	2 375.8	-	-	17 063.3	2 375.8
3. ЗГ-ын цэвэр зээл (1-2)		602,535.3	(5.4)	(403,202.3)	(76.2)	199,332.9	(118.9)

Эх сурвалж: Монголбанк болон банкуудын тайлан тэнцэл


2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн

2013-2014 оны гадаад орчны таагүй нөхцөл байдал ба төлбөрийн тэнцлийн 2013 оны хямрал

Дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширсан, гадаад зах зээлд түүхий эдийн үнийн урт хугацааны мөчлөг (super cycle) дуусгавар болж, үнэ уруудах хандлагатай болсны нөлөөгөөр Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл 2011 оны 4 дүгээр улирлаас хойш муудсан үзүүлэлттэй байв. Экспортын голлох түүхий эд болох нүүрс, зэсийн үнэ 2012 онтой харьцуулахад харгалзан 70%, 20%-иар тус тус буурсан үзүүлэлттэй болжээ.

Дэлхийн, түүний дотор Азийн бүс нутгийн хөрөнгө оруулалтын орчин тодорхой бус, хөрөнгийн урсгал нь хөгжиж буй болон бүрэлдэж буй эдийн засагтай (emerging markets) орнуудаас гадагшлах хандлага үргэлжилсэн хэвээр, Хятад улсаас хөгжиж буй орнуудад хийх хөрөнгө оруулалт эрс буурсаар байна. Гадаад орчны эдгээр сөрөг хүчин зүйлсээс гадна манай улсын дотоодын хөрөнгө оруулалтын орчинд 2012 оноос тодорхой бус байдал үүссэн, томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт шийдэгдээгүй хэвээр байсны улмаас Монгол Улсын эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал сүүлийн 30 гаруй сарын турш сэргээгүй, төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралын нөлөөлөл нь 2014 оны туршид арилаагүй хэвээр байлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оны оргил үеэс 17 дахин буурч, 2014 онд 276 сая ам.доллар болж, гуравхан жилийн дотор ДНБ-ий 45%-иас ердөө 2%-тай тэнцэхүйц түвшинд болж огцом багассан юм. Ийнхүү гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2009 онд эдийн засаг 1.3%-иар агшиж, санхүү-эдийн засгийн хямралтай байсан үеийнхээс ч доогуур түвшинд болж буураад байна.

Зураг 32. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүн)



Зураг 33. Дэлхийн зах зээл дэх нүүрс, зэсийн үнэ



Эх сурвалжууд: Монголбанк, Гаалийн ерөнхий газар, LME, Bloomberg

Эдийн засгийг зөөлөн газардуулах, тогтворжуулах зорилгоор 2013-2014 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр нөлөө:

2012 оны 11 дүгээр сараас эхлэн эдийн засгийн тогтворжуулах (stabilization), улмаар зөөлөн газардуулах (soft-landing) мөнгөний бодлогын шат дараатай, зайлшгүй арга хэмжээ авсны үр дүнд гадаад худалдаа, урсгал тэнцэл, нийт эдийн засагт шаардлагатай тохиргоо хийгдэх, үүссэн нөхцөл байдалд хувийн хэвшил, эдийн засгийн бусад оролцогчид дасан зохицох цаг хугацааны орон зай, боломжийг олгож, эдийн засгийг бодит хөрсөн дээр нь аль болох алгуурхан газардуулсан болно. Тухайлбал, 2012 онд ДНБ-ий бодит өсөлт 12.3% байсан бол 2013 онд 11.6%, 2014 онд 7.8% болж саарсан хэдий ч, эдийн засаг огцом уналтад орж агших (crash-landing), нийт М2 мөнгөний нийлүүлэлт огцом буурах, банкны системд зээл тасалдах, дотоод активууд үнэгүйдэх, санхүү-эдийн засаг-нийгмийн гурвалсан хямрал 2013-2014 онд бий болох эрсдлээс урьдчилан сэргийлж,

цаашид эдийн засагт бүтцийн шинэчлэл хийх, эдийн засгийг эрүүл хурдаар тогтвортой тэлэх суурь нөхцөлийг бүрдүүлээ.

Мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь төлбөрийн тэнцлийн хямралын үед уул уурхайн бус салбарыг огцом уналтад оруулахгүй байлгах, ажлын байрыг хамгаалах, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих, гадаад худалдааг тэнцвэржүүлэхэд тус тус эерэг нөлөө үзүүлсэн юм. Тухайлбал, хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлт 2013 онд 19.0%, 2014 онд 14.4%, барилгын салбарын бодит өсөлт 2013 онд 8.0% (2010 оны суурьтай тооцсоноор 8%. Харин 2005 оны суурьтай тооцвол барилгын салбар 2013 онд 66%-ийн бодит өсөлт үзүүлсэн), тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын бодит өсөлт 2014 онд 23.5% гарахад мөнгөний уламжлалт бус бодлого голлох үүрэг гүйцэтгэсэн болно.

2011-2013 онд гадаад худалдааны тэнцэл дунджаар -2.0 тэрбум ам.долларын алдагдал хүлээдэг байсан бол 2014 онд +0.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, гадаад худалдаанд 2.5 тэрбум ам.долларын эерэг өөрчлөлт бий боллоо. 2011-2013 онд урсгал тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ дунджаар -26.4% байсан бол 2014 онд экспорт 35%-иар өсч, импорт -18%-иар буурснаар уг үзүүлэлт -11.6% болж, урсгал тэнцлийн алдагдлын хэмжээ 2.2 дахин буурлаа. Түүнчлэн, эдийн засгийг зөөлөн газардуулах мөнгөний бодлого нь хөдөлмөрийн зах зээл дэх нийт ажлын байрны 20%-ийг 2013 онд алдах байсан эрсдлээс сэргийлж, хөдөө аж ахуй, барилга, агуулахын үйл ажиллагааны салбарт ажлын байрыг хадгалахад эергээр нөлөөлсөн.

Хүснэгт 13: ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлсэн хувь нэмэр

Бодит ДНБ	7.8%	100%
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.7%	21%
2 Уул уурхай, олборлолт	4.9%	63%
3 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.4%	17%
4 Бөөн/жиж.худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	-1.0%	-13%
5 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-1.1%	-14%
6 Мэдээлэл, холбоо	0.1%	2%
7 Боловсруулах үйлдвэрлэл	0.2%	2%
8 Барилга	0.0%	1%
9 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.1%	1%
10 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.6%	20%

Хүснэгт 14: ДНБ-ий бодит өсөлт, салбараар

Салбарууд	2013	2014
Бодит ДНБ	11.6%	7.8%
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	19%	14%
2 Уул уурхай, олборлолт	19%	24%
3 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-2%	23%
4 Бөөн/жиж.худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	7%	-7%
5 Бүтээгдэхүүний цэвэр татвар	13%	-8%
6 Мэдээлэл, холбоо	13%	6%
7 Боловсруулах үйлдвэрлэл	11%	3%
8 Барилга	8%	1%
9 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	5%	5%
10 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9%	8%

Эх сурвалж: УСХ

2013-2014 онуудад барилгын салбарт ажиллагсдын тоо 15.3 мянгаар өсч 77 мянгад, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо 10.1 мянгаар өсч 70 мянгад тус тус хүрчээ. Эдийн засгийг тогтворжуулах, зөөлөн газардуулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд нь 2013 онд ажилгүйдэл 180 мянга гаруй хүнээр нэмэгдэх байсан эрсдлээс урьдчилан сэргийлж, нийт ажиллагсдын тоо 2013 онд 20,024 хүнээр, 2014 онд 2479 хүнээр нэмэгдэх, ажилгүйдлийн түвшинг 2012 оны эцсийн 7.9%-иас огцом нэмэгдүүлэхгүй байлгахад тус тус эергээр нөлөөлсөн юм.

Эдийн засгийн бодит өсөлтийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь авч үзвэл 2013 онд банкны салбарын зээл буюу мөнгөний уламжлалт бус бодлогын нөлөө голлох үүрэг гүйцэтгэжээ. Эмпирик тооцооллын үр дүнгээс үзэхэд 2013 оны эдийн засгийн 11.6%-ийн бодит өсөлтийн 5.0 нэгж хувийг банкны салбарын зээлийн өсөлт (мөнгөний уламжлалт бус бодлогын нөлөөтэй) дангаараа бий болгосон байна.


ДНБ-ий бодит өсөлт дэх улсын төсвийн нөлөөлөл 2013-2014 онд маш бага байна. 2014 оны 2 дугаар хагасаас эхлэн макро бодлогыг эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд өөрчилж, энэ хүрээнд мөнгөний бодлогыг алгуур хатууруулах, уламжлалт бус мөнгөний бодлогыг үе шаттай хумьж эхэлсэнтэй уялдан ДНБ-ий бодит өсөлт дэх мөнгө, төсвийн бодлогын нөлөөлөл буурах, улмаар эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч байна.

Төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралын нөлөө 2014 онд арилаагүй, төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр байсны улмаас 2014 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад цэвэр актив (Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын нийт гадаад активаас нийт гадаад пассивыг хассан дүн)-ын хэмжээ 2013 оны эцэстэй харьцуулахад 2636 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээгээр буурчээ. Гадаад валютын орох урсгал сайжраагүйгээс төлбөрийн тэнцэл 2014 онд -471 сая ам.долларын алдагдалтай гарсан. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2013 оныхоос 1.4 тэрбум ам.доллараар буурсан хэдий ч, улсын төсвийн зардал, алдагдал өсч, төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр байсан нь эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломжийг хязгаарласан суурь хүчин зүйл болж байв.

Төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралын нөлөөг санхүүгийн салбарын тогтворгүй байдалд хүргэхгүйн тулд 2014 оны сүүлийн хагасаас эхлэн макро эдийн засгийн бодлогын төлөвийг эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд өөрчлөх, тэр дундаа төсвийн зардал болон төсөвтэй адилтгах зарцуулалтыг эрс бууруулах шаардлагыг бий болгосон. Гэвч улсын төсвийн зардал болон төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд нь макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангахад нөлөөлөхүйц хэмжээнд буураагүй тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлэх зорилгоор 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдөр мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн үр дүнд 2013 оноос эхлэн инфляцийн бүтцэд эерэг өөрчлөлт гарч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт эрс бууран, нам, тогтвортой түвшинд байна. Тухайлбал, 2010-2012 онд нийт инфляцийн 33.4% (1/3)-ийг нийлүүлэлтийн гаралтай инфляци бүрдүүлдэг байсан бол 2013 онд 18.0% (1/6), 2014 онд 4.5% (1/20) болж огцом буурлаа. Хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг эрс бууруулснаар 2013-2014 онд жилийн инфляци 25-30% болж өсч болзошгүй байсан эрсдлээс сэргийлсэн юм.

Зураг 34: Инфляцийн бүтэц дэх эерэг өөрчлөлт



Эх сурвалж: УСХ

Ингэснээр 2015 он, цаашлаад инфляцийн зорилтыг хангах боломж нөхцөл бүрдэж байна. Нөгөө талаар мөнгөний бодлогын төлвийг эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд өөрчилснөөр импортын бараа, импортын орц бүхий дотоодын бусад барааны үнийн өсөлт болон суурь инфляци эрчимжих хандлага 2014 оны 8 дугаар сараас эхлэн саарч, улмаар тасралтгүй буурах хандлагатай болсон юм. Ийнхүү нэг талаас нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт эрс буурч, нам бөгөөд тогтвортой түвшинд байгаа бол, нөгөө талаас төлбөрийн тэнцлийн хүндрэлийн үед эдийн засгийг зөөлөн газардуулах бодлогыг 2013-2014 онуудад хэрэгжүүлсний үр дүнд төгрөгийн гадаад валютын харьцах ханш сулрах суурь дарамт буураад байна. Ингэснээр валютын зах тогтворжин, инфляци дахь ханшийн өөрчлөлтийн шууд буюу шууд бус нөлөөлөл нь 2014 оны сүүлийн хагасаас эхлэн буурч байгаа бөгөөд 2015 онд жилийн инфляци зорилтот түвшинд хүрч буурахаар хүлээгдэж байна.

Хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляци 2012 онд 19.9% байсан бол 2013 онд 14.0%, 2014 онд 6.9% болж буурсан. Үүний дотор махны үнийн өсөлт 2012 онд 43.7% байсан бол 2013 онд 10.5%, 2014 онд -0.5% болж огцом буурчээ. Харин төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралаас шалтгаалсан төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт, Хөгжлийн банкнаас хийсэн төсөвтэй адилтгах зарцуулалт, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөгөөр бусад бараа, бүтээгдэхүүний үнийн жилийн өсөлт 2012 оны төгсгөлд 13.7%, 2013 оны эцэст 11.7% хувь байсан бол 2014 оны 7 дугаар сард 17.4% болж хамгийн өндөр түвшиндээ хүрсэн хэдий ч, 2014 оны эцэст 12.5% болж эргээд буурсан үзүүлэлттэй гарлаа. Энэ нь макро тогтвортой байдлыг хангах, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор 2014 оны 7 дугаар сараас эхлэн мөнгөний бодлогын төлвийг алгуур чангаруулсны үр дүнд бий болсон эерэг өөрчлөлт юм.

Монголбанк Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлогыг 2012 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд дунд хугацааны хөтөлбөрүүдийг анх төлөвлөсний дагуу зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой механизмд шилжүүлэх, улмаар Монголбанк хөтөлбөрөөс 2015 онд гарах зарчмыг баримтлан ажиллав.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 2-р сарын 7-11-ний өдрүүдэд хуралдаж, Бодлогын хүүг 10.5%-д хэвээр үлдээх, олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан. Бодлогын энэхүү арга хэмжээ нь нэг талаас эдийн засгийн бодит секторын идэвхжлийг дэмжих, нөгөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив огцом буурсан, төлбөрийн тэнцлийн дарамттай байсан орчинд гадаад валютын урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой байв. Суурь инфляцийн түвшин 2013 оны 11 дүгээр сараас эхлэн нэмэгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурах хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй байсан тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 7-р сарын 30-ны ээлжит хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн, 12.0 хувь болгох шийдвэр гаргасан. Энэхүү арга хэмжээ нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилготой байлаа.

Энэхүү шийдвэрийн нөлөөгөөр нийт эрэлт, урсгал тэнцлийн алдагдал буурч, жилийн инфляци 2014 оны 8 дугаар сараас эхлэн тасралтгүй буурах хандлагатай болсон.

Монголбанк Засгийн газартай хамтран ажиллах хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох,

төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой байв. Түүнчлэн, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах, дотоодын аж ахуйн нэгжид учирч байгаа эрсдэл, ачааллыг бууруулах, санхүү, эдийн засгийн эрсдлээс сэргийлэхэд чиглэсэн УИХ-ын тогтоол, шийдвэр гаргуулах, баримт материалын төсөл, санал боловсруулах чиглэлээр Засгийн газар, Ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллалаа.

Мөнгөний болон төсвийн бодлогын харилцан уялдааг сайжруулах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 129/133 дугаар хамтарсан тушаалаар “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг баталсан байдаг. Уг журамд Сангийн яам төсвийн гол үзүүлэлтүүдийн төсөөлөл болон Төрийн сангийн нэгдсэн данс (ТСНД)-ны орлого, зарлагын гүйлгээний таамаглал, бодит гүйцэтгэлийг 7 хоног, сар, улирлын давтамжтайгаар Монголбанкинд хүргүүлж байхаар заасан. Түүнчлэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 3-р сарын 28-ны өдрийн хуралдаанаар дээрх журмын хэрэгжилтийг Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ийг хамруулан сайжруулах, Эдийн засгийн хөгжлийн яам (хуучин нэрээр), МУХБ нь холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж, нэгдсэн мэдээллийг Сангийн яамнаас Монголбанкинд хүргүүлж байхаар шийдвэрлэсэн. Энэ нь мөнгөний бодлогын шийдвэрт улсын төсөв, МУХБ-ны мэдээллийг цаг алдалгүй авч ашиглах, мэдээллийн хоцрогдол, тодорхой бус байдлыг бууруулах боломжийг олгох юм.

Монголбанк эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөх, эдийн засгийн бодит салбарыг дэмжих зарим арга хэмжээг Засгийн газартай хамтран боловсруулж хэрэгжүүлсэн. Үүнд:

- Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас хараат байдлыг бууруулах замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зорилтын хүрээнд Монголбанкнаас *“Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх, санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх”* бодлогын судалгааг мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг хамруулан 2014 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд ноос ноолуур, арьс шир боловсруулах, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар ашигт малтмалын бус салбарын экспортын тогтвортой орлогыг бий болгох нь тэргүүний зорилт гэж тодорхойлсон болно.


Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2014.03.04-ний өдрийн хурлын тэмдэглэл, Монгол Улсын Засгийн газрын 2014.03.21-ний өдрийн 87 дугаар тогтоолын хүрээнд Монголбанкнаас ХХААЯ, СЯ-тай хамтран ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх (НҮДЭН) арга хэмжээний схем, НҮДЭН арга хэмжээг хэрэгжүүлэх журам, Засгийн газрын батлан даалтын гэрээ, Монголбанкнаас банктай байгуулах зээлийн гэрээ, зээлийн эх үүсвэрийг олгох, буцаан төлүүлэх, хяналт тавих механизм, аргачлалыг тус тус боловсруулан баталж, Засгийн газар холбогдох шийдвэрийг гарган, хэрэгжүүлж ажиллав.

Арга хэмжээний үр дүнд самнасан ноолуурын үйлдвэрлэл, экспортын орлого нэмэгдэж, 2014 оны төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх, үйлдвэрүүдийн тогтвортой үйл ажиллагаа хангагдан ажлын байрууд хадгалагдах богино хугацааны үр дүн бий болсон. Харин дунд хугацаанд хөдлөх хөрөнгийг барьцаалж, ноолуурын түүхий эдийн агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн бий болгох, үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа бэхжих, үйлдвэрлэлээ өргөтгөх, ашигт малтмалын бус салбарын экспорт өсөн нэмэгдэх үр дүн хүлээгдэнэ.

Арга хэмжээг хэрэгжүүлсэн алхмууд:

1. Хөдөө аж ахуйн түүхий эдийн бирж (ХААБ)-ийн брокерууд малчдаас түүхий ноолуур худалдан авах буюу малчид ноолуурын түүхий эдийг брокеруудаар дамжуулан ХААБ-д арилжаална.
2. Ноолуурын үйлдвэрүүд хөрөнгөө барьцаалж, түүхий эд бэлтгэлд зориулан банкуудаас T^* хэмжээний зээл авна.
3. Монголбанкнаас банкуудтай зээлийн гэрээ байгуулж, ноолуурын түүхий эдийн агуулахыг санхүүжүүлэх зорилготой зээлийг нийт хэрэгцээт санхүүжилтийн 70-80%-тай тэнцүү хэмжээгээр, гурван үе шат ($T(wf), 1-3$ -г)-тайгаар олгоно.
4. Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд зах зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор Засгийн газраас банкуудад баталгаа гаргана. Баталгааны хэмжээ нь Монголбанкны зээлийн эх үүсвэрийн 50%-тай тэнцүү байна.
5. Үйлдвэрүүд агуулах дахь A^* үлдэгдлийг барьцаалан дараагийн зээлийн санхүүжилтийг банкнаас авна. Ингэхдээ ХХААЯ (төслийн нэгж) болон агуулахын үлдэгдэл, хөдөлгөөнд хөндлөнгийн хяналт тавих байгууллагаас агуулахын үлдэгдэл, түүхий эдийн чанарыг баталгаажуулсан сертификатыг банкинд гаргана. Үйлдвэрүүд банкинд вексель бичиж өгнө. Агуулах дахь түүхий эдийн үлдэгдлийг барьцаалж зээл авах схемээр үйлдвэрүүд $A(wf)$ хэмжээний нэмэлт түүхий эдийг бүрдүүлэх бөгөөд $A^* + A(wf)$ хэмжээний нийт түүхий эдийг зөвхөн боловсруулж экспортлох зорилгоор ашиглана. Үйлдвэрлэгчдийг төлөөлсөн брокер нь үйлдвэрлэгчдийн харилцан тохиролцсон үнэ (fixed price)-ээр ХААБ дэх бусад брокеруудтай хэлцэл хийх бөгөөд ингэснээр зах зээлд үнэ огцом хөөрөгдөхгүй байх нөхцөлийг хангана. Брокер нь түүхий ноолуур худалдан авах, худалдан авсан түүхий эдийг үйлдвэрлэгчийн агуулахад хүргүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.
6. Засгийн газар самнасан ноолуурын экспортод баталгаа гаргах буюу экспортлох үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулна.
7. Үйлдвэрүүд экспортын орлогоос зээлээ бүрэн хаана. Банкууд Монголбанкнаас авсан зээлийн эх үүсвэрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж барагдуулна.

Зураг 35: НҮДЭН арга хэмжээний схем



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү арга хэмжээний үр дүнд 2014 онд ямааны самнасан ноолуурын экспортын биет хэмжээ 13%-иар, мөнгөн дүн 10%-иар тус тус өссөн бөгөөд цаашид хувийн хэвшил хөдлөх хөрөнгийн агуулах дахь үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг ашиглаж хэвших, хөгжүүлэх боломж бүрдэж байна. НҮДЭН арга хэмжээг 2015 оноос ХХААЯ, Хөгжлийн банкнаас хувийн хэвшил (банкууд, ноолуурын үйлдвэрүүд)-тэй хамтран үргэлжлүүлэх нь зүйтэй.

Үүний сацуу Монголбанкнаас ХХААЯ, Дэлхийн банкны ОУСК-тай хамтран ХАА-н салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үнэ цэнийн сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, дутагдалтай тал, сайжруулах арга зам, ирээдүйн чиг хандлагын талаар хэлэлцэх, салбарын оролцогчдыг мэдлэг, мэдээллээр хангах, санхүүжилтийн шинэлэг арга хэрэгслүүдийг танилцуулах, улмаар нэвтрүүлэхэд чиглэгдсэн “ХАА-н санхүүжилтийн шинэ арга, хэрэгслүүд” (цахим холбоос нь <http://www.mongol-bank.mn/conference/index.html>) сэдэвт анхдугаар зөвлөгөөнийг 2014 оны 4 дүгээр улиралд зохион байгуулсан.

- УИХ-аас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монголбанк болон банкуудад тушаагдах алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5% болгон бууруулсан нь дотоодын алт олборлолт, тушаалтыг нэмэгдүүлэх эерэг өөрчлөлт болсон билээ. Гэхдээ дэлхийн зах зээл дэх алтны үнэ буурсан, Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оноос огцом багассан, төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн улмаас дотоодын аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн эх үүсвэрийн дутагдал бий болсон зэрэг нь алт олборлолтод сөргөөр нөлөөлж байв. Иймд алтны салбарын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, алтны үнийн эрсдлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах замаар 2014 онд алт олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Монголбанк, УУЯ, ЭЗХЯ (хуучин нэрээр) хамтран “Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ”-г 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хамтарсан тушаалаар баталж, хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно. Арга хэмжээг хэрэгжүүлэх механизм, банктай байгуулах гэрээ, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл хийх зааврыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн А-75 дугаар тушаалаар баталсан.

Арга хэмжээний эхний шатны хүрээнд нийт 9 байгууллагаас 75 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт банкуудад ирсэн боловч батлагдсан арга хэмжээний 4 дэх бүлэг, Монголбанкны чиг үүргийн 7-д заасан эрх үүргийн дагуу арга хэмжээний хүрээнд санхүүжилт олгох нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн зорилтод сөргөөр нөлөөлнө гэж үзсэн тул хэрэгжилтийг түр хугацаагаар хойшлуулсан. 2014 оны 9 сараас гадаад худалдааны тэнцэлд эерэг өөрчлөлтүүд гарсантай холбоотойгоор арга хэмжээг эхлүүлэх саналыг тушаалын төслийн хамтаар ЭЗХЯ, УУЯ-д хүргүүлсэн хэдий ч, Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр Засгийн газар байгуулах асуудлаас шалтгаалан хэрэгжилт нь хойшилсон болно.

Дээрх арга хэмжээг 2015 оноос СЯ, УУЯ, Хөгжлийн банкнаас хувийн хэвшил (банк, алт олборлогч компаниуд)-тэй хамтран хэрэгжүүлж, алт олборлолт, тушаалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

- Монголбанк гадаад валютын орох урсгалыг дэмжих, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих зорилгоор “урт хугацаат своп хэлцэл”-ийг банкуудад нэвтрүүлсний зэрэгцээ Хятадын Ардын банктай 2011 онд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн хугацааг 2017 оны 5 дугаар сар хүртэл 3 жилээр сунгаж, хэмжээг нь 15 тэрбум юань болгож нэмэгдүүлсэн. Энэхүү хэрэгсэл нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлж, эдийн засгийг зөөлөн газардуулахад чухлаар нөлөөллөө. Цаашид своп хэлцлийн хугацааг тогтмол сунгаж, хэмжээг нь хоёр орны гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байдалтай уялдуулан нэмэгдүүлэх зарчмын чиглэлийг хоёр орны төв банкууд тууштай баримталж байна.

“Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөр

Монголбанк зээлийн хүү өндөр түвшинд тогтоход нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг бууруулах, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн таатай орчныг бий болгох замаар зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх зорилго бүхий хөтөлбөрийг анх Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (хуучин нэрээр)-ны даргын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 677/229/188/142 тоот хамтарсан тушаалаар баталж, 2013 оныг дуустал хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд тус хөтөлбөрийн хүрээнд инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг үндсэн 4 чиглэлээр тодорхой зорилтууд тавьж хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна:

- *Зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилтийг дэмжих зорилгоор Монголбанкнаас бодлогын дараах арга хэмжээг авсан.*

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны 1 дүгээр сарын 25, 4 дүгээр сарын 8, 6 дугаар сарын 25-ны өдрүүдэд тус тус хуралдаж мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжилтийг дэмжих үүднээс мөнгөний бодлогын хүүг 13.25%-иас шат дараалан (3 үе шаттай) бууруулан 10.5%-д хүргэсэн. Мөнгөний бодлогын зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 11-ний хуралдаанаар макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг хангах хүрээнд мөнгөний бодлогын хүүг 10.5%-д хэвээр байлгах, түүнчлэн олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрүүдийг тус тус гаргасан. Эдгээр нь нэг талаас тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих, эдийн засгийг зөөлөн газардуулах макро бодлогыг үргэлжлүүлж, бодит секторын идэвхжилтийг дэмжих, нөгөө талаас эдийн засаг дахь урт хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэрүүд байв. Харин мөнгөний бодлогын зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдэх хүртэл макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12% болгосон. Харин мөнгөний бодлогын зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн, 12.0 хувь болгох шийдвэр гаргаад байна.

Дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүгийн коридорыг 2013 оны 2 дугаар сарын 27-нд шинээр нэвтрүүлснээр банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, хүүний хэлбэлзэл буурах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах суурь нөхцөл бүрдэхийн зэрэгцээ Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурч, 2013-2014 оны эдийн засгийн идэвхжилд эергээр нөлөөлсөн.

- *Хэрэглээний үнийн индекст голлох нөлөөтэй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлж, оновчтой хуваарилан, нийлүүлэлтийг жигд хангаж, үнийн хэлбэлзлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлсэн.*

Монголбанк эрэлтийн инфляцийг бага байлгахын зэрэгцээ Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулах чиглэлд ажиллаж, нийлүүлэлтийн гаралтай инфляци үүсэх хүчин зүйлсийн үндсэн шалтгааныг арилгах, мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг хэрэглээний суурь барааны нийлүүлэлтийг сайжруулах замаар үнийн өсөлтийг нь тогтворжуулах, дунд хугацаанд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлэх

зорилго бүхий “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэв. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд нийлүүлэлтийн гаралтай инфляци мэдэгдэхүйц буурч, хөтөлбөрт хамрагдаж буй бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нь өмнөх онуудтай харьцуулахад үлэмж буураад байна. Тухайлбал, хөтөлбөрт хамрагдах барааны инфляци 2010-2012 оны дунджаар нийт инфляцийн 33.4%-ийг бүрдүүлдэг байсан бол 2013 онд 18%, 2014 онд 4.5% болж буурлаа.

- *Банкуудын зээлийн журам, түүний хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах болон зээлдэгчдэд учрах хүү, шимтгэлийн дарамтыг багасгах чиглэлээр холбогдох арга хэмжээ авсан.*

Монголбанкнаас ажлын хэсэг байгуулж, 2012 онд банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн байдал, хүү тооцох аргачлал зэргийг бүх банкууд дээр очиж шалгалт хийсэн. Шалгалтын дүгнэлтэд үндэслэн “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” болон “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү болон үнэт цаасны өгөөж, хямдруулалтын хувь хэмжээг бодох ерөнхий аргачлал”-ыг тус тус боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар баталсан.

- *Зээлийн мэдээллийн санг өргөтгөх ажлын хүрээнд төрийн эрх бүхий байгууллагатай холбогдох, тэдгээрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, түүнд банк, санхүүгийн байгууллагууд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн.*

Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр 2014 оны эцсийн байдлаар нийт 14 банк, 197 банк бус санхүүгийн байгууллага, 58 хадгаламж зээлийн хоршоотой мэдээлэл солилцож байна. Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр одоогийн байдлаар нийт 13 банк, 166 банк бус санхүүгийн байгууллага, 48 хадгаламж зээлийн хоршоотой мэдээлэл солилцож байна.

- *Мөнгөний захын хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, жишиг хүү болон өгөөжийн муруйг бий болгох үүднээс Засгийн газрын богино, дунд, урт хугацаат дотоодын үнэт цаасны арилжааг тогтмолжуулсан.*

Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, арилжааг тогтмол хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 111/А-105/131 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг тус тус баталсан.

Улмаар Засгийн газрын үнэт цаасны арилжааны цахим систем (платформ)-ийг ашиглан 12, 28, 52 долоо хоногийн богино хугацаатай, 3, 5, 10 жилийн урт хугацаатай үнэт цаасыг шууд болон шууд бус оролцогчдод арилжаалж байгаа бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны платформоор арилжаалагдсан богино хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 786.8 тэрбум төгрөг, дунд, урт хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 1351.2 тэрбум төгрөг байв. 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар богино хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 566.2 тэрбум төгрөг, урт хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл нийт 1206.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ-ыг арилжаалжээ.

- *Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн.*

“Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11

дүгээр сард дууссантай холбогдуулан Монголбанк, Засгийн газар, СЗХ-ноос хамтран “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийг УИХ-аар 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр шинээр батлуулсан.

- *Зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор зээлийн даатгал, баталгаа, батлан даалтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчин бүрдсэн.*

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль”-ийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Энэхүү хууль батлагдсанаас хойш зээлийн батлан даалтын сан байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулж жигдрүүлэх ажлууд хийгдсэн.

- *Хувь хүн болон компанийн зээлийн түүхийн мэдээллийн сангийн найдвартай байдал, үйл ажиллагааг сайжруулж, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.*

Зээлийн мэдээллийн чанар агууламжийг сайжруулах, зээлийн мэдээллийн лавлагааг түгээх сувгийн хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн “Зээлийн мэдээллийн тухай хууль” батлагдсан. Хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээллийг хадгалах, боловсруулах зэрэгт нууцлал, аюулгүй байдлын талаарх тодорхой шаардлагууд тавигдаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдалд тавих хяналт, хариуцлагыг тодорхой болгосон. Түүнчлэн, тус хуулийн хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн байгууллага эрхлэх боломжтой болж байгаатай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-197 дугаар тушаалаар “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг баталсан.

- *“Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2013-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийн талаар*

2011-2013 онуудад хэрэгжсэн “Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн үргэлжлэл болгон “Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийн эхний төслийг Монголбанк анх 2013 оны эхний хагаст холбогдох байгууллага, газруудаас санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж, түүнийг батлах тухай хамтарсан тушаалын хамт хүргүүлж, ЭЗХЯ-аас бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаар батлуулаад байсан ч хараахан албажаагүй байсан юм. Иймд 2014 оны 6 дугаар сард УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн даалгаврын дагуу хөтөлбөрийн төсөлд ЭЗБХ-ны Ажлын хэсгээс чиглэл болгосон зарим заалтуудыг нэмж тусган, шаардлагатай мэдээллийг шинэчлэн боловсруулсан. “Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийг Монголбанкны Ерөнхийлөгч, Эдийн засгийн хөгжлийн сайд (хуучин нэрээр), Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А-137/67/187/232 тоот хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн бусад байгууллагыг хадгаламжийн даатгалын тогтолцоонд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, банк болон бусад санхүүгийн байгууллагын зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах, банкны зээл олгохтой холбоотой шимтгэл хураамжийн зардлыг бууруулах зэрэг ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлжээ.

Монголбанк дээрх хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн

ил тод байдлын журам"-ыг боловсруулан, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12-р сарын 13-ны өдрийн тушаалаар баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдүүлсэн. Уг журмын дагуу банкуудын зээл, хадгаламжийн хүү, шимтгэл хураамжийн мэдээллийг банк тус бүрээр харьцуулсан байдлаар сар бүр, бүтээгдэхүүний төрөл тус бүрээр Монголбанкны цахим хуудаст нийтэлдэг болсон билээ. Ингэснээр банкны харилцагчдад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг ил тод байлгах, банкуудын зээлийн хүүг харьцуулах боломжийг харилцагчдад олгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкуудын хүүгийн өрсөлдөөнийг дэмжих замаар зээлийн хүү буурах орчныг сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2014 оны 3 дугаар сард банкуудын тэтгэврийн зээлийн нөхцөл, хүү тооцож буй аргачлалыг шалгаж, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй зарим банкинд улсын байцаагчийн акт тогтоох, биелэлтийг хангуулах арга хэмжээ авсан. Мөн энэхүү журам батлагдсантай уялдан банкуудын ажилтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчидтэй 2014 оны 2 дугаар сард зээлийн бодит өртгийн талаар ярилцлага, уулзалт, сургалтуудыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна банкуудын хүү, шимтгэл өөрчилсөн шийдвэрт хяналт тавин ажиллав.

Монголбанк хадгаламжийн даатгалын системийг бүрэн нэвтрүүлэх хүрээнд 2013 онд УИХ-аар батлуулсан “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн хэрэгжилтийг Хадгаламжийн даатгалын корпоративтай хамтран хангаж, тус системийг нэвтрүүлэх ажлыг хийж байгаа болно.

Банкуудын төгрөгийн жигнэсэн дундаж зээлийн хүү 2014 оны 12 дугаар сарын байдлаар Монголбанкнаас 2013 оноос эхлэн эдийн засгийг тогтворжуулах, зөөлөн газардуулах зорилготой мөнгөний уламжлалт бус бодлого, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зээлийг оруулснаар 16.9%, оруулалгүй тооцвол 19.5% байна. Гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2014 оны эцэст 12.9% болж, жилийн өмнөх үеэс 0.2 нэгж хувиар нэмэгджээ.

Бичил, жижиг дунд бизнесийн санхүүжилт

Тогтвортой болон оролцоотой санхүүжилт, байгаль орчин, ногоон бизнесийн санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд Монголын банкуудын холбоо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай хамтран тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг нь “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөө хамтарсан тунхаг бичиг”-ийг боловсруулж, банкуудтай хамтран ажиллан “Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмуудын удирдамж”-ийг боловсруулсан. Банкууд тогтвортой санхүүжилттэй холбоотой бодлого, журам, үнэлгээний стандартыг бий болгон, энэ хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын зохицуулалтын дагуу зээлийн үнэлгээ хийж, Монголбанкнаас уг үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллах юм.

Монголбанк бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, байнгын, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай хамтран “Тол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2012 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлсэн бөгөөд энэ хүрээнд жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг мөн дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 5 дэд хөтөлбөрийн хүрээнд банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 240 орчим аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээл олгожээ. Мөн банкууд орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зориулж 114 компанид Монголбанкны зээлийн эх үүсвэрээр зээл олгосон байна. Эдгээр арга хэмжээ нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийн үед эдийн засгийг зөөлөн газардуулах болон хувийн хэвшилд ирэх байсан огцом агшилтын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чухал дэмжлэг болсон юм.

Монголбанкнаас банкуудаар дамжуулан олгох төслийн зээлүүдийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгон ажиллаж байна. Тухайлбал, ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банк (КФВ)-ны санхүүжилттэй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хүрээнд Монголбанк 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 45 ЖДҮ эрхэлдэг аж ахуйн нэгжид 6.44 сая еврогийн зээл банкуудаар дамжуулан олгосон байна.

Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2014 онд 8 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд 1.17 тэрбум төгрөгийн зээлийг төсөлд оролцогч банкуудаар дамжуулан шинээр олгосон бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкуудад олгосон нийт зээлийн үлдэгдэл (9 аж ахуйн нэгжийн) 1.19 тэрбум төгрөг байна. Уг төслийн хүрээнд 2014 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 283 ажлын байр шинээр бий болжээ.

Монголбанк хөдөө орон нутаг дахь бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах боломжийн талаар 13 аймгийг хамарсан түүвэр судалгаа хийв.


Шигтгээ 4. Мөнгөний бодлогын арга хэрэгслүүд ба хүүний коридор

Монголбанк 2013 оны 2 дугаар сард 4 нэгж хувийн өргөнтэй, мөнгөний бодлогын хүүнээс $\pm 2\%$ -ийн хооронд дээд ба доод хязгаар нь тодорхойлогддог хүүний коридорыг нэвтрүүлсэн билээ. Хүүний коридорын дээд, доод хязгаар нь Монголбанкны бодлогын хүүнээс шууд хамаарч тогтоно. Тухайлбал, хүүний коридорын дээд хязгаар нь овернайт репо санхүүжилтийн хүү, харин доод хязгаар нь овернайт хадгаламжийн хүү байна.

Монголбанкны овернайт репо санхүүжилт гэдэг нь заавал байлгах нөөц (ЗБН)-ийн шаардлага хангахгүй байгаа банкинд клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар олгож байгаа зээл бөгөөд түүний хүү нь 2014 оны эцсийн байдлаар мөнгөний бодлогын хүү (12.0%-н дээр нэмэх нь 2 нэгж хувь буюу 14.0%-тай тэнцүү байв.

Харин ажлын өдрийн төгсгөлд банкууд илүүдэл нөөцөө Төв банкны овернайт хадгаламжинд байршуулж өгөөж олох боломжтой ба түүний хүү нь 2014 оны эцсийн байдлаар мөнгөний бодлогын хүү (12%-нээс хасах нь 2 нэгж хувь буюу 10.0%-тай тэнцүү байлаа.

Зураг 36: Монголбанкны хүүний коридор (2014 оны 3-12 дугаар сард)



Банкуудын өөр хоорондоо зээл өгч, авч байгаа хүүг банк хоорондын зах (БХЗ)-ын хүү гэдэг. БХЗ-ын хүү нь Монголбанкны мөнгөний бодлогын хүүг дагах ба ингэхдээ хүүний коридор дотор хэлбэлзэнэ. БХЗ дээр зээл хайж буй банк хүссэн үедээ овернайт репо санхүүжилтийг Төв банкнаас 14.0%-иар авах боломжтой ба үүнээс илүү хувиар авахгүй билээ.

Эх сурвалж: Монголбанк


Нөгөө талаас зээл олгож буй банк илүүдэл нөөцөө Төв банкинд 10.0%-ийн овернайт хадгаламжид байршуулах боломжтой тул үүнээс доогуур хувиар хэлцэл хийхгүй.

Ийнхүү хүүний коридорыг нэвтрүүлэх нь богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах үндсийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн тогтвортой байдал

Санхүүгийн тогтвортой байдал нь макро эдийн засгийн бодлогууд, санхүүгийн салбарын эрх зүйн орчин, микро, макро зохистой бодлого зэрэг өргөн цар хүрээнд эдгээрийн харилцан уялдаагаар тодорхойлогддог ойлголт тул нийтээр зөвшөөрөгдсөн цор ганц тодорхойлолт өнөө хэр байхгүй байгаа юм. Хэдий тийм боловч ерөнхий утгаар нь авч үзвэл санхүүгийн тогтвортой байдал гэдгийг санхүүгийн систем (i) санхүүгийн зуучлалыг үр ашигтайгаар гүйцэтгэх, (ii) эрсдэлийг оновчтой тараан байршуулах, (iii) төлбөр, тооцоог тасралтгүй гүйцэтгэж байх гэсэн үндсэн үүргээ нийгмийн томоохон зардалгүйгээр хэвийн гүйцэтгэж байх төлвийг ойлгож болдог. 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нь санхүүгийн салбарын бодит эдийн засагт үзүүлэх нөлөө, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн салбарын тэнцвэртэй хөгжлийг дэмжихийн ач холбогдлыг өндөрсгөж, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ макро болон микро зохистой бодлого хэрэгжүүлэгч институцийн оновчтой бүтэц, чадамжийг бий болгохын ач холбогдлыг өсгөсөн.

Зураг 37: Улс орнуудын төв банкны тухай хуулинд санхүүгийн тогтвортой байдал болон түүнтэй ойролцоо утгатай үг, заалт дурдагдсан байдал



Эх сурвалж: ОУТБ 114 орны төв банкны тухай хууль

нэг дэх хэсэгт Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлтэй холбоотой “Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ажиллана” гэж тус тус заасан байдаг. Монголбанк хуулиар заасан үүргийг хэрэгжүүлэх хүрээнд банкуудад тогтмол хяналт шалгалт хийж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж байна. Энэ нь банк төвтэй санхүүгийн салбар бүхий манай оронд нийт санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах бодлогын тэргүүлэх чиглэл болдог.

Манай улсад санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргийг хуулийн дагуу Төв банк (Монголбанк), Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэсэн 3 институци хүлээсэн байдаг. Тухайлбал “Төв банкны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ”, 27.2 дугаар зүйлийн

Монголбанк төлбөрийн тэнцлийн огцом цочрол, хүндрэл бүхий 2013-2014 онд банкуудад хяналт шалгалтыг тогтмол хийхийн зэрэгцээ санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болох, мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд огцом агших, улмаар эдийн засагт хямрал нүүрлэх эрсдэлтэй байсан үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд макро/микро зохистой бодлогын арга хэмжээг 2012 оноос хойш тогтмол авч хэрэгжүүлж ирсэн. Санхүүгийн салбарыг болзошгүй эрсдлээс сэргийлэх чиглэлд хэрэгжүүлсэн мөчлөг сөрсөн бодлогууд болон дотоод актив чанаргүйдэх эрсдлийг бууруулах арга хэмжээний үр дүнд санхүүгийн салбарт системийн шинжтэй эрсдэл бий болохоос урьдчилан сэргийллээ.

Банкны салбарын хяналт шалгалт, санхүүгийн тогтвортой байдалд чиглэсэн арга хэмжээ

Монголбанкнаас 2014 оны эцсийн байдлаар нийт 13 банкинд иж бүрэн, 1 банкинд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Шалгалтын мөрөөр гарсан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж байна.

Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан *“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”*, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар баталсан *“Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”* болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг цаашид хэрхэн хангах, банкны үйл ажиллагаанаас болон нийт банкны систем, эдийн засгийн нөхцөл байдлаас үүсч болзошгүй эрсдлийг урьдчилан таамаглах зорилгоор Монголбанкнаас банкуудаар мэдрэмтгий байдлын шинжилгээ (stress test)-г хийлгэж хэвшүүлэхээр ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлох үүднээс 2014 оны I, III улиралд зээлийн эрсдэл, том зээлдэгч, ханшийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэсэн 4 чиглэлд мэдрэмтгий байдлын шинжилгээг хийж, гарсан үр дүнг цаашид баримтлах бодлогод тусган ажиллаж байна. Түүнчлэн зээлийн эрсдлийн, гадаад валютын ханшийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын мэдрэмтгий байдлын шинжилгээний загварыг олон улсын зөвлөхтэй хамтран боловсруулж, системийн бүх банкуудаар гүйцэтгүүлж, үр дүнг танилцуулсан бөгөөд цаашид шинжилгээний загварыг улам боловсронгуй болгохоор банкуудтай хамтран ажиллаж байна.

Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг боловсронгуй болгох зорилгоор тэдгээрийн хоорондын уялдаа, хэрэгжилтэд учирсан хүндрэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд өөрчилж шинэчлэх ажлын хүрээнд Монголын банкуудын холбоо, банкууд болон бусад холбогдох байгууллагаас ирүүлж буй банкны үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын саналыг нэгтгэн судлав. Мөн *“Банкны зөвшөөрлийн журам”* болон *“Банкны нэгжсийн журам”*-д оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулсан бөгөөд шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Банкныг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нь ангилж, *“Төрөлжсөн үйл ажиллагаатай банкны журам”*-ын төслийг боловсруулан, холбогдох газруудаас санал авч, журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.

Монголын банкны салбарт үүсч болзошгүй эрсдлүүд, ялангуяа ханшийн болон зээлийн эрсдлээс сэргийлэх, нөлөөллийг бууруулах макро зохистой бодлогын боломжит хэрэгслүүдийн талаарх судалгааг хийсэн бөгөөд судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн *“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, түүнд хяналт тавих журам”*-д активын эрсдлийн жин болон өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах саналыг

боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар баталж, 2015 оноос эхлэн мөрдүүлэхээр тогтов. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр тушаалаар “*Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах, зарцуулах журам*”-д нэмэлт өөрчлөлт оруулж, хэвийн зээлд 1 хувийн эрсдлийн сан байгуулах зохицуулалтыг шинээр бий болголоо.

Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан хэлбэрээс эрсдлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай байгаа тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхийг эрсдэл өндөртэй байгаа үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улмаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг бууруулах зохицуулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гарын авлага боловсруулахаар тус асуудлаар мэргэшсэн олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмын төслийг урьдчилсан байдлаар боловсруулаад байна. Түүнчлэн одоо ашиглаж буй “*Хянан шалгагчийн гарын авлага*”-ыг эрсдлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын зарчимтай нийцүүлэх судалгааны ажил хийж байна.

“*Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги*”-ийн төслийг боловсруулж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасантай холбогдуулан Базелийн цуврал стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг судалж байна. Энэхүү цуврал стандартыг нэвтрүүлснээр нийт банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулж, хяналт шалгалтын олон улсад мөрдөгдөх стандартад нийцсэн хяналт, зохицуулалтын аргачлалыг ашиглах боломж бүрдэнэ. Түүнчлэн банкуудад мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж дууссан бөгөөд Сангийн яамтай хамтран батлуулахаар хүргүүлээд байна. Мөн багц материалыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тайлан нэгтгэлийн ФИНА системийг нэвтрүүлж, бүх банкуудын тайланг хүлээн авч туршиж байна.

Банкны үйл ажиллагаанд сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийг төлөвшүүлэх зорилгоор “*Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам*”-ыг Компанийн засаглалын хөгжлийн төв болон Азийн хөгжлийн банктай хамтран олон улсын стандартын үндсэн зарчмууд, “*Монголын Компанийн засаглалын VII чуулган*”-ын үеэр зохион байгуулагдсан “Банкны зохистой засаглалын зарчим” хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжид нийцүүлэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар баталсан бөгөөд биелэлтийг хангаж ажиллахыг бүх банкуудад үүрэг болгосон болно. Мөн банкны зохистой засаглалыг сайжруулах, хэрэгжилтийг үнэлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран хэд хэдэн сургалт зохион байгуулж, журмын төслийн талаар танилцуулга хийгээд байна.

Банкны салбараас алслагдсан, санхүүгийн мэдээлэл багатай, ялангуяа хөдөө, орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг үр ашигтай болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “*Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам*”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-236 тоот тушаалаар баталсан. Энэхүү журмын дагуу банкуудын хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд шаардлагатай мэдээллийг тогтмол түгээж байна.

Уг журмын хэрэгжилт нь нийтэд ижил, тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах ажлуудыг шалгах, хөдөө, орон нутагт олгогдож байгаа зээлийн нөхцөлийг газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор орон нутгийн банкуудад хэсэгчилсэн шалгалтыг 2014 оны 5, 6-р саруудад хийсэн. Мөн орон нутаг дахь санхүүгийн хүртээмж ямар түвшинд байгааг судлах зорилгоор 13 аймаг дахь иргэд, аж ахуйн

нэгжүүдээс түүвэрлэлт хийн, санхүүгийн хүртээмжийн судалгааг авав. Шалгалт болон түүвэр судалгааны үр дүнг 2014 оны 4-р улиралд нэгтгэн боловсруулж, үнэлгээ дүгнэлт хийгдэж байна.

Банкуудын үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх, хэрэв төр, захиргааны байгууллагаас шалтгаалж банкны үйл ажиллагааны зардал нэмэгдэж байгаа бол тэр чиглэлд холбогдох арга хэмжээг авах, банкуудад зөвлөмж өгөх чиглэлээр Монголбанк ажиллаж байна. Түүнчлэн, банкуудын үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн талаар Монголын банкуудын холбооноос санал авах, банкнаас өөрөөс нь шалтгаалж бий болдог зардал болон иргэд, харилцагчид дээр ирдэг зардлын бүтцэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэх арга хэмжээ авахаар ажиллаж байгаа болно.

Монголбанк Хөдлөх хөрөнгө, эрхийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль, Эрхийн улсын бүртгэлийн багц хуулийн төсөлд УИХ, Хууль зүйн яамтай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулан, Монголын банкуудын холбоо, банкууд болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж саналыг нэгтгэсэн. Мөн эдгээр хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсантай холбоотойгоор уг төслийн үзэл баримтлалын төслийг 2014 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд ажлын хэсэг хуулийн төслийг эцэслэн боловсруулж дуусаад байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийг боловсруулан, бүх яамд, байгууллагуудад хүргүүлж, санал авч нэгтгэн 2014 оны 12 дугаар сарын 3-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Санхүүгийн салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх бодлогын баримт бичгийг олон улсын санхүүгийн байгууллагуудын техник туслалцаатайгаар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам (хуучин нэрээр), Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагатай хамтран боловсруулахаар ажиллав. Энэ хүрээнд Монголбанкнаас Дэлхийн банкинд санал тавьж, хамтарсан ажлын хэсгийг СЯ, ЭЗХЯ, СЗХ-той хамтран байгуулах ажлыг эхлүүлсэн. Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох чиглэлээр Монголын ипотекийн корпораци (МИК)-тай хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд ипотекийн зээлийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасжуулах зорилгоор багцлан худалдах үед баримтлах зарчмыг “Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д тусгаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Монголбанкнаас санхүүгийн зах зээлийн зохистой бүтэц, чөлөөт өрсөлдөөний орчин, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх талаар судалгаа хийж, уг асуудалд Монголбанкнаас баримтлах бодлого, зарчмын байр суурь, оролцооны хэм хэмжээг тодорхойлох зорилгоор өндөр хөгжилтэй орны Төв банкны чиг үүрэг, туршлагыг судалсан. Үүний зэрэгцээ даатгал болон хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих замаар санхүүгийн зах зээлийн олон тулгуурт бүтцийг бий болгох, улмаар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, тэдгээрийг алслагдсан бүс нутагт хүргэх чиглэлийг СЗХ-той хамтран энэхүү бодлогын баримт бичигт тусгахаар төлөвлөж байгаа болно.

Монголбанкнаас СЗХ-той хамтран кастодиан үйлчилгээг манай орны санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх зорилгоор “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч болон СЗХ-ны даргын 85/А106 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр хөрөнгийн зах зээлийн арилжааны дараах үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчийн үнэт цаасыг түүний зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах боломжийг хязгаарлах давуу талтай. Үүнээс гадна дотоодын кастодиан үйлчилгээ үзүүлэгч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн кастодиан үйлчилгээ үзүүлэгчийн дэд-кастодиан болох замаар Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бололцоо бүрдэнэ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, гадаадын хөрөнгө оруулагч нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг нэр хүнд бүхий кастодиан банкаар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын кастодиан банктай холбогдож, хөрөнгө оруулалт хийх бололцоотой болох юм.

Монголбанк санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх хүрээнд банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар, журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, хүү тооцох аргачлалыг шалгах ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэсэн. Уг шалгалтын үр дүнд Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, зээлийн бодит өртөг зардал, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах, санхүүгийн зах зээлд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд, банкуудын хүү бодох аргачлалыг боловсронгуй болгож мөрдүүлэх, хадгаламж, зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулж, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Монголбанк *“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”*-ыг шинээр боловсруулан, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтад үндэслэн баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэв. Энэхүү журамд зээлийн бодит өртөг, хадгаламжийн бодит үйлчилж буй хүүг тооцож мэдээлэх, зээл, хадгаламж, үнэт цаасны өдрийн хүү тооцох суурь хоногийг стандартчилах, нэмэгдүүлсэн хүү тооцох аргачлал, шимтгэл, хураамжийн нөхцөл, мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тодорхой тусгаж зохицуулсан. Журмыг хэрэгжүүлэх хүрээнд банкуудын хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийг 2014 оны туршид сар бүр Монголбанкнаас нэгтгэн, цахим хуудсаараа (<http://www.mongolbank.mn/liststatistic.aspx?did=10>) дамжуулан олон нийтэд мэдээлж байна. Журмыг хэрэгжүүлэх хүрээнд банкуудын хүү, шимтгэл, хураамжийн 2014 оны эхний 7 сарын мэдээллийг Монголбанкнаас нэгтгэн, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

Энэхүү журмыг баталж хэрэгжүүлснээр зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангуулах, хүүг нэгдсэн аргачлалаар тооцдог болох, хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл, хураамжийг олон нийтэд ил тод байлгах, харилцагчдыг оновчтой, зөв сонголт хийх боломжоор хангах, банкуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсний үндсэн дээр цаашид зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох юм.

Банкны салбараас алслагдсан, санхүүгийн мэдлэг муутай, мэдээлэл багатай, ялангуяа хөдөө, орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг үр ашигтай болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оны 5-6 сарын хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв: (i) орон нутаг дахь иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэрлэлт хийж, санхүүгийн хүртээмжийн талаар судалгаа хийсэн, (ii) дээр дурдсан журмын хэрэгжилт нийтэд ижил тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах зорилгоор хөдөө орон нутгийн (13 аймгийн) банкуудад хэсэгчилсэн шалгалтыг хийж, хөдөө орон нутагт олгогдож байгаа зээлийн нөхцөлийг газар дээр нь шалгасан, (iii) 2014 оны 4-р улиралд шалгалт болон түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь макро эдийн засгийн төлөв байдал, эдийн засагт учирч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, бодлогын харилцан уялдааг хангах тухай болон цаг үеийн шинжтэй бусад асуудлаар зөвлөлдөж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдааныг 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Монголбанкинд зохион байгуулсан бөгөөд

тус хуралдаанаар: (i) 2014 оны эхний 2 сарын байдлаарх макро эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшид нөлөөлсөн хүчин зүйлс, (ii) АНУ-ын иргэн, хуулийн этгээдийн “Гадаад дахь дансдын хөрөнгийг татварт хамруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар АНУ-ын зүгээс тавьсан хүсэлтийн тухай, (iii) Урт хугацааны даатгалтай холбоотой эрх зүйн орчны зарим асуудлууд, (iv) Монголбанкнаас боловсруулдаг бусад санхүүгийн байгууллагын тоймын хамрах хүрээг сайжруулах санал зэрэг асуудлыг хэлэлцсэн болно. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн.

Тухайлбал, оны эхнээс гадаад худалдаа тэнцвэржиж байгаа хэдий ч, санхүүгийн дансны урсгал, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц сайжраагүй, экспортод гаргасан нүүрсний орлогын зарим хэсэг нь орж ирээгүй зэргээс шалтгаалж төлбөрийн тэнцэл дэх дарамт арилахгүй байна. Ийм орчинд улсын төсвөөр дамжуулж буюу төсвөөс гадуурх зарцуулалтыг Хөгжлийн банк, Төрийн банкнаас гэнэт хийх нь валютын захад сөргөөр нөлөөлөх, улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг богино хугацаанд сулруулахад нөлөөлж байгааг тогтоов. Энэ үндсэн дээр СЯ, ЭЗХЯ (хуучин нэрээр), Хөгжлийн банкнаас ирээдүйд хийх төгрөгийн зарцуулалтын мэдээг 7 хоног тутамд Монголбанкинд хүргүүлж, урьдчилан мэдээлж байх замаар макро бодлогын харилцан уялдааг хангаж байхаар тогтсон.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 2 дугаар улирлын ээлжит хуралдаан 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдөр болсон бөгөөд тус хуралдаанаар (i) ББСБ-ыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд оролцуулах, (ii) гадаад валютын своп, форвард хэлцэл байгуулах болон Монголбанкны үнэт цаас худалдан авах, бичил санхүүгийн зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд хамруулах тухай, (iii) Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ, (iv) Монгол Улсын гадаад секторын болон гадаад валютын дотоодын захын тойм, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэр зэрэг асуудлыг хэлэлцсэн.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 3 дугаар улирлын хуралдаан 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр болсон бөгөөд тус хуралдаанаар (i) Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл, (ii) “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн төслийн танилцуулга, (iii) Санхүүгийн хүртээмжийн холбоо (AFI)-ны гишүүнчлэлийн хураамжийн танилцуулга зэрэг асуудлыг авч хэлэлцэв. СТБЗ нь улирал бүр хуралдах хуваарьтай бөгөөд шаардлагатай гэж үзсэн тухай бүр ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах боломжтой байдаг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн салбарын талаарх бодит мэдээллийг нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэх, санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлж түүний тогтвортой байдлыг хангах зорилгоор “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам бэлтгэж, эхний 4 дугаарыг олон нийтэд хүргээд байна. Тухайлбал, Монголбанк дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба (СТБЗАА) нь тайлант хугацаанд “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн №3 дахь дугаарыг 2014 оны 5 дугаар сард, №4 дэх дугаарыг 11 дүгээр сард нэгтгэн боловсруулж хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж олон нийтийн хүртээл болгов. Санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдлийг тодорхойлон, эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн макро зохистой бодлогын арга хэмжээг судалж, бодлогын санал боловсруулах ажлын хүрээнд хагас жил тутам гардаг “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-д макро зохистой бодлогын арга хэрэгслүүдтэй холбоотой асуудлуудыг тусгаж оруулсан.

СТБЗАА-аас “Макро эдийн засаг, санхүүгийн салбарын улирлын тойм”-ыг боловсруулж, улирал бүрийн дараа улиралд багтаан цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлж байна. Үүний зэрэгцээ тус албанаас тайлант хугацаанд “Макро зохистой бодлого хэрэгжүүлэгч институцийн

загвар”, “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын үнэлэх *Cobweb* аргачлал”, “Санхүүгийн гүнзгийрэлт, түүний бодит секторт үзүүлэх нөлөө” гэсэн 3 судалгааны ажлыг гүйцэтгэв.

Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо нь өөрсдийн хариуцсан чиглэлээр санхүүгийн салбар, гадаад сектор, макро эдийн засгийн талаарх тайлан мэдээлэл, статистик мэдээ, судалгаа шинжилгээг боловсруулж, өдөр, сар, улирлын давтамжтайгаар, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол түгээж, шаардлагатай үед СТБЗ-өөс зөвлөмж гаргаж байгаа болно.

2.3 Валютын бодлого


Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш уян хатан тогтож байх бодлого нь макро эдийн засгийн ерөнхий тэнцвэрийг хангах, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтийн нөлөөллийг валютын ханшаар дамжуулан шингээх замаар эдийн засгийн дунд ба урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих, санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх суурь нөхцөл болдог билээ. Иймд Төрөөс мөнгөний бодлогын талаар сүүлийн жилүүдэд баримталсан үндсэн чиглэлд “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтож байх”-аар заасан бөгөөд Монголбанк уг бодлого, зарчмыг 2014 онд тууштай баримталж ажиллалаа.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж байгаа бөгөөд Монголбанкнаас баримталж буй ханшийн бодлого нь гадаад зах зээлийн таагүй өөрчлөлтийн дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаа, урсгал тэнцэл, нийт эдийн засаг дахь зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Төгрөгийн ханш ийнхүү эдийн засгийн суурь нөхцөл байдалтай нийцтэйгээр уян хатан тогтож байгаа нь богино хугацаанд буюу 2013 оны 2 дугаар хагас, 2014 оны 1 дүгээр хагаст тодорхой зардлыг дагуулж, импортын өртгийг нэмэгдүүлсэн хэдий ч, төгрөгийн тогтвортой байдал буюу үнийн тогтвортой байдал (инфляци нам, тогтвортой түвшинд байх)-ыг хангах Монголбанкны үндсэн зорилттой нийцтэй байв. Улмаар энэ нь дунд болон урт хугацаанд дотоодын үйлдвэрлэл, экспортыг урамшуулах, ажлыг байрыг хадгалах, үр ашиггүй буюу тэвчиж болох импорт, хэрэглээг бууруулах (жишээ нь удаан эдэлгээтэй хэрэглээний барааны импорт, түүний дотор автомашины импорт 25%-иар буурав), гадаад худалдааг тэнцвэржүүлэх, урсгал дансны алдагдлыг бууруулж, улмаар түүнийг ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлэх, төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өрсөлдөх чадвар, тэнцвэртэй өсөлтийг дэмжих боломжийг бүрдүүлж байна.

Монголбанк төлбөрийн тэнцлийн хүндрэл бүхий сүүлийн 2 жил гаруй хугацаанд хүндрэлийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханш болон гадаад валютын улсын нөөцийн аль алинаар нь дамжуулан зөөлрүүлж ирсэн билээ. Ингэснээр нэг талаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь үзүүлэлттэй нийцэж уян хатан тогтохдоо хэлбэлзэл нь бага (2014 онд өдрийн дундаж хэлбэлзэл 0.17%) байсан бол, нөгөө талаас гадаад валютын улсын нөөц 2014 онд дунджаар импортын 4.6 сарын, 2013-2014 онуудад импортын 5.9 сарын хэрэгцээг хангахуйц түвшинд байлаа. 2014 оны эцэст гадаад валютын улсын нөөц сүүлийн 3 сарын импортын дундаж гүйцэтгэлээр тооцоход 4.9 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байв.

Зураг 38: Гадаад валютын улсын нөөц ба импортын хэрэгцээг хангах түвшин




Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

2014 онд экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад эрэлт, дэлхийн зах зээл дээрх үнэ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурснаар валютын орох урсгал эрс татарсан. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн урсгал данс 2011-2013 онуудад дунджаар ДНБ-ий 26 гаруй хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байсан бөгөөд уг алдагдлыг 2011-2012 онд хөрөнгө, санхүүгийн дансны ашгаар, 2013 онд гадаад валютын улсын нөөцөөр нөхөж ирсэн. Гэвч хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 2013 онд 71%-иар, 2014 онд 26%-иар буурснаар төлбөрийн нийт тэнцэл 2013 онд -1.9 тэрбум ам.долларын, 2014 онд -0.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан юм. Ийнхүү 2013-2014 онд төлбөрийн нийт тэнцэл -2.4 тэрбум ам.доллар (ДНБ-ий 20 гаруй хувь)-ын алдагдалтай гарсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлөв.


Төлбөрийн тэнцлийн алдагдал өндөр байсан 2013 онд төгрөгийн нэрлэсэн (NEER) болон бодит үйлчилж буй ханш (REER) гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцвол харгалзан 15.5%, 8.2%-иар суларсан бол төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан 2014 онд харгалзан 2.3%, 11.0%-иар чангарсан үзүүлэлттэй гарсан. Үүнд ОХУ-ын рублийн ханш ам.долларын эсрэг огцом суларсан нь шууд нөлөөлөв. Харин гадаад худалдааны төлбөр тооцоонд хэрэглэгдэж буй валютаар жигнэж тооцвол NEER болон REER ханшийн индексүүд 2013 онд харгалзан 16.3%, 6.8%-иар суларч байсан бол 2014 онд харгалзан 10.3%, 3.3%-иар суларсан үзүүлэлттэй байна. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2013 онд 19.2%-иар, 2014 онд 13.8%-иар тус тус суларсан байна.

Зураг 39: Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар) ба төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER)-ийн өөрчлөлт (%)*



*Өсөлт нь NEER ханш чангарахыг, бууралт нь NEER ханш сулрахыг тус тус илэрхийлнэ
Эх сурвалж: Монголбанк

Зураг 40: Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER)-ийн жилийн өөрчлөлт (%)



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 41: Төгрөгийн бодит үйлчилж буй ханш (REER)-ийн жилийн өөрчлөлт (%)



Эдийн засгийг зөөлөн газардуулах бодлогын арга хэмжээний үр дүнд гадаад худалдаа тэнцвэржиж, 2011-2013 онд жилд дунджаар -2042 сая ам.долларын алдагдалтай байсан гадаад худалдааны тэнцэл 2014 онд +538 сая ам.долларын ашигтай гарлаа. 2014 оны 3 дугаар улирлаас эхлэн ханш огцом сулрах дарамт буурч, валютын зах тогтворжих хандлагатай болсон нь урсгал дансны алдагдал буурч, төлбөрийн нийт тэнцэл сайжирч эхэлсэнтэй холбоотой бөгөөд үүнд мөнгөний бодлогын төлвийг 2014 оны 7 дугаар сард чангаруулах чиглэлд өөрчилсөн нь эергээр нөлөөллөө. Өөрөөр хэлбэл төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт нь макро эдийн засгийн суурь үзүүлэлт талаас буураад байна. Ийнхүү төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт нь 2014 оныг 2013 онтой харьцуулахад багассан нь нэг талаас эдийн засгийг зөөлөн газардуулах бодлогын үр дүнд гадаад худалдаа тэнцвэржиж, урсгал дансны алдагдал огцом буурсантай, нөгөө талаас Монголбанкны валютын зах дахь тогтмол оролцоотой холбоотой юм.


Монголбанкнаас валютын зах дахь эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, зах зээлийн бодитой хүлээлтийг төлөвшүүлэх зорилгоор валютын захад шаардлагатай тухай бүр оролцож ажиллав. 2014 онд Монголбанкнаас гадаад валютын дуудлага худалдааг нийт 102 удаа зохион байгуулж, түүгээр 1260 сая ам.доллар, 582 сая ам.доллартай тэнцэх юанийг валютын захад нийлүүлсэн байна.

Үүний зэрэгцээ банк болон тэдгээрийн харилцагчдыг ханшийн эрсдэлийг бууруулах, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад валютаарх санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг идэвхтэй арилжаалж, банкуудтай төгрөг-ам.доллар, төгрөг-юанийн своп, форвард хэлцлүүдийг тогтмол хийв. Энэ нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ санхүүгийн салбарыг бүхэлд нь системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой байв. Монголбанк 2014 онд өссөн дүнгээр нийт 3.3 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 3.2 тэрбум ам.долларын своп, 160.5 сая юанийн своп хэлцлийг банкуудтай байгуулсан байна.

Түүнчлэн, Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор банкуудтай форвард хэлцлийг байгуулж ажиллалаа. 2014 оны эцсийн байдлаар 903.4 сая ам.долларын форвард хэлцлийн төлбөр тооцоог хийсэн нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дотоодын зах зээлд шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ өсөх эрсдэлийг хааж, үнэ тогтвортой байхад эергээр нөлөөлсөн болно.

Валютын зах дахь Монголбанкны оролцооны үр дүнд оны эхнээс 2014 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.97%-иар чангарч, 1.66%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.17% байв. Тайлант онд ханшийн нэг өдрийн хэлбэлзэл нийт хугацааны 85%-д нь 0.4% дотор, үлдсэн 15%-д нь хамгийн ихдээ 1.97%-иар хэлбэлзжээ. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.17% байгаа нь 2013 онтой харьцуулбал 0.08 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна.

Зураг 42: Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш ба өдрийн дундаж хэлбэлзэл



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, банкуудын гадаад зах зээлээс урт хугацаатай валютын эх үүсвэр татахыг дэмжих, гадаад активыг өсгөх, гадаад валютын зээл болон долларжилтыг бууруулах зэрэг зорилгоор 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд, зээлийн санхүүжилтыг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлсний зэрэгцээ 2014 оны 1 дүгээр улиралд “Урт хугацаат своп хэлцлийн журам” баталж, 2014 онд нийт 436 сая ам.долларын урт хугацаат (1 жилээс дээш) своп хэлцлийг банкуудтай байгуулж, уг дүнгээр гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүллээ. Энэхүү урт хугацаат своп хэлцэл байгуулсан гадаад валютын эх үүсвэрийн 85 хувь нь 2014 онд шинээр орж ирсэн эх үүсвэр байв. Ингэснээр гадаад валютын урт хугацаат эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг банкууд Монголбанкттай своп хэлцэл байгуулах замаар хааж, харилцагчиддаа валютаар бус төгрөгөөр зээл олгох боломжтой болсон нь системийн хэмжээнд ханшийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой болсон юм.

Монголбанк валютын захад тогтворгүй байдал үүссэн буюу онцгой нөхцөлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (contingency plan) боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Н-30 тоот тушаалаар баталсан. Ингэснээр валютын захад онцгой нөхцөл үүссэн буюу үүсэх эрсдэлтэй болсон үед нөхцөл байдлыг шуурхай хэлэлцэх, шаардлагатай урьдач болон хариу арга хэмжээний шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн болно.

Зураг 43: Урт хугацаат своп хэлцэл



Эх сурвалжууд: Монголбанк

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ нь долларжилтыг саармагжуулах, гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хангах чиглэлд чухал алхам болсон.

Мөн “Валютын зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд ханшийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан хаах зөвлөмж”, “Валютын зээл хүсэгчдэд зориулсан гарын авлага”-ыг боловсруулж, банкуудаар дамжуулан тэдгээрийн харилцагчдад болон олон нийтэд түгээв. Ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй харилцагчид нь ханшийн хэлбэлзлээс шалтгаалан алдагдалд орох эрсдэлтэй төдийгүй чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, нийт санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд ханшийн эрсдэлийг бууруулахад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг өргөнөөр ашиглах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Валютын арилжааны тогтолцоо бий болгох ажлын хүрээнд ББСБ-уудыг Монголбанкнаас зохион байгуулдаг валютын дуудлага худалдаанд спот болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн (своп, форвард хэлцэл) захад одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмын хүрээнд банкуудаар дамжуулан оролцуулахаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын хуралдаанаар шийдвэрлэсэн. ББСБ-ууд валютын дуудлага худалдаанд оролцож, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглах боломжтой болсноор валютын өнөөгийн захыг илүү үр ашигтай, боловсронгуй болгоно гэж үзсэн. Гадаад валютын дуудлага худалдааг банк бус санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдын хувьд нэвтрүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн байгууллагын холбоо (ББСБХ)-ноос санаачлага гарган ажиллахаар болсон бөгөөд Монголбанк уг асуудалд арга зүйн зөвлөмж өгч ажиллав. 2014 оны 11-р сарын 25-ны өдөр ББСБХ, ББСБ-ууд, ХХБ 3 талт гэрээ байгуулснаар ББСБ-ууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд банкаар дамжуулан оролцох бүрэн боломжтой болсон байна.

2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ “Төв банк (Монголбанк)-ны тухай” хуулийн 5, 21 дүгээр зүйлд заасны дагуу нөөцийн гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангаж байна. Зөвхөн дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажилладаг билээ.

2014 онд Монголбанк хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн төвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг баталж, түүний хүрээнд нөөцийн активын бүтэц, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажилласан. Түүнчлэн ГВУН-ийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлыг тогтмол ажиглан судалж, холбогдох мэдээ тайлан бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2014 онд Монголбанкнаас ГВУН-ийг зээлийн эрсдэл харьцангуй бага, дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи гэх мэт орнуудын төв банкууд, Олон улсын төлбөр тооцооны банк (BIS), зээлжих зэрэглэл өндөртэй банкуудад харилцах, хадгаламж хэлбэрээр байршууллаа. Дэлхийн эдийн засгийн өсөлт тайлант онд 2013 онтой харьцуулахад сэргэх хүлээлттэй байснаас үүдэн АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны мөнгөний зөөлөн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн засгийн газрын бонд худалдан авах хөтөлбөрөө 2014 оны сүүлийн хагаст бүрэн зогсоосон бөгөөд улмаар бодлогын хүүг нэмэгдүүлэх хүлээлттэй байсан тул дэлхийн эдийн засагт тэргүүлэгч орнуудын Засгийн газрын богино, урт хугацаат үнэс цаас зэрэг хэрэгсэлд хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацааг дээд тал нь 3 жил байхаар тооцоолж хөрөнгө оруулав.

2014 оны 1 дүгээр улирлаас эхлэн БНХАУ-ын Засгийн газрын үнэт цаасны дотоодын зах зээлд хөрөнгө оруулах эрхтэй болж улмаар БНХАУ-ын ЗГҮЦ-нд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн.

ГВУН-ийн ам.долларын багцыг 2013 оноос Дэлхийн банкны зөвлөгөө, бусад төв банкуудын сайн туршлагын дагуу богино хугацаат багц, хөрөнгө оруулалтын багц гэж ангилж, богино хугацаат багцыг 0-1 жилийн хугацаатай, хөрөнгө оруулалтын багцыг 0-3 жилийн хугацаатай индексийн жишиг хэмжүүртэй харьцуулан удирдаж ажилласан. Мөн зэрэглэл өндөртэй АНУ-ын Засгийн газрын 0-3 жилийн хугацаатай үнэт цаасны индексийг хуулбарлан, хөрөнгө оруулалтын багцыг удирдах аргаар хүүгийн эрсдэлийг бууруулж ажиллав.


Монгол Улсын ГВУН 2014 оны эцэст 1649.9 сая ам.долларт хүрч оны эхнээс 26.6%-иар буюу 598 сая ам.доллараар буурсан. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох валютын төлбөртэй импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээг бүрэн хангаж байгаа үзүүлэлт юм. 2014 оны эцэст ГВУН нь:

- 2014 оны 12 дугаар сарын валютын шууд төлбөртэй импортын дүнгээр авч үзвэл 4.8 сарын буюу 19.1 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын шууд төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 4.9 сарын буюу 19.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд тус тус байв.

ГВУН оны эхнээс буурахад (i) банкууд цэвэр дүнгээр 1314.8 сая ам.доллартай тэнцэх валютаар дансаа зузаатгасан, (ii) Сангийн яам Монголбанкнаас хүүгийн болон гадаад зээлийн төлбөрт нийт 220.1 сая ам.доллартай тэнцэхүйц гадаад валютыг шилжүүлсэн зэрэг нь голлон нөлөөлсөн бөгөөд ГВУН-ийн ам.доллараар илэрхийлэгдэх хэмжээг бууруулахад ГВУН-ийг бүрдүүлэгч голлох валютууд болох юань, алт, фунт стерлинг, евро, иенийн ханш 1.5-13.9%-ийн хооронд суларсан нь нөлөөлөв.

2014 онд “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдсанаар алт тушаалт нэмэгдэж, дотоодын алт үйлдвэрлэгчид Монголбанкинд 12.7 тонн алт тушааж, ГВУН-ийг дотоод эх үүсвэрээр нэмэгдүүллээ. Энэ нь 2013 оноос 6.7 тонн, 2012 оноос 9.4 тонноор тус тус нэмэгдсэн дүн юм.

Зураг 44: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (кг) ба дэлхийн зах зээл дэх алтны үнэ (\$/унц)



Эх сурвалж: Монголбанк

2.5 Төлбөр тооцооны систем

Монголбанк нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллалаа.

Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор их, бага дүнтэй төлбөр тооцооны журам, төлбөрийн картын журамд тус тус шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулахаас гадна дэвшилтэт техник технологийн хөгжлийг даган төлбөрийн системд шинээр орж ирж байгаа төлбөрийн хэрэгслийг зохицуулах “Хөдөлгөөнт банкны журам”-ыг боловсруулан батлуулж, нийт оролцогчдод мөрдүүлэн ажиллаж эхэлсэн.

Бэлэн бус төлбөрийн хэрэгслийг хөгжүүлэх, эрх зүйн орчинг төлөвшүүлэх, төлбөрийн системийн оролцогчдын үнэлгээний шинэ аргачлалыг нэвтрүүлэх, оролцогчдын хамтын ажиллагааг сайжруулах талаар ТТҮЗ-ийн XIII, XIV хуралдаанаар хэлэлцэж, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийн нэгдмэл байдлыг хангахын тулд төлбөрийн системийн хөгжлийн стратегийг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах үндсэн зорилготойгоор Монголбанк Дэлхийн банктай хамтран төлбөрийн системийг хөгжүүлэх техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр болов.

Түүнчлэн, 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн төлбөрийн системийн оролцогч хоорондын 1 сая төгрөгөөс бага дүнтэй төлбөр тооцоог бодит цагийн горимд буюу 24/7 (хоногт 24 цагаар тасралтгүй) хуваариар дамжуулдаг болж, харилцагчаас шилжүүлсэн төлбөр тухайн мөчид хүлээн авагчийн дансанд орж, банкны үйлчилгээ иргэдэд илүү хялбар, шуурхай хүрэх болсон юм.

Монголбанкны зүгээс төлбөрийн системийн үндсэн зорилгын хүрээнд техник технологийн хөгжилтэй зэрэгцэн төлбөр тооцоонд шинээр нэвтэрч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан, системийн оролцогчдод холбогдох зөвшөөрлийг олгож, хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 15. Банк хоорондын 2011-2014 оны гүйлгээний тоо, дүн
(мянган ширхэг, их наяд төгрөг)

	2011		2012		2013		2014	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	798.0	3.7	914.9	5.7	3846.3	9.0	4513.4	13.3
өсөлт (%)	15.1	68.2	14.6	53.8	320.4	58.4	17.3	48.1
II улирал	1077.5	5.4	1249.4	7.5	4664.1	13.3	5087.2	15.0
өсөлт (%)	18.5	80.0	16.0	38.5	273.3	77.7	9.1	12.7
III улирал	903.6	6.0	1018.5	8.4	4524.5	16.1	4789.2	13.9
өсөлт (%)	12.7	73.5	12.7	40.2	344.2	91.7	5.8	-13.6
IV улирал	1139.3	8.3	3954.9	9.0	4780.1	17.5	5466.5	22.8
өсөлт (%)	15.9	76.6	247.1	8.4	20.9	94.2	14.4	30.4
Нийт	3919.3	23.4	7137.8	30.6	17815.0	55.9	19856.3	65.0
өсөлт (%)	15.7	77.3	82.1	30.7	149.6	82.8	11.5	16.3

Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын гүйлгээний тоо, дүнг өмнөх оныхтой харьцуулахад гүйлгээний тоо 11.5, гүйлгээний дүн 16.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 45. Банк хоорондын 2011-2014 оны гүйлгээний тоо, дүн



Эх сурвалж: Монголбанк

Нийт гүйлгээний тоо, дүн 2011 оноос хойш тогтмол өссөөр 2014 онд 65 их наяд төгрөгийн 19.9 сая ширхэг гүйлгээ боловсруулагдсан үзүүлэлттэй байна.

Төлбөрийн карт

Картын хэрэглээний үзүүлэлт жил тутамд өсч байгаа нь иргэдийн бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах сонирхол өндөр байгааг харуулж байна. Банкууд Виза, Мастеркарт, Юнионпэй, Ү карт гэсэн 4 төрлийн төлбөрийн карт өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Жилийн эхэн үед нийт зах зээл дэх картын 60 гаруй хувийг Виза карт дангаар эзэлж байсан бол, жилийн эцсийн байдлаар Виза карт 47, Ү карт 44 хувийг, үлдсэн 9 хувийг бусад карт эзлэх болсон байна.

Хүснэгт 16. Төлбөрийн картын хэрэглээ

Картын хэрэглэгчийн тоо	2012	2013	2014	Орон нутаг	Өөрчлөлт (%)
Карт эзэмшигч	2,855,378	3,456,440	3,590,646	1,048,256	3.9
Карт идэвхитэй ашиглагч	1,123,041	1,343,284	1,361,630	321,462	1.4
Төхөөрөмжийн тоо	2012	2013	2014	Орон нутаг	Өөрчлөлт (%)
ПОС	7210	9535	12015	2811	26.0
МПОС			2084	48	
ПОБ	2384	2765	1848	1005	-33.2
АТМ	915	1032	1229	285	19.1
Бусад	316	314	24		-92.4

Гүйлгээний тоо, дүн		2012	2013	2014	Орон нутаг	Өөрчлөлт (%)
ПОС	Тоо. Сая ширхэг	10.3	13.6	24.1	3.3	77.2
	Дүн. Тэрбум төгрөг	735.1	738.7	1099	74.3	48.8
МПОС	Тоо. Сая ширхэг			0.01		
	Дүн. Тэрбум төгрөг			0.9		
ПОБ	Тоо. Сая ширхэг	1.7	1.4	3.8	0.8	171.4
	Дүн. Тэрбум төгрөг	557	422.5	972.9	151.7	130.3
АТМ	Тоо. Сая ширхэг	57.4	57	103.1	22.4	80.9
	Дүн. Тэрбум төгрөг	3993.2	4647.5	6392.1	1235.2	37.5
Нийт	Тоо. Сая ширхэг	69.5	72	131	26.5	82.0
	Дүн. Тэрбум төгрөг	5305.3	5808.7	8465	1461.2	45.7

Эх сурвалж: Монголбанк

2.6 Банкны хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт

Тайлант онд УИХ-аас банк, санхүүгийн салбарт холбогдох хууль тогтоомжийг сайжруулах хүрээнд Банкны тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргажээ.

1. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйл (Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаа)-д “7.2.7. эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэр гүйцэтгэх албаны дарга зөвшөөрсөн” гэж нэмж оруулснаар мэдээлэл авах эрх бүхий этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг хамааруулав.
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл (Албан татварын хувь хэмжээ)-д “17.2.10. Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын хөрөнгийн биржид гаргасан бондыг худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн бондын хүүгийн орлогод 10 хувиар” гэсэн заалтыг нэмж оруулав:

Банк гадаадын хөрөнгийн зах зээлээс зээлийн эх үүсвэр татахад хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчээс хүүгийн орлогодоо аливаа татварыг Монгол Улсад суутгуулахгүй байхыг шаарддагаас үүдэн банк өөрийн зардлыг нэмэгдүүлэн тооцож, хуулийн дагуу татварыг улсын төсөвт төлж эх үүсвэрийн өртөг нэмэгддэг. Үүнийг тухайн эх үүсвэрийн өртөгт нэмэгдсэн татварыг зээл авч буй бизнес эрхлэгчдийн зээлийн хүүд тодорхой хувиар шингээн тогтоож, бизнес эрхлэгчдэд дарамт болж байв. Энэхүү хуульд дээрх нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар банкны зээлийн өртөг буурч, бизнес эрхлэгчдэд ирэх хүүгийн дарамт бууран, улмаар гадаад зах зээлээс хямд эх үүсвэр татах сонирхол нэмэгдэн, гадаад валютын болон мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх боломжийг нэмэгдүүлэв.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйл (Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг)-д “35.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана”, 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэг (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараах хэмжээтэй байна)-т:

“47.3.3. Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.” гэсэн нэмэлт, өөрчлөлт оров. Мөн тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “47.3.1-д зааснаас бусад” гэснийг “47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад” гэж өөрчлөв.

- Алт олборлогч аж ахуйн нэгжийн татварын дарамт нэмэгдэж, алт олборлогч, алт худалдан авагчид улсын хилээр алтыг хууль бусаар хил давуулан худалдах, олборлосон алтаа нуух, хадгалах зэргээр татвар төлөхөөс зайлсхийх үзэгдэл газар авах хандлагатай болсон, Монголбанк болон банкинд тушааж буй алтны хэмжээ буурч улсын валютын нөөцийн бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх болсон зэргээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл шаардлага үүссэн болно.
- Түүнчлэн, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд ашигт малтмал хайх, ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн жилдээ багтааж бүрэн тушааж байхаар зохицуулжээ.
- Эдгээр зохицуулалтыг хийсний үр дүнд, Монголбанкинд тушаах алтны хэмжээ болон улсын валютын нөөц нэмэгдэж, Монгол Улсын зээлжих эрхийн зэрэг дээшлэх, татварын суурь өргөжиж, борлуулсан алтанд ногдох албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлж улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, алтны нөөцийг өсгөх, алтны олборлолт, борлуулалт ил тод, хуулийн хүрээнд байх боломж бүрдүүлэх ач холбогдолтой болов.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйл (Эд хөрөнгийн тухай мэдүүлэг)-д дараах хэсгийг нэмж оруулав: “40.4.Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламжийн болон харилцах дансны мэдээллийг авах саналыг шийдвэр гүйцэтгэх албаны даргад гаргах бөгөөд шийдвэр гүйцэтгэх албаны дарга уг саналын үндэслэлийг хянана”. Мөн энэхүү хуулийн дараах хэсгийг өөрчлөн найруулав: “40.1. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн төлбөр төлөгчөөс доор дурдсан эд хөрөнгийн тухай мэдүүлгийг авна:

40.1.1. төлбөр төлөгчийн өмчлөлийн эд хөрөнгө, банкин дахь мөнгөн хөрөнгийн тухай”.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбогдуулан төлбөр төлөгчийн банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаасны тухай мэдээллийг гаргуулан авах эрхтэй бөгөөд хэрэв төлбөр төлөгч хадгаламжийн болон харилцах дансны мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийсэн нөхцөлд тус мэдээллийг банк, банк бус санхүүгийн байгууллагаас авах саналыг шийдвэр гүйцэтгэх албаны даргад гаргаж, тус саналыг үндэслэлтэй гэж үзвэл холбогдох байгууллагад хуульд зааснаар хандаж болохоор зохицуулав.

5. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл (Эрдэнэсийн сангийн зарлага)-ийн 11.1 дэх заалтын “иргэдэд үнэт металл,” гэснийг “иргэдэд соёлын өвд хамаарахаас бусад үнэт металл,” гэж өөрчлөв. Энэ өөрчлөлт орсноор зарлагын батлагдсан тэнцлийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд соёлын өвд хамаарахаас бусад үнэт металл, эрдэнийн чулууг дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас тогтоосон үнээр бусдад борлуулах боломжтой болжээ.
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, жишигт хүргэж боловсронгуй болгох, Эрүүгийн хууль болон Мөнгө

угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиуд дахь мөнгө угаах гэмт хэргийн тодорхойлолтын агуулгыг жигдрүүлэх, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн төрлийг өргөжүүлэх үүднээс УИХ-аас 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дараах нэмэлт, өөрчлөлт оруулав:

1) Эрүүгийн хуульд:

- а) Олон улсын эрх зүйд хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татдаг стандарт, жишгийг Монголын эрх зүйд бий болгох үүднээс хуулийн 8.3, 20.2-т ... тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шинэ хариуцлагыг тогтоов.
- б) 166¹. Мөнгө угаах гэсэн зүйлийг шинэчлэн мөнгө угаах гэмт хэргийн тодорхойлолтыг олон улсын стандартад нийцүүлж, түүний хамрах хүрээг өргөжүүлэв.
- в) Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглаж бусдад их хэмжээний хохирол учруулах гэмт хэрэг буюу “166³. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах” гэж шинээр зүйлчлэв.
- г) Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг шунахай сэдэлтээр ашиглахтай тэмцэх үүднээс “166³. Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох” гэсэн шинэ зүйлийг хуульчлав.
- д) Түүнчлэн, террорист хүн, террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар, бүхэлд нь болон хэсэгчлэн эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан тухай “Терроризмыг санхүүжүүлэх” гэсэн 178² дугаар зүйлийг шинэчлэв.

2) Эрүүгийн байцаан шийтгэх хуульд:

Гэмт хэргийн хөрөнгө, орлогыг түр болон бүрмөсөн хураах арга хэмжээг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор, мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэргээс олсон орлогоос шууд бусаар олж авсан хөрөнгийг оролцуулан “гэмт хэргээс олсон орлого”-ын тодорхойлолтыг хуульчлав:

- 1/ 27 дугаар зүйл (Мөрдөн байцаалт явуулах байгууллага)-ийн Авлигатай тэмцэх байгууллагын мөрдөн байцаагч 27.3 дахь хэсэгт “дугаар зүйл болон өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 166¹ (Мөнгө угаах)” гэж нэмж оруулав.
- 2/ 134 дүгээр зүйл (Эд хөрөнгө битүүмжлэх)-д “134.1. Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний эд хөрөнгийг битүүмжлэх, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг нотлох хангалттай үндэслэл байгаа бол уг хөрөнгө, орлогыг битүүмжлэх үүрэгтэй” гэсэн заалтыг нэмж оруулав.

Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуульд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох зүйл заалтыг тусгаснаар Монгол Улс олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал алхам болсныг тэмдэглэх нь зүйтэй.


3.1 Төв банкны үнэт цаас

Монголбанкнаас банкны системийн нөөцийг удирдах гол хэрэгсэл нь ТБҮЦ юм. Монголбанк банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлт дээр үндэслэсэн дараах 2 төрлийн ТБҮЦ-ыг банкуудад тогтмол арилжаалж байна. Үүнд:

- 7 хоногийн хугацаатай ТБҮЦ
- 28 хоногийн хугацаатай ТБҮЦ

ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 3 дугаар сараас эхлэн 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг долоо хоногт гурван удаа арилжаалж байгаа бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 855.6 тэрбум төгрөг байв. Үүний 96% -ийг 7 хоногийн хугацаатай, 4%-ийг 28 хоногийн хугацаатай ТБҮЦ эзэлж байна.

Зураг 46. Банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ны үлдэгдэл (хугацаа, сар бүрээр)



Эх сурвалж: Монголбанк

3.2 Төв банкны санхүүжилт

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зохистой түвшинд удирдах зорилгоор банкны системд мөнгөн хөрөнгө нийлүүлэхдээ өдрийн зээл, овернайт репо санхүүжилт, репо арилжаа, барьцаат зээл зэрэг хэрэгслүүдийг ашиглаж байна. Эдгээр нь хугацаа, хэлбэр, хүү, зориулалтаараа ялгаатай юм. Монголбанкны санхүүжилтийн хэрэгслүүд бүгд барьцаатай бөгөөд барьцаа нь Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албанаас гаргасан барьцааны жагсаалтад орсон актив байна.

Өдрийн зээл

Өдрийн зээл нь тухайн өдрөө эргэн төлөгддөг онцлогтой бөгөөд түүнийг төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ашигладаг. Өдрийн зээл нь хүүгүй байна. Тайлант онд Монголбанк нийт 3.5 тэрбум төгрөгийн өдрийн зээлийг банкуудад олгов.

Овернайт репо санхүүжилт

Монголбанкнаас олгох овернайт репо санхүүжилт гэдэг нь Заавал байлгах нөөцийн шаардлага хангахгүй байгаа банкинд клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар олгож байгаа зээлийг хэлнэ. Овернайт репо хүү нь Төв банкны хүүгийн коридорын дээд хязгаар болох ба бодлогын хүүн дээр 2 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Банкууд 2014 онд нийт 6.0 их наяд төгрөгийн овернайт репо санхүүжилт Монголбанкнаас авчээ.

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа гэж Монголбанкнаас зарласан арилжаагаар банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцлээр банкинд санхүүжилт олгох нээлттэй захын үйл ажиллагааг хэлнэ. Банк системд хөрөнгийн дутагдал бий болсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан зэргээс шалтгаалан 7 хүртэл хоногийн хугацаатай санхүүжилтийг репо арилжаагаар олгодог. Тайлант онд Монголбанк 4 удаагийн репо арилжаагаар нийт 550.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгосон байна.

Барьцаат зээл


Монголбанк мөнгөний бодлого хэрэгжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангах зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн хувьд банкинд барьцаат зээл олгодог. Барьцаат зээлийн хүүг 2014 онд бодлогын хүүтэй уялдуулан бодлогын хүүн дээр 2 нэгж хувийг нэмж тогтоосон. Тайлант онд Монголбанк нийт 659.0 тэрбум төгрөгийн барьцаат зээл олгосон бөгөөд 2014 оны эцсийн байдлаар 82.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монголбанк 2014 онд өөрийн мөнгөний бодлогын хэрэгслүүдээр дамжуулан банкуудад нийт 7.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд үүний 83.1 хувь нь овернайт репо санхүүжилт, 9.2 хувь нь барьцаат зээл, 7.6 хувь нь репо арилжаа, үлдсэн 0.1 хувь нь өдрийн зээл байв.

3.3 Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)


ЗГҮЦ-ны анхдагч захын үйл ажиллагаа

Зураг 47. ЖДХ (12 долоо хоногтой ЗГҮЦ)



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 48. ЗГҮЦ-ны үлдэгдэл



Хүснэгт 17. ЗГҮЦ-ны хоёрдогч захын үйл ажиллагаа

ЗГҮЦ-ын хоёрдогч захад хийгдсэн арилжааны дүн			
/Огноо	i/ Богино хугацаат	ii/ Урт хугацаат	/i+ii/ Нийт
2014 оны 1 сар	-	-	-
2014 оны 2 сар	1 500	2 500	4 000
2014 оны 3 сар	-	10 000	10 000
2014 оны 4 сар	29 000	10 000	39 000
2014 оны 5 сар	35 000	12 500	47 500
2014 оны 6 сар	1 500	22 000	23 500
2014 оны 7 сар	-	-	-
2014 оны 8 сар	-	-	-
2014 оны 9 сар	-	-	-
2014 оны 10 сар	500	-	500
2014 оны 11 сар	15 020	-	15 020
2014 оны 12 сар	-	-	-
НИЙТ	82 520	57 000	139 520

Эх сурвалж: Монголбанк

төлөвлөж байна. Ингэснээр ЗГҮЦ-ны хөрвөх чадварыг сайжруулах, зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг сайжруулах давуу тал бий болох юм.

2013 онд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг баталж, хоёрдогч захын үйл ажиллагааг амжилттай эхлүүлсэн болно. 2014 онд нийт 135.9 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ хоёрдогч зах дээр арилжаалагдсан байна. Үүнээс 78 тэрбум нь Засгийн газрын богино хугацаат, 57 тэрбум нь Засгийн газрын урт хугацаат үнэт цаас байжээ. ЗГҮЦ-ны хоёрдогч захыг хөгжүүлснээр өгөөжийн муруйг бий болгохын зэрэгцээ үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах бөгөөд энэ нь төгрөгийн эрсдэлгүй хүүгийн түвшинг тодорхойлох төдийгүй санхүүгийн зах зээлийн суурь хүү болж, санхүүгийн салбарын хөгжилд ихээхэн түлхэц болох учиртай.

3.4 Гадаад валютын дуудлага худалдаа

2014 онд гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, урсгал тэнцлийн алдагдал багассан ч, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсны нөлөөгөөр төлбөрийн нийт тэнцэл 471 сая ам.долларын алдагдалтай гарч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлсөн.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчмыг тууштай баримтлан, валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүссэн ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцоогоо идэвхитэй хадгалсаар ирлээ.

Мөн гадаад валютын дотоодын зах дахь оролцоогоо улам хүртээмжтэй, илүү үр ашигтай, боловсронгуй болгох зорилгоор валютын арилжааны тогтолцоо бүрдүүлэх ажлыг идэвхжүүлээ. Уг ажлын хүрээнд валютын захад банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдыг идэвхитэй оролцуулах ажлыг зохион байгуулж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Банк бус санхүүгийн байгууллагын холбоотой хамтран, ББСБ-уудыг Монголбанкнаас

2012 оны 10 дугаар сард Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар “ЗГҮЦ гаргах, арилжаалах журам”-ыг баталсан. Тус журмын дагуу 2014 онд анхдагч зах дээр нийт 65 удаагийн арилжааг зохион байгуулж, 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкаар дамжуулан арилжаалсан ЗГҮЦ-ны идэвхитэй нийт үлдэгдэл 2.1 их наяд төгрөг байв.


Цаашид Монголбанк Сангийн яамтай хамтран ЗГҮЦ-ны зах зээлд “Үндсэн дилерийн тогтолцоо”-г нэвтрүүлэхээр

зохион байгуулж буй гадаад валютын дуудлага худалдаанд банкаар дамжуулан оролцуулах ажлыг эхлүүлээд байна. Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бий болгох, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийг идэвхжүүлж, урт хугацаат своп хэлцлийг шинээр нэвтрүүлсэн.

Гадаад валютын спот зах дахь оролцоо

2014 онд Монголбанк гадаад валютын дуудлага худалдааг 102 удаа зохион байгуулж цэвэр дүнгээр 1260 сая ам.доллар, 3584.8 сая юань буюу 582 сая ам.доллартай тэнцэх хэмжээний юань, нийтдээ 1842 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютыг захад нийлүүлсэн байна. Мөн тайлант хугацаанд шаардлагатай үед валютын захад дуудлага худалдааны бус аргаар оролцож, нийт 295.1 сая ам.долларыг нийлүүлсэн байна.

Зураг 49. Ам.долларын дуудлага худалдаа



Зураг 50. Юанийн дуудлага худалдаа




Эх сурвалжууд: Монголбанк

Гадаад валютын зах дахь урт болон богино хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслээрх оролцоо

Монголбанк спот захад оролцохын зэрэгцээ банкууд болон тэдгээрийн харилцагчдын ханшийн эрсдэлийг бууруулах, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх зорилгоор богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашигласаар ирсэн. Монголбанк 2014 онд нийт 3.3 тэрбум ам.долларын дүнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 3.2 тэрбум ам.долларын дүнтэй тэнцэх хэмжээний ам.долларын своп хэлцлийг банкуудтай байгуулсан бол Хятадын Ардын банкттай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээний хүрээнд 160.5 сая юанийн своп хэлцлийг банкуудтай байгуулсан байна.


Зураг 51. Гадаад валютын своп хэлцэл



Эх сурвалж: Монголбанк

3.5 Дотоодын зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа

Зураг 52. Монголбанкны 2013-2014 онд худалдан авсан алтны хэмжээ (кг-аар)



Эх сурвалж: Монголбанк

2013 онд Монголбанк нийт 11.2 тонн алт цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг 430.0 гаруй сая ам.доллараар нэмэгдүүллээ. Монголбанкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 5 хувиар бус, харин 2.5 хувиар тооцож ногдуулах эрх зүйн өөрчлөлттэй уялдан Төв банкинд тушаах алтны хэмжээ өсөн нэмэгдлээ.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авалт юм. Монголбанк нь дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол эрхэлж байна. Энэ ажлын хүрээнд тайлант онд Монголбанк 79 аж ахуйн нэгж, 105 иргэнээс нийт 12.7 тонн алтыг 830.8 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оноос 6.7 тонноор буюу 2 дахин өссөн үзүүлэлт юм. 2014

УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол, 2013 оны 62 дугаар тогтоол, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013, 2014 онд баримтлах үндсэн чиглэл, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанк, Засгийн газар хамтран *“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”*-ийг 2012 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн.

Энэхүү хөтөлбөр нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт, нөлөөллийг бууруулж, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах зах зээлийн зарчимд суурилсан суурь тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 3 жилийн хугацаанд, зөвхөн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжсэн.

Хөтөлбөрийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг арилгаж, төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй үед инфляцийг 2 жилийн дотор 14.0 хувиас 11.0 хувь болгож бууруулах, мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахууны үнийн өсөлтийг бага байлгаснаар бага, дунд орлоготой иргэдийн бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлэх, цаашид инфляцийн зорилтот 7 хувийн түвшинг хангах нөхцөлийг бүрдүүлээд байна. Үүний зэрэгцээ дунд хугацаанд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан байнгын тогтолцоо (бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдэл буюу хөдлөх хөрөнгийг банкны зээлээр санхүүжүүлэх)-г бий болгож, барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахын аж ахуй эрхлэгчдэд үйлдвэрлэл-хүчин чадлаа өргөтгөхөд нь бодитой дэмжлэг боллоо. Мөн уг хөтөлбөр нь 2013 оны төлбөрийн тэнцлийн хямралтай, 2013-2014 оны эдийн засгийн хүндрэлтэй үед хөдөө аж ахуй, барилга угсралт, тээвэр агуулахын аж ахуйн салбарт ажлын байрыг хамгаалахад чухал хөшүүрэг болсон юм.

Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр нь зорьсон үр дүндээ хүрсэн, хөтөлбөрийг анх эхлүүлэхдээ дунд хугацаанд зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой тогтолцоо бүрдүүлэх, улмаар Монголбанк хөтөлбөрөөс үе шаттай гарахаар төлөвлөсөн, УИХ-ын 2014 оны 69-р тогтоолоор хөтөлбөрөөс үе шаттай гарах оновчтой арга замыг сонгож хэрэгжүүлэхийг, 2015 оны 41-р тогтоолоор хөтөлбөрийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэхийг тус тус даалгасны дагуу 2015 оны эхний хагас жил дуусахад Монголбанкны тэнцэлд үлдэх 475.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг Засгийн газарт шилжүүлэхээр болов. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл 2013 оны эцэст 714.1 тэрбум төгрөг байсан бол 2014 оны эцэст 633.8 тэрбум төгрөг болж буурсан. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл 2015 оны эцэст 232.3 тэрбум төгрөг, 2016 оны эцэст 27.3 тэрбум төгрөг болж буурахаар хүлээгдэж байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж болон оролцогч банк хооронд байгуулсан гэрээнд заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт орохгүй бөгөөд зээлийн эргэн төлөлтүүд гэрээнд заасан тогтсон хуваарийн дагуу үргэлжлэн хийгдэнэ.

Хүснэгт 18. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл, хугацааны эцэст (тэрбум төгрөг)

		2013	2014	2015. 06.30	2015 оны эцэст	2016 оны эцэст
Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр	Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах	61.6	17.3	30.2	0.0	0.0
	Гурилын үнийг тогтворжуулах	12.5	47.0	21.2	0.0	0.0
	Хүнсний бүтээгдэхүүний зoorь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх	99.0	132.2	111.1	82.2	7.6
Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр		192.0	176.1	92.2	0.0	0.0
Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр		12.0	15.9	7.7	1.3	0.0
Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр	Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	169.7	211.7	200.8	148.5	19.7
	Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материалын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах	99.4	0.0	0.0	0.0	0.0
	Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах дэд хөтөлбөр		67.9	33.6	12.2	0.3	0.0
НИЙТ		714.1	633.8	475.4	232.3	27.3

Эх сурвалж: Монголбанк

4.1 Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (SIFS)-ийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго:

Манай улсад газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнийн инфляцид үзүүлэх шууд ба шууд бус нөлөөлөл хүчтэй байдаг. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн өсөлтийг бага байлгах нь үнийн тогтвортой байдлыг хангахад эергээр нөлөөлнө. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахын тулд Засгийн газраас нефть боловсруулах үйлдвэр байгуулах, улсын нөөц бүрдүүлэх зэрэг дунд болон урт хугацаанд хэрэгжих ажлуудыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Гэхдээ эдгээр ажлууд хийгдэх хүртэлх хугацаанд жижиглэнгийн шатахууны үнийн өсөлтийг бага, тогтвортой түвшинд байлгах шаардлага үүссэн.

Үүний тулд шатахууны импортын санхүүжилтийн өртгийг багасгах, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг богино хугацаанд хэрэгжүүлж болох арга хэрэгслүүдийг ашигласан болно. Дээрх шаардлага, зорилтыг хэрэгжүүлэхээр Монголбанкны

Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-171/46 дугаар хамтарсан тушаалаар “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр SIFS”-ийг баталж хэрэгжүүлсэн бөгөөд дараах үр дүнд хүрэхээр зорьсон билээ.


Хүснэгт 19. SIFS дэд хөтөлбөрийн зорилго

Үндсэн зорилго:	Бодлогын зорилт:
Гадаад зах зээлийн нөхцөл байдалд огцом өөрчлөлт ороогүй нөхцөлд шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгана: - Санхүүжилтийн зардлыг бууруулна. - Валютын ханшийн эрсдэлийг бууруулна.	- Шатахууны импортын татварыг хилийн үнэтэй уялдуулан тогтоодог болно. - Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах савыг барьсан байна. - Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нэмэгдсэн байна. - Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэр төрөлжинө.

Эх сурвалж: Монголбанк

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа нь 3 жил, хэрэгжүүлэх арга механизм нь санхүүжилтийн өртгийг бууруулах, хил дээрх өртгийн ханшийн хэлбэлзлээс хамаарах нөлөөллийг бууруулах замаар жижиглэнгийн үнийн тогтвортой байдлыг хангахыг зорьсон. Шатахуун импортлогч компаниудад банкуудын олгосон зээлийн үлдэгдэл 2013 оны эцэст 192 тэрбум төгрөг, 2014 оны эцэст 176.1 тэрбум төгрөг байв. 2015 оны эхний хагас дуусахад 92.2 тэрбум төгрөгийн зээл Засгийн газарт шилжих ба зээлийн гэрээний дагуу 2015 оны эцэст дэд хөтөлбөрийн зээл бүрэн төлөгдөж дууссан байна.

Зураг 53. SIFS дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үе шат




Үр дүн:

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- Хөтөлбөр эхэлсэн үетэй харьцуулахад төгрөгийн ам.доллартай харьцах ханш 33 хувиар сулрахад шатахууны жижиглэнгийн үнэ 5 хувиар өссөн буюу сүүлийн 26 сарын турш тогтвортой байснаар газрын тосны бүтээгдэхүүний инфляцид үзүүлэх нөлөөлөл эрс буурсан байна.
- Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ дэх валютын ханшийн эрсдэлийг бууруулснаар санхүүжилтийн өртөг буурсан.


- Хөтөлбөр эхэлснээс хойш компаниудын шатахууны биет нөөц 3.0 дахин нэмэгдэж, богино хугацаанд шатахууны хомсдолд орох эрсдэлгүй болсон.
- Шатахууны импортын эх үүсвэрийг төрөлжүүлснээр нийлүүлэлтийн тасралтгүй байдал сайжирч, хилийн үнэ буурах нөхцөл бүрдсэн.
- Импортын татварыг хилийн үнийн өсөлт, бууралттай нь уялдуулан өөрчилдөг болсноор татварын зохицуулалтыг сэргээсэн.
- Санхүүгийн үүсмэл хэрэгслээр ханшийн эрсдэлийг бууруулан шатахууны үнийн өсөлтийг бага байлгах боломжтой болсон.

Зураг 54. А-92 шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)




Эх сурвалжууд: УУЯ, ГТГ

Зураг 55. Дизель түлшний жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)




Зураг 56. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц (мян. тн.)



Эх сурвалжууд: УУЯ, ГТГ

Зураг 57. Газрын тосны бүтээгдэхүүний импортод ОХУ-ын эзлэх хувь



Цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

УИХ-ын 2015.02.18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 2.2-т заасны дагуу дэд хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

- 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дэд хөтөлбөрийн зээлийн Монголбанкны тэнцэлд үлдэх 92.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Засгийн газар, Хөгжлийн банкны эх үүсвэрт бүрэн шилжүүлэх, энэ ажлын хүрээнд Хөгжлийн банк болон ОХУ-ын VTB банкны хооронд хийгдэх худалдааны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх;
- Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах схемийг цаашид Засгийн газар, Хөгжлийн банк хувийн хэвшилтэй хамтран үргэлжлүүлэх замаар дотоодын зах зээлд шатахууны үнэ огцом өсөх эрсдэлээс сэргийлж, шатахууны үнийн инфляци дахь сөрөг нөлөөллийг бага байлгах;
- Дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн үйл ажиллагааг мөн тус өдрөөр дуусгавар болгох, тогтоол гарсан өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн ам.долларын эх үүсвэрийг Засгийн газар ижил нөхцөлөөр санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл хийх замаар Монголбанкинд буцаан төлөх;
- Гадаад, дотоод зах зээлд үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга механизмыг бий болгох зорилгоор дэд хөтөлбөрт тусгагдсан болон дараах ажлуудыг хэрэгжүүлэх:
 - o Үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс өртгийн гэнэтийн огцом өөрчлөлтөөс хамгаалах эрсдэлийн санг бий болгох (СЯ);
 - o Уул уурхайн яам, Сангийн яам хамтран шатахууны хилийн үнийн өсөлт, ханшийн өөрчлөлтийг борлуулалтын үнэд зах зээлд цочрол үүсгэхгүйгээр алгуур шингээх аргачлалыг боловсруулж, батлуулах (УУЯ, СЯ);
 - o Шатахууны жижиглэнгийн худалдааны өртгийг тооцоолох аргачлалыг батлах, үнэ бүрдэлтийг олон нийтэд УУЯ, ГТГ-ын цахим хуудсаар дамжуулан сар бүр тогтмол мэдээлэх (УУЯ);
 - o Шатахууны биет нөөцийг хадгалах улсын эзэмшлийн агуулах барих, нөөцийг биетээр бүрдүүлэх, хяналтын механизмыг бий болгох (УУЯ).

Хүснэгт 20: Шатахууны онцгой болон гаалийн албан татварын өөрчлөлтүүд

	Онцгой албан татвар		Гаалийн татвар	Тогтоол огноо, дугаар
	Уул уурхай	Бусад салбар		
2012 оны 9 сар				
АИ80	0 ₮/тн	0 ₮/тн	-	
АИ92				
Дизель				
2012 он 11 сар				
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн	-	Засгийн газрын 2012.12.23-ны өдрийн 134 дүгээр тогтоол
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	0 ₮/тн		
2013 он 7 сар			Хилийн үнийн 3%	Засгийн газрын 2013.07.06-ны өдрийн 236 дугаар тогтоол
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн		
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	80,000 ₮/тн		
2013 он 12 сар			Хилийн үнийн 3%	Засгийн газрын 2013.12.07-ны өдрийн 406 дугаар тогтоол
АИ80	130,000 ₮/тн	0 ₮/тн		
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	109,000 ₮/тн	0 ₮/тн		
2014 он 1 сар			Хилийн үнийн 1%	Засгийн газрын 2014.01.28-ны өдрийн 24 дүгээр тогтоол
АИ80	30,000 ₮/тн	30,000 ₮/тн		
АИ92	0 ₮/тн	0 ₮/тн		
Дизель	30,000 ₮/тн	30,000 ₮/тн		
2015 он 1,2 сар			Хилийн үнийн 5%	Засгийн газрын 2015.01.19-ны өдрийн 18, 2015.02.16 өдрийн 65 дугаар тогтоол
АИ80	252,000 ₮/тн			
АИ92	259,000 ₮/тн			
Дизель	265,000 ₮/тн			

Эх сурвалж: УУЯ, ГТГ

4.2 Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр (TLF)-ийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж


Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго:

Манай улс өргөн хэрэглээний бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ тодорхой хэсгийг импортоор хангаж байгаа өнөөгийн нөхцөлд гадаад худалдааны тээвэр, логистикийн өндөр зардал, хүчин чадлын дутагдалтай байдал нь бүтээгдэхүүний үнийг өсгөх, нийлүүлэлтийн хомсдлыг үүсгэх замаар инфляцид сөргөөр нөлөөлж ирсэн байдаг. Иймд өргөн хэрэглээний импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд, тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах шаардлага үүссэн.

Дээрх шаардлага, зорилгыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын 2012.10.26-ны өдрийн А-167/57 дугаар хамтарсан тушаалаар энэхүү дэд хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэв. Энэхүү хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд төмөр замын үйлчилгээг сайжруулах, хөнгөвчлөх зорилгоор гадаад, дотоод харилцааны бодлого төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлэхийн сацуу банкны зээлийн эх үүсвэрээр хөтөлбөрт тусгасан ажлуудыг хэрэгжүүлэхээр анх төлөвлөсөн юм.

Зураг 58. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн схем

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Зам, тээврийн яам нь удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авснаас гадна, санхүүжилт шаардлагатай арга хэмжээний талаар Монголбанкинд санал оруулж, түүнийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтыг бие даан зохион байгуулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Монголбанкнаас банкинд зээл олгосон бөгөөд банк өөрөө эрсдэлээ хариуцан хөтөлбөр хэрэгжүүлэгчид зээл олгож, олгосон зээл хуваарийн дагуу эргэн төлөгдөж байна.




Үр дүн:


1. Өргөн хэрэглээний барааны ачаа эргэлт нэмэгдэж, хурдсав (Замын Үүд-УБ).

- Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тусгайлсан 4 галт тэргээр гүйцэтгэдэг болсон. Удирдлага зохион байгуулалтыг сайжруулсны үр дүнд Замын Үүд-УБ чиглэлд ачаа тээвэрлэлтийн хугацааг 20 цаг, вагоны эргэлтийн хугацааг 2011 онд 4.41 хоног байсныг 2014 онд 3.27 хоног болгож бууруулсан.

Зураг 59: Вагон эргэлтийн хурд нэмэгдэв



Зураг 60: Замын Үүд-УБ чиглэлд тээвэрлэлт өсөв



Эх сурвалжууд: ЗТЯ

2. Ачаа тээвэрлэлтийн өртгийг тогтворжуулав.

- Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртөг 2011 оны 9 дүгээр сараас хойш өөрчлөгдөөгүй тогтвортой байна.
- УБТЗ-ын шатахууны эргэлтийн хөрөнгөд нийт 34 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгосон ба зээл хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр үлдэгдэл нь 2014 оны эцэст 15.9 тэрбум төгрөг байна. Энэхүү зээл нь шатахууны зардалд 8 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болгосноор ачаа тээвэрлэлтийн өртөг нэмэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Замын-Үүдийн шилжүүлэн ачих ангид ачаа тээврийн програм, автомашины дарааллыг хянах програм суурилуулснаар нэг машинд зарцуулах хугацаа 20 минут байснаас 1 минут болж буурсан.

3. Тяньжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчлөв.

- Нарийн царигийн төмөр замаар ирж байгаа вагонуудыг шуурхай хүлээн авч шилжүүлэн ачих ажлыг 2012 оны 11 дүгээр сараас тогтмол зохион байгуулж байна.
- “Тяньжин-Монголын тээвэр ложистикийн төв” төслийн нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулж дууссан.
- БНХАУ-тай зам, тээврийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар хэд хэдэн баримт бичгүүдийг байгуулсан. Үүний үр дүнд Хойд Хятадын Дандонг, Далиен, Жиньжоу, Ингоу, Цинь Хуангдао, Хуанг Хуа, Тяньжин зэрэг нийт 7 боомтыг ашиглахаар болов. Түүнчлэн Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг БНХАУ-ын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжуулан тээвэрлэх чиглэл, тоо хэмжээ, тарифын хөнгөлөлт, татвар зэргийг Монгол Улсад ашигтай байдлаар тохиролцсон бөгөөд Тяньжин-Улаанбаатар чиглэлд чингэлгийн буухиа галт тэргийг тогтмол аялуулахаар болсон.

4. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэв.

- “УБТЗ” ХНН 2014 оны 6 дугаар сард сэлгээний 4 зүтгүүр, 15 зорчигчийн вагон, хот дүүргийн хооронд аялах Рейлбус галт тэрэг, 2014 оны 11 дүгээр сараас эхлэн гол замын 4 зүтгүүрийг тус тус өөрийн хөрөнгөөр худалдан авч ашиглаж байна.

5. Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэв.

- Замын-Үүдийн ачааны терминалын ачаа боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд технологийн горимын мөрдөлтийг сайжруулж, Замын-Үүд-1 өртөөний галт тэрэг хүлээн авах, явуулах замыг сунгаж, боловсруулах чадварыг 20-30%-иар нэмэгдүүлэв.
- “Замын-Үүд хилийн боомтын ачааны автомашин шалган нэвтрүүлэх цогцолбор-Гаалийн рентген хяналтын талбай-Замын Үүдийн шилжүүлэн ачих III терминал” хооронд хүнд даацын 11 км урт, хатуу хучилттай авто замыг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулан ажиллаж байна.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

УИХ-ын 2015.02.18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 2.2-т заасны дагуу дэд хөтөлбөрийн хүрээнд УБТЗ ХНН-т олгосон зээлийн 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх хүлээгдэж буй үлдэгдэл 7.7 тэрбум төгрөгийг Засгийн газар шилжүүлж авах, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний ачаа эргэлтийг хурдасгахад чиглэсэн арга хэмжээг Засгийн газар тогтвортой үргэлжлүүлэх.

4.3 Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр нь дараах 3 хөтөлбөрөөс бүрдэнэ:

- ♦ “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах”
- ♦ “Гурилын үнийг тогтворжуулах”
- ♦ “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх”

“Гурилын үнийг тогтворжуулах”

“Гурилын үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг дараах зорилгоор 2012 оны 12 дугаар сараас эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр анх төлөвлөсөн.

- Гурилын жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцөлийг тогтмол хангах;
- Гурилын үйлдвэрүүд үр тарианы нөөцөө барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл авч, үйлдвэрлэлээ тогтвортой явуулах;
- Хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх юм.

“Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зорилтын дагуу эхний жилийн санхүүжилт 100 хувь Монголбанкнаас байсан бөгөөд дараа дараагийн жил 80 хувь, 60 хувийг Монголбанкнаас гаргаж үлдсэн хэсгийг гурилын үйлдвэр өөрийн санхүүжилтээр буюу агуулахад байгаа улаанбуудайн үлдэгдлээр баталгаажсан сертификатын дагуу олгогдож эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд банкнаас 37 компанид олгосон зээлийн үлдэгдэл 2013 оны эцэст 12.5 тэрбум, 2014 оны эцэст 47.0 тэрбум төгрөг байсан. Түүнчлэн, ХХААЯ-ны мэдээлж байгаагаар хөтөлбөрийн хүрээнд гурилын үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж, шинээр өндөр технологи бүхий гурилын үйлдвэр нэмэгдсэнээр Улаанбаатар хотын гурилын хэрэгцээг 100 хувь хангах чадвартай болсон. 2014-2015 оны хөтөлбөрийн санхүүжилт тохирсон эргэн төлөх хуваарийн дагуу 2015.09.01-ний өдөр бүрэн төлөгдөж дуусна.

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх”

Уг хөтөлбөрийг 2013 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн. Монголбанк болон Засгийн газар хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан санамж бичигт хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр заасан. Хөтөлбөрийн гол зорилгыг дурдвал:

- Стандартын шаардлага хангасан хүнсний зориулалттай зоорь, агуулах барих нөхцөлийг бүрдүүлэх;
- Хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх;
- Мах, сүү, хүнсний ногоо үйлдвэрлэгч, эрчимжсэн аж ахуй эрхлэгч дотоодын үйлдвэрлэгчид үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгөө барьцаалж банкнаас зээл авах замаар үйлдвэрлэлээ өргөтгөх, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш банкууд 66 аж ахуйн нэгжид 137.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгож, 2014 оны эцсийн байдлаар 132.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2015

оны эцэст 82.2 тэрбум төгрөг болж буурахаар хүлээгдэж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэх юм. Үүнд:

- Хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд энэ хугацаанд хөтөлбөрийн нөлөөгөөр 24 төслийн зоорийн багтаамж нийт 82.6 мянган тонноор нэмэгдэж байна.
- Автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан ажиллагаатай төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний зоорь, агуулах худалдааны төвүүдийг байгуулснаар:
 - о Төмс, хүнсний ногооны зоорь 64.5 мянган тонноор, мах махан бүтээгдэхүүний хөргүүртэй зоорь 15.1 мянган тонноор нэмэгдэнэ;
 - о Төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж 37 хувиар нэмэгдэж 238.1 мянган тоннд хүрнэ;
 - о Эрчимжсэн аж ахуйн нэгжийн 32 төслийн хүрээнд 2014 онд 6 мян.тн, 2015 онд 6.8 мян.тн, 2016 онд 7.7 мян.тн нойтон мах нийлүүлнэ. Энэ нь гол төлөв 2-7 дугаар сарын нойтон махны нийлүүлэлтийг 15 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй.

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл нь 2016 оны эцэст 7.6 тэрбум төгрөг болох ба 2017 оны 9 дүгээр сард бүрэн төлөгдөж дуусна.

“Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах”

Хөтөлбөр нь хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах ойрын зорилготой бөгөөд цаашид хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлийн зарчимд суурилсан байнгын тогтолцоо бүрдүүлэх хэтийн зорилготой байв.

Дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд зориулан нөөцийн махны менежер компаниуд нийт 11.5 мянган тонн махны нөөцийг 87.0 тэрбум төгрөгийн банкны хөнгөлөлттэй зээлээр бэлтгэн, худалдан борлуулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Зээлийн эх үүсвэр бүрэн төлөгдөж, нөөцийн махыг борлуулж дууссан. Хөтөлбөрийн дагуу нөөцийн мах борлуулж байсан хугацааны туршид махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өмнөх 3 жилийн дунджаас 3.1 дахин бага байжээ.

2014 оны хөтөлбөрийн хүрээнд махны нөөцийн менежер компаниуд нийт 14.6 мянган тонн нөөцийн мах бэлтгэн, сертификатаар баталгаажуулан борлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд банкууд нөөцийн менежер компаниудад нийт 77.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу хөтөлбөрийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн зээлийн 20%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 80%-ийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлэв. Нөөцийн махны худалдааг 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар махыг бүрэн борлуулж, компаниуд хуваарийн дагуу нийт зээлийг 100% банкинд, банкнаас Монголбанкнд буцаан төлжээ. Хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өнгөрсөн оноос 2.8 дахин бага, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 3 жилийн дунджаас 10.9 дахин бага байна.

2015 онд хөтөлбөрийн хүрээнд нийт санхүүжилтийн 40 хувийг нөөцийн менежер өөрийн эх үүсвэрээр бүрдүүлэх, эсвэл оролцогч банктai харилцан тохиролцсоны үндсэн дээр зах зээлийн нөхцөлөөр бүрдүүлэв. Үлдсэн 60 хувийг Монголбанкнаас оролцогч банктai зээлийн гэрээ байгуулсны үндсэн дээр, хөнгөлөлттэй хүүтэй нөхцөлөөр олгосон. Хөтөлбөрийн зээлийг махны борлуулалттай уялдуулан 2015 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн дотор эргэн төлөх бөгөөд энэ нь борлуулалтын орлого зориулалт бусаар ашиглагдахаас сэргийлэх ач холбогдолтой.

Агуулах дахь хөдлөх хөрөнгийн нөөцийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрсэн бөгөөд дунд хугацаанд санхүүжилтийн эх үүсвэрийг 100 хувь хувийн хэвшил дангаар шийдвэрлэх тогтолцоонд шилжих юм. Түүнчлэн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, махны нөөц бэлтгэл болон борлуулалтын үйл ажиллагаанд хяналтын байгууллагуудаас гадна хөтөлбөрт оролцогч банкнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

- Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээлийн 2015 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанкны тэнцэлд үлдэх 162.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Засгийн газар шилжүүлж авах;
- Цаашид схемийг Засгийн газар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ингэхдээ санхүүжилтийг хувийн хэвшилтэй 50-50% зарчмаар шийдвэрлэх;
- Зээлийн багцыг томруулах, улмаар гадаадын банк, санхүүгийн байгууллагад шилжүүлэх замаар санхүүжилтийг гадаад эх үүсвэртэй болгох;
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг батлуулах.

4.4 Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

“Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр нь барилгын материалын нийлүүлэлтийг дэмжих дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:

- Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг дэмжих;
 - Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
 - Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах (зөвхөн 2013 онд);
 - Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих;

Үүнээс “Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг 2012 оны 12 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд хэрэгжихээр Монголбанк болон Засгийн газар хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан санамж бичигт заасан. “Барилгын гол нэр төрлийн материалын үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн гол зорилгыг дурдвал:

- Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын үйлдвэрлэгч, зайлшгүй шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ыг импортлогч аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгож, дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдэд дэмжлэг үзүүлэн барилгын материалын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар үнийг тогтворжуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Барилгын гол нэр төрлийн материал үйлдвэрлэгч, импортлогчдод стандартын шаардлага хангасан бараа, материалын үлдэгдэл, үйлдвэр, тоног төхөөрөмжийг барьцаанд тооцуулан эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх.

Уг хөтөлбөрийг Монголбанк, БХБЯ-тай 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А-2/06 дугаар хамтарсан тушаалаар хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын дотоодын нийлүүлэлтийг дэмжихэд зориулж банкууд 86 компанид 264.2 тэрбум төгрөгийн зээл олгож, нийт зээлийн үлдэгдэл 2014 оны эцэст 211.7 тэрбум төгрөг байв. Дэд хөтөлбөрийн зээлийн нийт үлдэгдэл

2015 оны эцэст 148.5 тэрбум төгрөг, 2016 оны эцэст 19.7 тэрбум төгрөг болж буурахаар хүлээгдэж байна.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

- ♦ 2015 оны эхний хагасын байдлаар Монголбанкны тэнцэлд үлдэх 200.8 тэрбум төгрөгийн дэд хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг Засгийн газар шилжүүлж авах;
- ♦ Цаашид орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй байдлыг хангах зах зээлийн зөв бүтцийг бий болгох, түүнд шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх.

4.5 Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах дэд хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж

Түлш, эрчим хүчний салбарын ТӨК-иудын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, тус салбарын нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Эрчим хүчний сайдын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А-148/95 дугаар хамтарсан тушаалаар “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн гол арга хэрэгсэл нь банкуудаар дамжуулан эрчим хүчний салбарын ТӨК-иудад олгох хөнгөлөлттэй хүүтэй зээл ба хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2 жил, харин хөтөлбөрийн хүрээнд олгох санхүүжилтийн хугацаа 12 сар хүртэл байх нөхцөлтэй юм.

Тус дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний жилд олгох санхүүжилтийн хүрээнд банкууд эрчим хүчний салбарын 16 үйлдвэрт 74.9 тэрбум төгрөг, хэрэгжилтийн хоёр дахь жилд олгох санхүүжилтийн хүрээнд эрчим хүчний салбарын 9 үйлдвэрт 11.4 тэрбум, хөтөлбөрийн 2 жилийн хэрэгжилтийн туршид нийт 86.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 7 банкаар дамжуулан олгосон.

Дэд хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл 2013 оны эцэст 67.9 тэрбум төгрөг, 2014 оны эцэст 33.6 тэрбум төгрөг байсан бөгөөд 2015 оны эхний хагасын байдлаар 12.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байх төсөөлөлтэй байна. Хөтөлбөрийн зээл хуваарийн дагуу эргэж төлөгдсөөр зээлийн үлдэгдэл нь 2015 оны эцэст 0.3 тэрбум төгрөг болно. Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл 2016 оны 1 дүгээр сард бүрэн төлөгдөж дуусах хуваарьтай юм.

Хөтөлбөр хэрэгжсэнээр эрчим хүчний үнэ тариф огцом нэмэгдэх эрсдэлийг бууруулж, эрчим хүчний салбар үйлдвэрүүдийн хөрөнгө санхүүгийн дутагдалтай үед санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэн нүүрсний хуримтлагдсан өр, богино хугацаат өрийг тэр хэмжээгээр бууруулан тогтвортой байлгаж, дулааны эрчим хүч үйлдвэрлэгч үйлдвэр компанийн эрчим хүч үйлдвэрлэхэд тасралтгүй найдвартай хангах, өвөлжилтийн бэлтгэл хангах, нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэхэд ач холбогдол үзүүлээ. Хөтөлбөрийн хугацаанд ТӨК-иуд дотоод нөөц бололцоо, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зардлыг бууруулан 10.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргав.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

- 2015 оны эхний хагас жилийн байдлаар дэд хөтөлбөрийн зээлийн Монголбанкны тэнцэлд үлдэх 12.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Засгийн газар шилжүүлж авах;
- Эрчим хүчний үнэ, тарифыг нэмэгдүүлэх тохиолдолд түүний инфляцид үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан тооцох, хариу арга хэмжээ авах цаг хугацаа олгох боломжийг бүрдүүлдэг байх.

5.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт

Төв банк нь 9 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа эрхэлж байна. 2014 онд Монголбанкны нийт ажиллагсдын тоо 464 байснаас 347 ажилтан Төв аппаратад, 117 ажилтан орон нутагт ажиллаж байна.

Монголбанк хүний нөөцийг бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хүрээнд ажилтнуудын сургалтын болон гадаад албан томилолтын төлөвлөгөөг тогтмол баталж, түүний дагуу ажилтнуудыг гадаад, дотоодын хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт семинарт тогтмол хамруулж байна. 2014 онд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажилтнуудыг 242 удаагийн богино хугацааны гадаад, дотоодын сургалт, семинарт тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу хамруулсан ба 26 удирдах албан тушаалтан 50 удаагийн олон улсын хурал, уулзалтад оролцож, гадаадад албан томилолтоор ажилласан байна.

Монголбанк ажилтнуудын цалингийн шатлалыг сайжруулах, албан тушаалын ангилалд өөрчлөлт оруулах асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж, түүний мөрөөр холбогдох шийдвэрийг гарган, мөрдөж ажиллаж байна. Мөн Төрийн мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг тогтвортой, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ажилтнуудын орон сууцны асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2014 онд нийт 26 ажилтанд орон сууцны зээлийн дэмжлэгийг нийгмийн хөгжлийн сангаас олгосон болно.

Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 90 жилийн ой, Ардын хувьсгалын 93 жилийн ойн баярыг тохиолдуулан 6 ажилтан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 11 ажилтан Алтан гадас одонгоор, 13 ажилтан Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагдсан байна.

5.2 Олон нийттэй харилцах харилцаа

Монголбанкнаас олон нийттэй харилцах чиглэлээр мөнгөний бодлогын зорилго, түүнд хүрэх арга замыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, Төвбанкны бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэн инфляцийн хүлээлтэнд нөлөөлөх чадамжаа дээшлүүлж, Төвбанкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тогтмол тайлагнан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллав.

Энэхүү зорилтын хүрээнд Монголбанкнаас 2014 оны турш макро эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв байдал, Төв банкны үндсэн зорилт, бодлогын арга хэмжээ, хэрэгжилтийн үр дүн, үйл ажиллагааны ил тод байдал, төсөв мөнгөний бодлогын харилцан уялдаа зэрэг сэдвээр олон нийт, оюутан сурагчид, хэвлэл мэдээллийн байгууллагад тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулав. Үүний зэрэгцээ Монголбанкны бодлогын үйл ажиллагааны талаар ярилцлага тодруулга өгөх, олон нийтийг мэдээллээр хангах ажлыг тогтмол гүйцэтгэв. Оюутан сурагчдад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд “Монголбанкны үйл ажиллагаатай танилцах экскурс” хөтөлбөрийг үргэлжлүүлэн их дээд сургуулиудаар зочлон илтгэл уншиж, мэдээлэл өгөв.

“Мөнгөний бодлогын үндсэн чиглэл”-ийг тайлбарлах

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг УИХ, Засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд, санхүүгийн зах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд Монголбанкнаас хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, макро эдийн засаг, санхүүгийн салбар, хөгжлийн онол-бодлого, мөнгөний бодлогын хэрэгжилтийг тайлбарлан таниулах ажлыг

гүйцэтгэв. Мөн үндсэн чиглэлтэй холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үг болон удирдлагуудын ярилцлагыг томоохон сонин хэвлэлээр тогтмол нийтлэн, олон нийтийн хүртээл болгов.

Мөнгөний бодлогын шийдвэр гаргалт ба хэвлэлийн хурал

Монголбанк 2012 оны 10 дугаар сард Мөнгөний бодлогын зөвлөлийг шинээр байгуулж зөвлөл дэх хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэн, шинэ бүтэц, зохион байгуулалт, журмаар мөнгөний бодлогын саналыг гурван үе шаттайгаар, өргөн хүрээнд нухацтай хэлэлцсэний үндсэн дээр бодлогын шийдвэр гаргадаг болсон билээ. 2014 оны 2 дугаар сарын 12, 7 дугаар сарын 30-ны өдрүүдэд Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гарсантай холбоотойгоор хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Мөнгөний бодлогын мэдэгдлийг Монгол, Англи хэлээр болон хэвлэлийн хурлын тэмдэглэлийг цахим хуудсанд тухай бүр байршуулав.

Хэвлэлийн хурлын товыг Монголбанкнаас урьдчилан зарласан нь Төв банкны үйл хөдлөлийг таамаглагдахуйц болгох ач холбогдолтой төдийгүй банк, санхүүгийн захын шийдвэр гаргалтад ч мөн эергээр нөлөөлөв. Мөнгөний бодлогын асуудлаар болон цаг үеийн сэдвээр хийсэн хэвлэлийн хурлаар Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөх, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, түүний үндэслэл, шалтгаан, бодлогын хэрэгжилт, хүлээлт зэрэг сэдвээр зохих тайлбар, тодруулга өгч ажиллав.

Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүн

Монголбанкны уламжлалт хэвлэмэл бүтээгдэхүүн болох Жилийн тайлан, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан, Монголбанкны судалгааны ажил зэргийг хэвлүүлж, олон нийтэд хүргэв.

Цахим хуудсыг боловсронгуй болгох

Монголбанк өөрийн цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгоход онцгой анхаарал хандуулан ажиллав. Монголбанкны цахим хуудасны графикийн дагуу мэдээ, мэдээллийг байршуулахын зэрэгцээ тухай бүр дэд цэс, баннер, хуудсуудыг үүсгэв. Үүнд, “Хөдөө аж ахуйн салбарын санхүүжилтийн шинэ арга хэрэгслүүд” зөвлөгөөний цахим хуудас, “Мэдээллийн ил тод байдлын цэс”-ийг үүсгэн Монголбанкны мэдээллийг олон нийтэд илүү нээлттэй хүргэн ажиллалаа.

“Мөнгөний бодлогын зөвлөл, Мөнгөний бодлого” цэсийн агуулга, бүтцэд бодлогын үндсэн зорилт, арга хэлбэр, шилжих механизм, шийдвэр гаргалт зэрэг мэдээг шинээр оруулах, шинэчлэн найруулах ажлыг хийж гүйцэтгэн бодлогын шийдвэрийг тухай бүр Монголбанкны цахим хуудсанд байршуулав. Төв банкны хараат бус байдал, хариуцлага, ил тод байдлын талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэхэд анхаарч ажиллалаа.

Монголбанкнаас цахим хуудсаараа дамжуулан судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг олон нийтэд танилцуулах ажлаа үргэлжлүүлэв. Тухайлбал, “Статистикийн бюллетень”, “Арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл”, “Арилжааны банкуудын улирлын зээлийн тайлан”, “Орон нутаг дахь банкуудын тайлан”, “Мөнгөний статистикийн тойм”, “Банкуудын ипотекийн зээлийн тайлан”, “Макро эдийн засаг, санхүүгийн салбарын тойм”, “Тадаад худалдааны тойм”, “Тадаад секторын тойм”, “Орон нутаг дахь банкуудын тайлан”, “Төлбөрийн системийн тайлан”, “Хөдөлгөөнт банкны тайлан”, “Иргэд, ЖДҮ эрхлэгч ААН-д олгосон зээлийн тайлан” гэх мэт тайлан мэдээлэл, тоймыг цахим хуудсаар дамжуулж олон нийтэд тогтмол хүргэж байна.

5.3 Гадаад харилцаа

Монголбанк гадаад харилцааны бодлогын хүрээнд Монголын банк, санхүүгийн тогтолцоог хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай холбоо тогтоон гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс үр ашигтай түншлэлийг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Үүний дагуу Тайландын Төв банк, Хятадын Ардын банк, ОХУ-ын Төв банк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллалаа.

Гадаад харилцааны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тоймлон дурдвал:

- Монголбанк Хятадын Ардын банк хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн хугацааг дахин 3 жилээр сунгах гэрээнд 2014 оны 5 дугаар сард, своп хэлцлийн хэмжээг 15 тэрбум юань болгож нэмэгдүүлэх гэрээнд 2014 оны 8 дугаар сард тус тус гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү своп хэлцэл нь хоёр орны гадаад худалдааг санхүүжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжихэд чухал нөлөө үзүүлж байгаагийн зэрэгцээ Монгол Улсад 2013-2015 онд тохиолдсон төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөлөлтэй хэрэгсэл байв. Цаашид гэрээний хугацааг тогтмол сунгах бөгөөд хэлцлийн хэмжээг хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын байдалтай уялдуулан нэмэгдүүлэх асуудал нээлттэй байна.
- Монголбанкнаас ОХУ-ын Төв банктэй үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэл (төгрөг-рублийн) байгуулах саналыг тавьж, энэ чиглэлээр Төв банкны ерөнхийлөгч нарын уулзалт, ажлын хэсгийн уулзалтуудыг 2014 оны 10-12 дугаар саруудад хийж, яриа хэлэлцээрийг өргөжүүлэв. Үүний зэрэгцээ ОХУ-тай хийх гадаад худалдаанд рублийг ашиглах, Монгол Улсаас ОХУ-д хийх бараа, үйлчилгээний экспортын хэмжээг 2018 он гэхэд 1 тэрбум ам долларт хүргэх зорилт тавин хэрэгжүүлэхийг Монгол, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын ажлын төлөвлөгөөнд тусгаад байна. Хоёр орны төв банк хооронд своп хэлцэл байгуулахын тулд ОХУ-ын Засгийн газрын шийдвэр гарах шаардлагатай бөгөөд энэ асуудал хүлээгдэж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгч 2014 оны 6 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Төв банкны Ерөнхийлөгчтэй албан ёсны уулзалт хийж, хоёр орны Төв банкны хоорондын хамтын ажиллагаа, ялангуяа үндэсний валютын своп хэлцлүүд хийх боломжийн талаар харилцан санал солилцож, энэ чиглэлээр холбогдох судалгааг хийхээр тохиролцов.
- Монголбанкны Ерөнхийлөгч Япон Улсын Санхүүгийн Үйлчилгээний Агентлагийн даргатай 2014 оны 6 дугаар сард хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж, хоёр байгууллагын хооронд харилцан мэдлэг, туршлага солилцохоор тогтсон. Дэлхийн санхүүгийн зах зээлийн даяарчлалын өнөө үед энэхүү санамж бичиг нь санхүүгийн зохицуулалтын тогтолцоог сайжруулж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд цаашид тус чиглэлээр мэдлэг, туршлага солилцож ажиллахаар болсон.
- Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны жилийн уулзалтын үеэр тус банкны удирдлагуудтай хийсэн албан уулзалтаар Монголбанкны Ерөнхийлөгч уул уурхайн салбарын үйлдвэрлэл, тус салбарт орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өндөр өсөлт авчирч байсан хэдий ч, Монгол улс эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, олон тулгууртай болгох, ашигт малтмалын бус салбарыг хөгжүүлж, өрсөлдөх чадвартай, өндөр бүтээмж, технологид суурилсан, тогтвортой, экспортын чиг баримжаа бүхий хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилттой буйг онцлон тэмдэглэсэн. Энэ

хүрээнд хийгдсэн судалгааны ажил, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга механизмын талаар ЕСБХБ-ны албаны хүмүүстэй харилцан санал солилцов. Үүний сацуу ЕСБХБ болон Европ тивийн хөдөө аж ахуйн салбарт хуримтлуулсан туршлага, хөдөө аж ахуйг зээлжүүлэх, санхүүжүүлэх арга зам, хөдөө аж ахуйн технологи, ноу-хау Монгол Улсад ач тустай тул ЕСБХБ-наас зохих санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцаа авах талаар хүсэлтээ гаргасанд тус банкны удирдлага дэмжиж, энэ тал дээр хамтран ажиллахаар болов.

- Монголбанк, Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбооны Судалгаа, сургалтын төвтэй хамтран 2014 оны 9-10 дугаар сард “Банкны хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэх нь” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Хувьсан өөрчлөгдөж буй санхүүгийн зах зээл болон банкны хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын талаарх Төв банкуудын хянан шалгагч нарын мэдлэгийг дээшлүүлэн, олон улсын стандарт болон аргачлалыг түгээх зорилготой уг сургалтад Австрали, Америк, Малайз, Тайланд, Япон зэрэг 13 орны Төвбанк болон арилжааны банкууд, 34 банк, санхүүгийн байгууллагуудын төлөөлөл оролцож мэдлэг туршлагаа солилцож илтгэл хэлэлцүүлсэн.

5.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагаа

Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн бүлгийн 2007 онд Монголд хийсэн үнэлгээн дээр үндэслэн Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг (ФАТФ)-ээс манай орны МУТСТ тогтолцоог хангалтгүй хэмээн олон нийтэд зарлан саарал жагсаалтад оруулаад байсан. Санхүүгийн мэдээллийн алба болон түүний дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд саарал жагсаалтаас гарахын тулд хэрэгжүүлсэн олон арга хэмжээний дүнд ФАТФ-ын 2014 оны 6 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд Парис хотноо болсон ээлжит чуулганаар манай улсыг МУТСТ тогтолцооны стратегийн дутагдлуудаа зассан болохыг онцлон тэмдэглээд саарал жагсаалтаас гаргасан нь манай банк, санхүүгийн системийн хувьд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Монгол Улсын МУТСТ хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад ойртуулах ажлын хүрээнд:

- Эрүүгийн хууль,
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль,
- Терроризмтэй тэмцэх хууль,
- Улсын бүртгэлийн тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулсан. Түүнчлэн “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 348 дугаар тогтоолоор баталсан.

Санхүүгийн мэдээллийн алба нь дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг боловсронгуй болгох зорилгоор Азийн хөгжлийн банк (АХБ), Олон улсын валютын сан (ОУВС)-гаас техник туслалцаа авч, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах чадавхийг нэмэгдүүлэх, банк, санхүүгийн байгууллагад чиглэсэн хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлийн үнэлгээнд суурилсан хэлбэрт шилжүүлж, нөөц бололцоогоо үр дүнтэй ашиглахад чиглэсэн ажлуудыг хийж байна.

Санхүүгийн мэдээллийн алба 2014 онд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийнхээ хүрээнд банкны салбарт газар дээрх хяналт шалгалтыг хийлээ. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллаж, шаардлагатай мэдээлэл, туршлагаа солилцон ажиллаж байна.

Хүснэгт 21. МУТСТ чиглэлээр хийсэн хяналт шалгалт

Үзүүлэлт	2014 он
Банкинд хийсэн хяналт шалгалт	10
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	151
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан акт	152
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар	295

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба МУТСТ тухай шинэчлэн батлагдсан хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс холбогдох тайлангуудыг хүлээн авч ажиллаж байна.

Хүснэгт 22. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн ирүүлсэн тайлангийн тоо

Үзүүлэлт	2014 он
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан	1,962,408
Сэжигтэй гүйлгээний тайлан	212
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан	149,682
Гаалийн мэдүүлгийн тайлан	2347

Эх сурвалж: Монголбанк, СМА

2014 онд нийт 212 сэжигтэй гүйлгээний тайлан, өссөн дүнгээрээ нийт 813 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан байна. Үүнийг өнгөрсөн 2013 онтой харьцуулбал сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 25%-иар буурсан үзүүлэлттэй байна. Харин бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн нийт тоог 2013 онтой харьцуулбал ойролцоогоор 2.5 дахин өссөн дүнтэй байна.

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны гол хэсэг бол ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад дүн шинжилгээ хийж, мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй байх тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах үйл ажиллагаа юм. Тайлант хугацаанд Монголбанкны СМА нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, бусад гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагуудтай санхүүгийн мэдээлэл солилцох үр ашигтай суваг, харилцааг бий болгож ажилласан.

Хүснэгт 23. СМА-ны санхүүгийн мэдээлэл солилцсон статистик

Үзүүлэлт	2014 он
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тайлан	275
СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн мэдээлэл	6
Мэдээлэл авах зорилгоор дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд хүргүүлсэн хүсэлт	634
Дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд хүргүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу	631


Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба нь хуулийн дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл сурталчилгаа явуулах үүрэгтэй учир тайлант хугацаанд дангаараа болон бусад байгууллагатай хамтран сургалтуудыг тогтмол зохион байгуулсан.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2014 онд нийт 598 оролцогчдыг хамарсан 14 сургалт, семинар зохион байгуулсан байна. Үүнээс 4 сургалтыг СМА дангаараа, 164 оролцогчдыг хамруулж хийсэн бол бусад байгууллагатай хамтран 428 оролцогчдыг хамарсан 10 удаагийн сургалт зохион байгуулжээ. Тус сургалтууд нь:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах;
- Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний стратегийг боловсруулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тогтолцоог танилцуулах;
- Олон улсын стандартыг танилцуулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд батлагдсан хууль, журам, зааврыг тайлбарлан танилцуулах зэрэг сэдвүүдийг хамарсан байна.

Зураг 61. СМА-наас МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд хийсэн сургалт



Эх сурвалж: Монголбанк, СМА

Гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, сэжиглэхтэй холбоотой дэлхийн санхүүгийн мэдээллийн албадын холбоо Эгмонт бүлгийн гишүүний хувьд Монголбанк дахь СМА нь бусад орны санхүүгийн мэдээллийн албадтай Монгол Улсаас гадаад руу гарсан, эсвэл гадаад орноос Монгол Улсад орж ирсэн хууль бус мөнгөний урсгалыг олж илрүүлэх хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан болно.

5.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (ДХҮАЭГ) нь чиг үүргийнхээ дагуу Монголбанкны бүтцийн нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авах, үүрэг даалгавар өгөх, удирдлагыг мэдээллээр хангах, зайны хяналт хийх, үйл ажиллагааны эрсдэлийн талаар Монголбанкны ажиллагсдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах, үйл ажиллагааны эрсдэлийн талаар баримтлах бодлого, журмын төсөл боловсруулах, Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Тайлант онд Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбарын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын үнэлгээ, дүгнэлтийг илүү бодитой, оновчтой болгох зорилгоор холбогдох дүрэм, журмыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласны зэрэгцээ дотоод хяналт шалгалттай холбогдолтой бусад журам, зааварт өөрчлөлт орууллаа.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд тайлант хугацаанд газар дээрх иж бүрэн шалгалтыг Монголбанкны 9 газар, хэлтэс, алба, орон нутаг дахь 17 хэлтэс, салбарыг бүрэн хамруулан хийж, газар дээрх шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлд цаг хугацаанд нь тайлагнан ажиллалаа. Үүнээс гадна татан буугдсан банкууд дахь Банкны эрх хүлээн авагчийн зөвлөлийн үйл ажиллагааг шалгах, газар, хэлтэс, албаны зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн болон явцын шалгалт хийх, орон нутаг дахь хэлтэс, салбарын бэлтгэл сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг өндөржүүлэх зорилгоор нийт 10 удаа төлөвлөгөөт бус, гэнэтийн, хэсэгчилсэн шалгалтуудыг хийж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан болно.

ДХҮАЭГ-ын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг илүү боловсронгуй болгох, үйл ажиллагааны үе шат бүрт анхан шатны болон дараалсан хяналтыг тогтмол, тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэлэг арга барил, хэлбэрээр ажиллах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

5.6 Бэлэн мөнгөний хангалт

Монголбанкнаас 2014 онд мөнгөн тэмдэгттэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэв.

Зуутын дэвсгэртийг Франц улсын Обертур Федюшир компани, 1-т, 5-т, 10-т болон 20-тын дэвсгэртүүдийг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Де Ла Рие компани, 10000-тын дэвсгэртийг ХБНГУ-ын Гийзеке Девриент компаниар тус тус хэвлүүлж, нөөц бүрдүүлсэн.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 810.2 тэрбум төгрөг байгаа нь 2013 оны эцэстэй харьцуулахад 32.1 тэрбум төгрөгөөр буюу 3.8%-иар буурсан байна. Оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх 2013 онтой харьцуулахад дэвсгэртийн тоогоор 13.9 сая ширхэгээр буюу 4.4%-иар өссөн байна. Энэхүү өсөлт нь 10-т, 20-т, 50-т болон 100-тын буюу жижиг дэвсгэртүүд өссөнтэй холбоотой байв.

Хүснэгт 24. Бэлэн мөнгөний хангалтын үзүүлэлтүүд

№	Дэвсгэр-түүд	2013 оны эцсийн үлдэгдэл				2014 оны эцсийн үлдэгдэл			
		сая төгрөг	Хувь	Мянган ширхэг	Хувь	сая төгрөг	Хувь	Мянган ширхэг	Хувь
1	1	29	0.0%	29,264	9.3%	30	0.0%	29,716	9.0%
2	5	131	0.0%	26,237	8.3%	133	0.0%	26,699	8.1%
3	10	571	0.1%	57,064	18.1%	623	0.1%	62,307	18.9%
4	20	880	0.1%	43,999	13.9%	966	0.1%	48,284	14.6%
5	50	1,843	0.2%	36,858	11.7%	2,016	0.2%	40,317	12.2%
6	100	3,745	0.4%	37,447	11.9%	3,963	0.5%	39,636	12.9%
7	200	34	0.0%	169	0.1%	34	0.0%	172	0.1%
8	500	5,661	0.7%	11,321	3.6%	5,078	0.7%	11,956	3.6%
9	1000	14,263	1.7%	14,262	4.5%	14,756	1.8%	14,755	4.5%
10	5000	53,975	6.4%	10,794	3.4%	50,003	6.2%	10,000	3.0%
11	10000	207,230	24.6%	20,723	6.6%	187,416	23.1%	18,741	5.7%
12	20000	553,908	65.8%	27,695	8.8%	544,274	67.2%	27,213	8.3%
	Дүн	842,269	100.0%	315,840	100%	810,192	100.0%	329,803	100%

Хүснэгт 25. Банкуудаас хүлээн авсан, банкинд олгосон бэлэн мөнгөний тоо, үнийн дүн

Он	Банкинд олгосон		Банкуудаас хүлээн авсан	
	Нийт дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг	Нийт дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг
2010	827.9	131,954	862.5	123,713
2011	1246.4	181,258	1310.6	170,460
2012	1564.2	213,305	1663.4	198,521
2013	1601.6	216,394	1728.7	202,035
2014	1377.6	143,936	1536.1	176,422
Дүн	6,617.7	886,847	7,101.3	871,151

Тайлант онд Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбаруудад 252.0 тэрбум төгрөгийн зузаатгал хүргүүлж, 33.3 тэрбум төгрөгийн муудсан мөнгөн тэмдэгтийг төвд татан авсан.

5.7 Мэдээллийн технологи

Монголбанк нь тайлант онд банк хоорондын төлбөр тооцооны болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Засгийн газрын үнэт цаасны арилжааны програм, Төв банкны үнэт цаасны арилжааны програм болон банк хоорондын захын програмын бусад модулыг боловсронгуй болгох ажлууд хийгдлээ. Мөн банкуудаас авах цахим тайлангийн систем шинээр боловсруулж, эхний хэсгийг ашиглалтад оруулаад байна.

Түүнчлэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдах шинэ програмууд боловсруулах, ашиглаж буй мэдээллийн системүүдийг өргөтгөх, сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдийн тасралтгүй ажиллагааг хангах, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс үүлэн тооцооллын технологийг судалж, эхний үе шатыг хэрэгжүүллээ.

5.8 Монголбанкнаас 2014 онд хэрэгжүүлсэн бодлого, техникийн арга хэмжээний хураангуй

№	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1.	2014.01.17	А-14	Урт хугацаат своп хэлцлийн журам	Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгохын тулд банкууд урт хугацаат гадаад эх үүсвэрээр Монголбанктай своп хэлцэл байгуулах үйл ажиллагаанд баримтлах зарчим, талуудын эрх, үүрэг, бусад харилцааг зохицуулахаар журамлав.

2.	2014.01.29	A-19	Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам	Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаатай холбогдсон Монголбанкны харилцааг зохицуулахаар журамлав.
3.	2014.02.12	2014/01	Мөнгөний бодлогын шийдвэрийн тухай	Бодлогын хүүг 10.5 хувьд хэвээр үлдээх, Олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх.
4.	2014.3.24	A-54/59	Гаалийн тооцоонд мөрдөх ханшийн тухай	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар гаалийн тооцоонд хэрэглэх төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тухайн барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар тооцож байхаар зохицуулав.
5.	2014.4.30	A-69/36/87	Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ	Монголбанкны Ерөнхийлөгч, Эдийн засгийн хөгжлийн сайд, Уул уурхайн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр алтны олборлолт, Монголбанкинд тушаагдах алтны хэмжээ нэмэгдэх, Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэх ач холбогдолтой.
6.	2014.5.5	A-77	Санхүүгийн мэдээллийн албанд банкнаас мэдээлэл хүргүүлэх журам	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт буюу банкнаас сэжигтэй гүйлгээ, 20.0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгө, гадаад төлбөр тооцооны гүйлгээний талаар Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд (СМА)-мэдээлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалахтай холбоотой СМА, банк, түүний удирдлага, ажилтнуудын үйл ажиллагааны харилцааг зохицуулах, мөн хуулийн 7, 9 дүгээр зүйлийн холбогдох заалтыг тус тус хэрэгжүүлэхээр зохицуулав.
7.	2014.5.27	A-83/02	Хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Монголбанкны Ерөнхийлөгч, Нийгмийн хамгааллын сайд бөгөөд нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын хамтарсан шийдвэрээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хуримтлалын сангаас 2014 онд арилжааны банкинд харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 640.0 (зургаан зуун дөчин) тэрбум байхаар шинэчлэн тогтоов.
8.	2014.6.27	A-101	Төлбөрийн системийн хяналтын бодлого	Үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай, тасралтгүй ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах замаар санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр зохицуулав.

9.	2014.7.3	A-106/85	Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар Санхүүгийн зохицуулах хорооноос кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох, уг үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг тогтоох болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулав.
10.	2014.7.3	A-107	Мөнгөн тэмдэгтийг тусгай зориулалтаар худалдах, худалдан авах тухай журам	Монголбанкны нөөцөд байгаа Монгол улсад 1993 оноос өмнө гүйлгээнд байсан (гүйлгээнээс хасагдсан) мөнгөн тэмдэгт болох цаасан дэвсгэрт, тэдгээрийн загвар болон дурсгалын зориулалтаар үйлдвэрлэсэн цаасан дэвсгэртийг иргэн, хуулийн этгээдэд худалдах, тэдгээрээс худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулав.
11.	2014.7.18	A-111	Монголбанкны Улсын байцаагчийн дүрэм	Монголбанкны Улсын байцаагчийн эрх зүйн байдал, түүний үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, Улсын байцаагч банк, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Монголбанкны гаргасан дүрэм журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг банк, хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах ажилтан хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулав.
12.	2014.7.18	A-113	Монголбанкны Улсын байцаагчийн зөвлөлийн ажиллах журам	Монголбанкны Улсын байцаагчийн зөвлөлийн эрх зүйн байдлыг тодорхойлж, Монголбанкны Улсын байцаагчид эрх олгох, эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, улсын байцаагчдаас шалгалт авах, улсын байцаагчийн тогтоосон акт, мэдээлэл, шийтгэврийн талаар ирүүлсэн тайлбар, санал, гомдлыг хэлэлцэн шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулав.
13.	2014.7.21	A-116	Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн 22 дугаар зүйлд заасны дагуу Хамтын ажиллагааны зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулав.
14.	2014.7.28	A-119/ A/132	Монголбанк, Гаалийн ерөнхий газрын хамтран ажиллах журам	Монголбанкны Ерөнхийлөгч, Гаалийн Ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар Монголбанк, Гаалийн ерөнхий газрын хоорондын гадаад худалдаа, валютын урсгал, ханшийн талаарх мэдээлэл солилцоог тогтмолжуулах, Монгол Улсын гааль дээр хураагдсан үнэт зүйлсийг Монгол Улсын Эрдэнэсийн санд хүлээн авах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулав.

15.	2014.7.31	A-127	Төв банкны Бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Төлбөрийн тэнцэлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12.0 хувь болгох.
16.	2014.8.6	A-129/171	Хадгаламжийн даатгалын корпорацийн ажилтны ёс зүйн дүрэм	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Хадгаламжийн даатгалын тухай хуулиар тодорхойлсон зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжийг биелүүлэх үйл ажиллагаанд баримтлах Хадгаламжийн даатгалын корпорацийн ажилтны ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулав.
17.	2014.8.29	A-137/67/187/232	Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр	Монголбанкны Ерөнхийлөгч, Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, банкуудын үйл ажиллагаанд шударга, зохистой байдлыг хангуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг сайжруулах дунд хугацааны хөтөлбөрийг батлав.
18.	2014.9.30	A-151	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам	Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг банкны хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашигт нийцүүлэх, улмаар банкны зохистой засаглалын тогтолцоог боловсронгуй болгохоор зохицуулав.
19.	2014.11.7	A-177	Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги	2014-2019 оныг хамрах энэхүү баримт бичгийг банкны салбарт Монголбанкнаас хийгдэх, зохицуулалтын орчинд түгээмэл тохиолдож буй өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хяналт шалгалтын талаарх тэргүүний туршлага, шалгарсан арга, техникийг Монголын банкны салбарын онцлогт тохируулан нэвтрүүлэх зорилготойгоор боловсруулав.

20.	2014.11.14	A-182	Гадаад валютын дуудлага худалдааны журам, Гадаад валютын дуудлага худалдааны заавар	Дотоодын банк хоорондын гадаад валютын захад Монголбанкнаас оролцох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах замаар гадаад валютын дотоод захын үр ашгийг нэмэгдүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг зах зээлийн зарчмаар тодорхойлох зорилгоор Монголбанкнаас зохион байгуулах гадаад валютын дуудлага худалдаанд баримтлах зарчим, талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон журамлав. Энэхүү заавраар “Гадаад валютын дуудлага худалдааны журам”-ын дагуу гадаад валютын дуудлага худалдааг Монголбанкнаас зохион байгуулах зарчим, шийдвэр гаргах үйл явц, арилжаанд оролцогч этгээд, нэгж тус бүрт тавигдах шаардлага, тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны дарааллыг тодорхойлох, түүнд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх замаар үйл ажиллагааны болон гүйлгээний эрсдэлээс хамгаалах зорилгоор зохицуулав.
21.	2014.12.17	A-199	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар	Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан “Банкны зөвшөөрлийн журам”-ын дагуу Банкны зөвшөөрлийн гэрчилгээний загварыг батлав.
22.	2014.12.24	A-204	Хөдөлгөөнт банкны журам	Хөдөлгөөнт банкны үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, оролцогчийн эрх, үүрэг, нууцлал, аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй байдлыг хангах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулан журамлав.
23.	2014.12.25	A-206/ A/277	Азийн хөгжлийн банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд эргэн төлөгдсөн эх үүсвэрээс зээл олгох журам	Монголбанкны Ерөнхийлөгч, Хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлсэн “Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн эргэн төлөгдсөн хөрөнгийн эх үүсвэрийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлөөр иргэд, хуулийн этгээдэд зээл олгох, оролцогч байгууллагуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн ажлын уялдаа холбоог хангах, зээлийн хөрөнгийг оновчтой хуваарилж, үр дүнтэй ашиглахаар журамлав.

МОНГОЛБАНК (Төв банк)

**Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2014 оны 12 дугаар сарын 31**

МОНГОЛБАНК

2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

МОНГОЛБАНК

БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

АЛБАН ХАЯГ:

Монголбанкны байр
Бага тойруу- 3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛ:

Н.Золжаргал (Монголбанкны Ерөнхийлөгч)
Б.Жавхлан (Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч)
Э.Батшугар (Монголбанкны Дэд ерөнхийлөгч)
Д.Чимэд-Юндэн
(Тамгын газрын захирал)
Х.Дэлгэр
(Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын захирал)
Д.Болдбаатар
(Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал)
Д.Дэлгэрсайхан
(Валют, эдийн засгийн газрын захирал)
Д.Ганбат
(Хяналт, шалгалтын газрын захирал)
М.Амгалан
(Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал)
П.Сүхбаатар
(Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын захирал)
Г.Эрдэнэбаяр
(Хууль, эрх зүйн газрын захирал)
Д.Довчинбазар
(Мэдээллийн технологийн газрын захирал)
Н.Батсайхан
(Эрсдэлийн удирдлагын албаны захирал)
С.Болд
(Монголбанкны Ерөнхий эдийн засагч)

АУДИТОРУУД:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

МОНГОЛБАНК

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын зөвлөлийн үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын зөвлөл нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын зөвлөлийн үүрэг байдаг.

Энэхүү санхүүгийн тайланг (5-97 дугаар хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын зөвлөл үзэж байна.

Захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:

Н.ЗОЛЖАРГАЛ

(Монголбанкны Ерөнхийлөгч)

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2015 оны 5 дугаар сарын 01



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Бид Монголбанкны (“Банк”) 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь удирдлагын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа “Аудитын олон улсын стандарт”-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

